

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Нийслэлийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан
мэргэжилтэн, албан хаагчдад зориулсан гарын авлага

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт.....	4
Хүснэгтийн жагсаалт.....	5
ЗурГИЙН жагсаалт	6
Бүлэг 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	7
1.1 Хөрөнгө оруулалтын үндсэн ойлголт	7
1.2 Нийслэлийн хөрөнгө оруулалтанд анхаарах зарим зүйлс.....	10
Бүлэг 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХЗҮЙН ОРЧИН.....	13
2.1 Хөрөнгө оруулалтын эрхзүйн орчин.....	13
2.2 Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд.....	18
2.3 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын эрхзүйн орчин.....	20
2.4 Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн төлөвлөлт, тэдгээрийн ялгаа.....	24
2.5 Жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлт.....	28
Бүлэг 3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ	30
3.1 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн эрх зүйн орчин	30
3.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатууд.....	34
3.3 Орон нутгийн төсөв төлөвлөх, батлах үйл явц	40
3.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлттэй холбоотой журмуудын хэрэглээ	44
Бүлэг 4. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ	57
4.1 Гадаад зээл, тусламжийн төслүүдийн онцлог	57
4.2 Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт...	59
Бүлэг 5. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ	62
5.1 ТХХТ-ийн төслийн эрхзүйн орчин.....	62
5.2 Төрийн өмчийн концессын төслийн төлөвлөлт	63
5.3 Орон нутгийн концессын зүйлийн төлөвлөлт	64
Бүлэг 6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ	68
6.1 Төслийн хэрэгжилтийн үе шат.....	68
6.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үе шатууд.....	80
6.3 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	93
Бүлэг 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛТ	96
7.1 Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх.....	96
7.2 Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилт.....	113

7.3	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн санхүүжилт.....	115
Бүлэг 8.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН АУДИТЫН ХЯНАЛТ, ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА	119
8.1	Хөндлөнгийн хяналт, аудитын шалгалт.....	119
8.2	Хөрөнгийн удирдлага	122
Бүлэг 9.	НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	133

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖББ	Жишиг баримт бичиг
ЖМТ	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОУВС	Олон улсын валютын сан
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБХТ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилгууд	21
Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн төлөвлөлтийн гол ялгаа, үе шат	25
Хүснэгт 3. Төсвийн хөрөнгө оруулалтын ангилал	31
Хүснэгт 4. Хөрөнгийн зардлын зориулалтын ангилал.....	33
Хүснэгт 5. Хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн ангилал.....	33
Хүснэгт 6. Хөрөнгө оруулалтын эдийн засгийн ангилалын тусгай шаардлагууд.....	37
Хүснэгт 7. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төслүүдийн төлөвлөлтийн үе шатанд оролцогч талууд, тэдгээрийн оролцоо	39
Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар	42
Хүснэгт 9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны цаглабар.....	47
Хүснэгт 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, онооны систем.....	48
Хүснэгт 11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалуудын ашиглалт.....	49
Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд оролцогч талуудын чиг үүрэг	54
Хүснэгт 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалуудын ашиглалт.....	55
Хүснэгт 14. Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг	70
Хүснэгт 15. Худалдан авах ажиллагааны босго үнэ болон дээд хязгаарын харьцуулалт	76
Хүснэгт 16. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад зарцуулж буй хугацаа	79
Хүснэгт 17. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үе шат.....	80
Хүснэгт 18. ХАА-ны төрөлд хэрэглэх тендерийн жишиг баримт бичгүүд	85
Хүснэгт 19. Тендерийг хянан үзэх, үнэлэхэд ашиглах тендерийн үнэлгээний заавар.....	86
Хүснэгт 20. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл	89
Хүснэгт 21. Гэрээний бүтэц, бараа худалдан авах гэрээний жишээ.....	89
Хүснэгт 22. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний ХАА-ны оролцогч талуудын үүрэг	90
Хүснэгт 23. УТХО-ын барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт авахад бүрдүүлэх материал.....	98
Хүснэгт 24. ЗГ-ын 160 дугаар тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтын тайлбар, хэрэгжилт	100
Хүснэгт 25. Аудит хийхэд оролцогч талуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацаа.....	120
Хүснэгт 26. Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой дүрэм, журмын тайлбарууд.....	123
Хүснэгт 27. Төрийн өмчийн харилцааны субъектүүдийн эрх.....	124
Хүснэгт 28. Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах санал, зөвлөмж, хэрэгжүүлэх арга зам, хариуцах эзэн.....	136

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь /2013-2020 он/, тэрбум ₮	9
Зураг 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа	14
Зураг 3. Улс, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний цагалбар	23
Зураг 4. Нэгдсэн төсөвт эзлэх нийт хөрөнгийн зардал, сая төгрөг	24
Зураг 5. Хөтөлбөрт төсвийн төлөвлөлтийн логик гинжин хэлхээ	29
Зураг 6. Улсын төсөв боловсруулах, батлах цаглабар	35
Зураг 7. Төслийг үнэлж, эрэмбэлэх журам, аргачлал	45
Зураг 8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны үе шат	46
Зураг 9. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалын тайлбар схем	47
Зураг 10. Төслийг дахин үнэлэх Аргачлал 1-ийн үйл ажиллагааны зураглал	51
Зураг 11. Төслийг үнэлэх Аргачлал 2-ын оролцогч талууд, цаг хугацааны зураглал	52
Зураг 12. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээний зураглал	53
Зураг 13. Гадаад зээл, тусламжийн батлагдсан дүн /тэрбум ₮/	57
Зураг 14. Төслийн зээлийн ашиглалт, салбараар (2005-2019), тэрбум ₮	58
Зураг 15. Төрийн өмчийн концессын төслийн төлөвлөлт	64
Зураг 16. Орон нутгийн өмчийн концессын төслийн төлөвлөлт	65
Зураг 17. Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үе шат	68
Зураг 18. Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын тодорхойлолт	71
Зураг 19. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавих шаардлага	71
Зураг 20. Төсвийн төлөвлөлттэй уялдуулан ХАА-г зохион байгуулах цаглабар	74
Зураг 21. Худалдан авах ажиллагааны арга	75
Зураг 22. Босго үнийн харьцуулалт, худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулах шаардлага	76
Зураг 23. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үе шат	79
Зураг 24. Нээлттэй (нэг үе шаттай) тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар худалдан авалт зохион байгуулах	83
Зураг 25. Гомдол гаргахүйл ажиллагааны зураглал	91
Зураг 26. Худалдан авах ажиллагааг тайлагнах үе шат	93
Зураг 27. Улсын төсвийн санхүүжилтийн ерөнхий схем	96
Зураг 28. Нийслэлийн төсвийн санхүүжилтийн ерөнхий схем	97
Зураг 29. “Барих-Шилжүүлэх” төрлийн концессын гэрээний эргэн төлөлт /тэрбум ₮/	116
Зураг 30. Төрийн санхүүгийн тайлангийн аудитын цаглабар	120

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1.1 Хөрөнгө оруулалтын үндсэн ойлголт

“Хөрөнгө оруулалт” гэдэг нь ямар нэгэн хөрөнгийг ирээдүйд үр ашгаа өгөх хэлбэрт шилжүүлж, хөрөнгө оруулснаараа өгөөж авах зорилготой бэлэн мөнгө, хувьцаа, бонд, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөнд байршуулах үйл ажиллагаа юм. Харин энэхүү гарын авлагын хүрээнд нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалт буюу улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид “ТХХТ” гэх), концессын хүрээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтын талаар нарийвчилсан, цэгцтэй, ойлголт өгөхийг зорилоо.

Эдийн засгийн онолоор тухайн улсын жилдээ үйлдвэрлэсэн нийт баялагийг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) зардлын ангиллаар тооцоолоход нэг бүрэлдэхүүн нь “хөрөнгө оруулалт” байдаг тул хөрөнгө оруулалт нь эдийн засгийн хөгжлийн нэг гол хүчин зүйл болдгийг илтгэнэ. Хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр үр өгөөжтэй төслүүдэд хөрөнгө оруулахын хэрээр үйлдвэрлэл нэмэгдэж, ДНБ өсөн улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг тул хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт харилцан эерэг хамааралтай юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад бий болсон төсөв, санхүүгийн хүндрэл, “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт буурсан ч мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа тусгайлан хөрөнгө оруулалтыг бууруулахгүй байж хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зогсоохгүйгээр аль болох түргэн хугацаанд эдийн засгийг сэргээх Шинэ Сэргэлтийн бодлого, холбогдох томоохон хөрөнгө оруулалтыг хийхээр төрөөс төлөвлөн ажиллаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын удирдлагын хүрээнд төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тайлагнах үе шаттайгаар хэрэгждэг. Иймд хөрөнгө оруулалтын удирдлагын энэ бүх шатанд тодорхой хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд тулгарч ирсэн бөгөөд үүнийг үе шаттай, дэс дараалалтайгаар шийдвэрлэхийн тулд УИХ, Засгийн газар, Сангийн яам зэргээс холбогдох хууль, тогтоол, шийдвэрийг баталж, сайжруулах чиглэлээр ажиллаж ирсэн билээ.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар манай улсад төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд дараах хүчин зүйлсийг засаж сайжруулах хэрэгтэй хэмээн зөвлөжээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төслийн сонголт муу, түүний дотор үр ашиггүй, үрэлгэн төслүүд их;
- Төслүүдийн зураг төсөл, гүйцэтгэлийн ажил цаг хугацаандаа хэрэгжихгүй удаашрах;
- Худалдан авах ажиллагаанд үүсдэг авилга;
- Бүрэн бус төслүүд;

- Хөрөнгийг үр дүнтэй ашиглаж, арчлах зэрэг хөрөнгийн удирдлагыг оновчтой хийж чаддаггүйгээс баригдсан байгууламжаас хүртэж буй өгөөж буурч, ашиглалтын хугацаа нь багасдаг;
- Төслийн сонгон шалгаруулалт, төлөвлөлтийг муу хийснээр хэрэгжилтийн явцад хүндрэл үүсдэг.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг бэхжүүлснээр дараах гурван чиглэлд эерэг үр дүн гарна гэж үздэг¹.

1. *Урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт хэрэгжинэ.* Үүнд тухайн улс орон, салбарын 8-10 жилийн бодлого, мастер төлөвлөгөө, тэдгээрт нийцүүлэн гаргасан 4-5 жилийн хөтөлбөр, төлөвлөгөө болон 3 хүртэлх жилийн төлөвлөгөө, тэдгээрт тусгагдсан зорилтуудыг хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд хангана.
2. *Төрийн төсөв, санхүүгийн удирдлагын хэрэгжилт хангагдана.* Төсвийн санхүүгийн нэгдмэл хариуцлага, нөөцийн оновчтой хуваарилалт, төрийн үр ашигтай үйлчилгээний зорилтыг хангана гэж үздэг.
3. *Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн хангагдана.* Хөрөнгө оруулалтын удирдлагын зөв тогтолцоо нь нэгж төслийн хөрөнгө оруулалтын бүтээмж, үр өгөөжийг өсгөх замаар гүйцэтгэлийг сайжруулдаг.

ОУВС-ийн судалгаанаас харахад хөгжиж буй орнууд ДНБ-нийхээ 1 хувьтай тэнцэх хэмжээний улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хийснээр ДНБ нь урт хугацаанд 1-ээс дээш хувийн өгөөжийн өсөлтийг бий болгодог байна. Манай улсын хувьд ДНБ-д эзлэх улсын төсвийн хөрөнгө оруулалт дундажаар 3% орчим байсан ба 2020 онд 5.3 хувь байжээ.

¹ *Public Investment Management Handbook for Capacity Development, JICA 2018*

Зураг 1. Төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь /2013-2020 он/, тэрбум ₮



Эх сурвалж: Сангийн яам

2021 онд нийт 1.4 их наяд төгрөгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь ДНБ-ий 3.3 хувьтай тэнцэж байв. Харин 2022 онд батлагдсан төсвийн хөрөнгө оруулалт түүхэндээ байгаагүй хамгийн өндөр буюу 2.2 их наяд төгрөгт хүрсэн.

Иймд цаашид өсөн нэмэгдэж байгаа төсвийн хөрөнгө оруулалтыг илүү үр өгөөжтэй, улс төрөөс хараат бус, хөгжилд чиглүүлсэн хөрөнгө оруулалт болгоход анхаарах шаардлагатай байна. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь улсын урт хугацааны хөгжил, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, улс орны тэргүүлэх чиглэлд нөөцийн хувиарлалтыг оновчтой хийж, зардлын хувьд үр ашигтай, хэмнэлттэй байх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг байх ёстой. Энэ хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Өмнө нь Монгол Улсад төсвийн хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрээс төсөл, арга хэмжээний санхүүжилт хийж байсан бөгөөд эдгээрийн нэлээдгүй нь төсвөөс гадуурх хэлбэрээр олгогдож байсан тул зарим хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийг хянах, тайлагнах боломжгүй байдлыг үүсгэж байсан. Гэвч 2017 оноос эхлэн төсвийн сахилга батыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашиг, оновчтой удирдлага, тогтолцоог бий болгох хүрээнд ОУВС болон Дэлхийн банкнаас өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу Төсвөөс гадуурх ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтуудыг бүрэн зогсоож, нэгдсэн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг УИХ, Засгийн газраас үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн юм.

Түүнчлэн, олон улсын жишигт байдаггүй концессын хэлбэр болох "Барих-Шилжүүлэх" төрөл /үндсэндээ өндөр хүүгийн төлбөр, менежментийн зардалтай төсөл/-ийн төслүүдийг олноор байгуулж, эргээд төсвөөс буцаан төлөх нэмэлт зардлыг нэмэгдүүлж байсныг зогсоож, цаашид нэмж "Барих-Шилжүүлэх" төрлийн концессын гэрээ байгуулахыг УИХ-аас хориглосон зэргийг дурдаж болно.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах, үр ашигтай, оновчтой хөрөнгө оруулалт хийх чиглэлд 2018-2019 онуудад түлхүү анхаарч, Засгийн газрын тогтоолоор холбогдох аргачлалын журмыг батлан мөрдөж байна. Уг журмын талаар Улсын төсвийн төлөвлөлт хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно. Харин концессын төслүүдийн төлөвлөлтийн асуудал, хэрэгжилт, санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэх зорилгоор ТХХТ-ийн тухай хуулийн төслийг Сангийн яамнаас боловсруулан УИХ-аар батлуулах ажил эхлээд байна.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хувьд Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 204 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн жилийн төсөв батлах маягт”-ыг баталж өгснөөс өөрөөр сүүлийн жилүүдэд нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэлтийн асуудал орхигдож ирсэн.

Иймд энэхүү гарын авлага нь нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үе шатуудыг сайжруулахад туслах зорилготойгоос гадна улс, нийслэлийн төсвийн хязгаарлагдмал нөөцөөр хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгийн эх үүсвэрийг зөв хуваарилах, төслүүдийг оновчтой сонгох, үр дүнг тодорхойлох явцад нь хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдэд аргазүйн тусалалцаа үзүүлэхийг зорив. Түүнчлэн хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдийн хувьд анхаарах гол зүйлсийг танилцуулж, холбогдох хууль, журмын талаарх үндсэн ойлголтыг өгөх, хууль, журмын зүйл, заалтыг хэрэгжүүлэхэд туслах жишээ, бодит хэрэглээг таниулахад чиглэв.

Тус гарын авлага нь Нийслэлийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан боловсруулагдсан тул Нийслэлийн төсвөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд анхаарах асуудлыг товч авч үзье.

1.2 Нийслэлийн хөрөнгө оруулалтанд анхаарах зарим зүйлс

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн орчинд улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн баримт бичиг мөн адил үйлчилдэг. Үүний зэрэгцээ нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төрөөс баримталж буй бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дунд, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төслийг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана. Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрүүлж авч үзнэ.

Дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулахаас гадна дараах шаардлагыг хангасан төслийг Нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

- Тухайн санхүүгийн жилд шинээр баригдах барилга, байгууламжийн зураг, төсвийг экспертизээр батлуулсан байх,
- Барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудал бүрэн шийдэгдсэн байх,

- Техник эдийн засгийн тооцоогоор үр ашигтай нь нотлогдсон байх зэрэг барилгын ажил эхлүүлэх гол нөхцөлийг хангасан байх,
- Урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байх,
- Их засварын ажлын хувьд тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэх зэрэг болно.

Дээрх шаардлагыг хангасан байдал, магадлалаар батлагдсан зураг төсөв, газрын гэрчилгээ, техникийн нөхцөлийг хавсаргаж хүсэлтээ холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх шаардлагатай.

Түүнчлэн тухайн жилийн хөрөнгө оруулалтын боломж, Нийслэлийн төсвийн орлого бүрдэлттэй уялдуулан дараах зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй. Үүнд:

- Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд **Монголын талын хүлээсэн хөрөнгө, үүргийг ханган биелүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэн тэргүүнд шийдвэрлэх,**
- Өмнөх онуудад хэрэгжүүлж эхэлсэн **он дамжин шилжих төсөл, арга хэмжээг нэн тэргүүнд дуусгах,**
- Захиалагч байгууллагын баримт бичиг иж бүрэн, шаардлага, тооцоог хийсэн, батлагдсан маягтын дагуу шаардлагатай бүх материалыг боловсруулж, хавсаргасан, заасан мэдээллийг хугацаанд ирүүлсэн, **үр ашигтай, нэн шаардлагатай шинэ төсөл арга хэмжээг эхлүүлэх** зэрэг болно.

Жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр **дундажаар 2-2.2 их наядын орчим төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг** ирүүлдэг боловч дөнгөж 15.7-17 хувь /340-370 тэрбум төгрөгийн/ нь л хөрөнгө оруулалт хэлбэрээр Улс, нийслэлийн төсөвт багтан батлагдаж, хэрэгжсэн байдаг.

Энэхүү өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг улс, нийслэлийн хязгаарлагдмал нөөцөөр хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахад хөрөнгийн эх үүсвэрийг зөв хуваарилах, төслүүдийг оновчтой сонгох, үр дүнг тодорхойлох явдал хамгийн чухал юм. Тухайлбал:

1. Улсын төсвийн хөрөнгөөр буюу салбарын сайдуудын багцад тусган хэрэгжүүлэх дэд бүтэц, нийгмийн салбарын томоохон төсөл, арга хэмжээнүүд */томоохон авто зам, замын байгууламжийг барих, өргөтгөн шинэчлэх, цахилгаан, дулааны хангамжийг сайжруулах зэрэг инженерийн шугам сүлжээг барих, өргөтгөх, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах зэрэг/-ийг тусган хэрэгжүүлэх бодлого барих,*
2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгохдоо Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-т заасан нийслэл өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх 20 чиг үүргийн дагуу төлөвлөх,

3. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгохдоо Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т заасан зүйлд заасан дүүрэг өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөж орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах,
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс гарсан саналуудад үндэслэн нэн шаардлагатай, аль болох үр ашигтай төсөл, арга хэмжээг тусгах зэрэг болно.

Хэдийгээр нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулсан нарийн тогтоол, журмууд цөөн ч Нийслэлээс өөрийн боломж болон одоо хэрэгжиж буй олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажилласнаар дараах давуу тал, боломж бүрджээ. Үүнд:

1. Нийслэлийн хэтийн төлөвлөлтийг олон улсын байгууллагын техник туслалцааны хүрээнд “Тогтвортой хөгжлийн 17 зорилго”-той нийцүүлэн боловсруулсан ба Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөг уялдаа холбоотой төлөвлөж, батлуулахаас гадна хэрэгжилтэд шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтад шаардлагатай газрын асуудал, техникийн зураг төсвийн бэлэн байдал зэргийг иж бүрнээр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд (НИТХ) тайлагнаж, төлөвлөдөг тогтолцоог хэвшүүлээд байна.
2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ), Дэлхийн банкны техник туслалцааны төслийн хүрээнд хөрөнгө оруулалтын төслийн саналыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалыг 2015 оноос хойш улс, нийслэлийн төсвийг боловсруулахад ашиглаж байна.
3. Аз жаргалтай хотын индексийг боловсруулан, нийслэлийн иргэдийн оролцоотойгоор “Амьдрах орчны зураглал”-ыг хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд ашиглаж байна.
4. Азийн сангийн “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд иргэдээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах Smart UB аппликэйшнийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.
5. Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс НЗДТГ-тай хамтран “Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн санхүүжилтээр 20 сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах, төсвийн хөрөнгө оруулалтын ил тод байлыг хангах Нийслэлийн иргэдийн төсөв гарын авлага боловсруулсан. Нийслэлийн боловсролын салбар (сургууль, цэцэрлэг)-ын барилга, байгууламжийн их засварын төсөл, арга хэмжээг төлөвлөх аргачлалыг төслийн дэмжлэгтэйгээр боловсруулж Нийслэлийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 25 өдрийн А/859 тоот захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангах үүднээс нийслэлийн боловсролын салбар (сургууль, цэцэрлэг)-ын барилга, байгууламжийн бүртгэлийн системийг нэвтрүүлсэн зэрэг бодлогын түвшинд хэд хэдэн зүйлийг хийгээд байгаа юм. Энэхүү гарын авлагыг ч гэсэн уг төслийн хүрээнд боловсруулсан билээ.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХЗҮЙН ОРЧИН

2.1 Хөрөнгө оруулалтын эрхзүйн орчин

Энэхүү гарын авлагын хүрээнд Монгол Улсын хэмжээнд хийгдэж буй бүх хөрөнгө оруулалтын асуудлыг авч үзэх боломжгүй тул зөвхөн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж болон ТХХТ-ийн хүрээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтын тухай авч үзнэ. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хамгийн эхний үе шат болох төлөвлөлтийн шатанд ямар эрхзүйн орчин үйлчилж байгаа талаар танилцуулахын зэрэгцээ энэ хүрээнд анхаарах зарим асуудлыг авч үзнэ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд дараах хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийн хэрэгжилтийг хангахад анхаарч, нийтлэг мөрдлөг болгодог. Үүнд:

- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020)
- ✓ Шинэ сэргэлтийн бодлого (2021)
- ✓ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)
- ✓ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (УИХ-ын 2020 оны 08 сарын 28 өдрийн 23 тоот тогтоол)
- ✓ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020)
- ✓ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- ✓ Төсвийн хүрээний мэдэгдэл
- ✓ Салбар бүрийн богино, дунд хугацааны хөтөлбөрүүд зэрэгт тусгагдсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх бодлого баримталж байна.

Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөд уялдуулах шаардлагатай дээрх хуулиудын зарим заалт болон холбогдох бусад хуулийн гол ойлголт, анхаарах заалтуудыг тоймлон оруулав. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)

Монгол Улсын аль ч салбар, түвшний бодлого төлөвлөлт тогтвортой, залгамж чанартай, харилцан уялдаатай, оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангасан байх шаардлагын үүднээс “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийг 2020 онд батлан мөрдөж эхэлсэн. Тус хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт, дунд, богино хугацааны

баримт бичгүүд байдаг. Дээр заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт, бичгүүдийн заримыг энэхүү хуулийн хүрээнд баталж хэрэгжүүлдэг байна.

Зураг 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа



Эх сурвалж: ЖАЙКА (2021). "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн илтгэл

Эдгээр урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд нь хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хангахад чиглэсэн байдаг ба хэрэгжүүлэх хугацаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, санхүүгийн эх үүсвэр зэргийг багтаасан байдаг. Гэвч бодит байдал дээр заасан хугацаанд санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүйн улмаас төлөвлөсөн тоон болон чанарын шалгуур үзүүлэлт биелэх боломжгүй байдалд хүрэх эрсдэл бий. Иймд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилтууд амжилттай хэрэгжихэд хөрөнгө оруулалтын төлөвлөлт нэн чухал юм.

2. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010)

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь малгай хууль гэж нэрлэгддэг бөгөөд тус хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн харилцааг зохицуулдаг.

Монгол улсын төсвийг нэгдсэн төсвөөр төлөвлөх бөгөөд төсвийг төлөвлөх, батлан хэрэгжүүлэх болон гүйцэтгэлийг тайлагнах аль ч шатанд төсвийн тогтвортой байдлыг хангасан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв болон Эрүүл мэндийн даатгалын

сангийн төсөв гэсэн бүх төсвийн нийлбэр нь нэгдсэн төсөв болж, нэгдсэн төсвийн үзүүлэлт нь тусгай шаардлагыг хангах учиртай.

Хөрөнгө оруулалтын зардалтай шууд холбоотой дараах тусгай шаардлагын заалтууд тус хуульд бий. Тухайлбал, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх ёстой бол тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь болон улсын өр нь хуулиар хязгаарлагдсан байдаг. Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох шаардлагатай болохыг хуульчилж өгсөн байна.

Иймд төсвийн орлого, зарлагын эх үүсвэр хязгаартай учраас хөрөнгө оруулалтын зардлын хэрэгцээг тодорхой хүрээнд хязгаарлах үндэс нь тус хуулийн тусгай шаардлагууд болдог байна.

3. Төсвийн тухай хууль (2011)

Төсвийн тухай хуулиар Монгол Улсын нэгдсэн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалт ч гэсэн энэ хүрээнд багтанад хөрөнгө оруулалт гэдгийг хуульд дараах байдлаар тодорхойлжээ.

4.1.24. "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

Энэхүү гарын авлагад улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг авч үзэхдээ Төсвийн тухай хуульд суурилж Бүлэг 3, 4, 5-д дэлгэрэнгүй авч үзнэ.

4. Өрийн удирдлагын тухай хууль (2015)

Хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхэд энэ хуулийг дагаж мөрддөг. Түүнчлэн, улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өр үүсгэх, түүнийг удирдахтай холбогдсон харилцааг тус хуулиар мөн зохицуулдаг.

Гадаадын зээл, тусламжийн харилцааг 12 жил хамтад нь зохицуулж байсан Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль нь 2015 онд Өрийн удирдлагын тухай хууль батлагдснаар хүчингүй болсон. Энэ хууль гадаадын тусламжийг харилцааг зохицуулаагүй бөгөөд зөвхөн өр, зээлийн харилцаанд хамааралтай хууль болон батлагдсан. Иймд гадаадын тусламжийн асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй

болж, одоо Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар зохицуулагддаг болсон. Зээл, тусламжийн төслүүдийн төлөвлөлтийн талаар **Бүлэг 4**-т дэлгэрэнгүй авч үзнэ.

5. *Концессын тухай хууль (2010)*

Одоогоор Монгол Улсад ТХХТ-ийн төсөл, арга хэмжээг Концессын тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд концессын төрөл, концессын зүйлийн санал боловсруулах, жагсаалт батлуулах, концессын эзэмшигчийг сонгох шалгаруулах, гэрээг байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, эргэн төлөгдөх нөхцөлтэй бол төсвөөс санхүүжилтийг хийхэд Засгийн газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар /Эдийн засаг, хөгжлийн яам/, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх, үүрэг зэргийг тодорхойлж, харилцааг зохицуулсан хууль юм. Энэхүү хуулийн хүрээнд төлөвлөлтийг хийх талаар **Бүлэг 5**-д дэлгэрэнгүй авч үзнэ.

6. *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)*

Энэхүү хуулиар батлагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн бүх худалдан авах ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийг тендер зарлахаас гэрээ байгуулах хүртэлх гол асуудлууд уг хуулиар зохицуулагддаг талаар **Бүлэг 6**-д дэлгэрэнгүй танилцуулна.

7. *Барилгын тухай хууль (2016)*

Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдын зайлшгүй уншиж танилцсан байх ёстой хууль бөгөөд хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн явцыг хянах, санхүүжүүлэхэд энэхүү хуулийн холбогдох заалтуудыг ашигладаг. Тухайлбал, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулахаас эхлээд ашиглалтад хүлээж авах хүртэлх хугацаанд шаардлагатай бүх үйл ажиллагаа, харилцаа уг хуулиар зохилцуулагдахаас гадна, зохиогч, захиалагчийн хяналт, түүний зардал, магадлашгүй ажлын зардал, барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх, хүлээн авах, ил далд ажлын акт бэлтгэх зэрэг санхүүжилтэд шаардлагатай олон зүйл ч мөн энэхүү хуулийн дагуу явагддаг тул **Бүлэг 6**-д товч оруулсан болно.

8. *Төрийн аудитын тухай хууль (2003)*

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хяналт, тайлагналттай шууд холбогддог энэхүү хуулийн дагуу Үндэсний Аудитын Газраас жил бүр санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудит хийдэг бөгөөд бид энэ талаар **Бүлэг 8**-д авч үзнэ.

9. Холбогдох журмууд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
2. Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”;

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас үзүүлж буй тусламж нь хөрөнгө оруулалтын санхүүжилтийн нэг эх үүсвэр болох бөгөөд гадаадын тусламж авах, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, тусламжийн хөрөнгийг зарцуулах, бүртгэх, хяналт тавих, тайлагнах харилцааг тус журмаар зохицуулдаг.

3. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам”. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам (журмын Хавсралт 1);
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал (журмын Хавсралт 2);
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал (журмын Хавсралт 3);
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал (журмын Хавсралт 4).

4. Сангийн сайдын 2018 оны 281 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
5. Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;

Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээлийн эх үүсвэр авах, тэдгээрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, тайлагнах, үнэлэх харилцааг энэ журмаар зохицуулна.

6. Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” зэрэг байна.
7. Сангийн сайдын 2021 оны 204 дүгээр тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, сум дүүргийн жилийн төсөв батлах маягт”. Уг тушаалд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт батлах маягтыг баталж өгсөн.

2.2 Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд

Зураг 1-д заасан бодлогын баримт бичгүүдээс хөрөнгө оруулалттай шууд холбоотой дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралтаар батлагддаг **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр** (УХОХ) нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд ихээхэн ач холбогдолтой. Учир нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, түүнийг дагалдан гарсан улсын хөрөнгө оруулалтын **таван жилийн** хөтөлбөрт 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төслүүд, тэдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах этгээд зэргийг нарийвчлан заасан бөгөөд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чухал баримт бичиг болдог байна.

УХОХ-ийг Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Үндэсний хөгжлийн газар нь салбарын яамдын саналыг авч боловсруулан батлуулж байв. Одоо шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яамны (ЭЗХЯ) харъяалах асуудлын хүрээнд уг ажил шилжсэн.

МЭДЭЭЛЭЛ

УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг дараах хавсралтын хамт баталсан.

Хавсралт 1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Хавсралт 2. **Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт
- Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт
- Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 3. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин зэргийг тусгажээ.

Засгийн газар УХОХ-ийг жил бүр тодотгоно. Өөрөөр хэлбэл УХОХ-ийн тодотголыг Засгийн газар дангаар хариуцах боломжтой байхаар зохицуулсан нь харьцангуй уян хатан болгосон онцлогтой. УХОХ-т эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хамаарна.

УХОХ-т тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлэх боломжтой байдаг. Үүнд:

- Улс, орон нутгийн төсөв
- Гадаад зээл, тусламж
- Концесс, ТХХТ
- Хувийн хэвшлийн шууд хөрөнгө оруулалт
- Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд хамаарна.

Иймд Нийслэлээс хэрэгжүүлэх төслөө УХОХ-т оруулж батлуулан хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай бөгөөд УХОХ-т тусгагдаагүй 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ямар ч хөрөнгө оруулалтын төслийг эдгээр санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломжгүйг анхаарах хэрэгтэй. Мөн нийт төсөвт өртөг нь 30 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо судалгааг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хийх бөгөөд Сангийн яам нь хууль тогтоомжид нийцүүлэн тухайн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнтэй болохыг тогтоосон нөхцөлд төсөвт тусгана.

Уг баримт бичигт тусгагдаагүй 30 тэрбум төгрөгөөс доош төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улс, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөхөд мөн энэхүү гарын авлагын дараагийн бүлгүүдэд үзэх төлөвлөлтийн хэсгийг ашиглана. Гэхдээ энэхүү гарын авлагын хүрээнд зөвхөн эхний гурван эх үүсвэр болох улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, концессийн санхүүжилтээр хийх боломжтой хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтын тухай авч үзэх болно.

Үндэсний хөгжлийн газрын даргын **2020 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А-56 тоот тушаалын 9 дүгээр хавсралт²-аар УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг ашиглах гарын авлагыг батласан бөгөөд үүнийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид онлайн хэлбэрээр заасан линкээр орж дэлгэрэнгүй танилцах боломжтой.**

Агуулгыг нь товч танилцуулбал, төсвийн ерөнхийлөн захирагч нь УХОХ-ийн жилийн тодотголд тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор холбогдох “Төслийн саналын маяг” болон аргачлалын дагуу үнэлгээ, холбогдох бичиг баримт, нэгдсэн дүгнэлтийн хамт хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь УХОХ-ийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн саналыг хүлээн авч дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ирүүлсэн санал УХОХ-т тусгах төслийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлахын зэрэгцээ бие даасан байр сууринаас үнэлгээ хийнэ. Урьдчилсан болон иж бүрэн үнэлгээ хийдэг. Иж бүрэн үнэлгээ нь а) Төсвийн ерөнхийлөн захирагч б) ЭЗХЯ-ын хоёр талын үнэлгээнээс бүрдэнэ.
- УХОХ-т тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоож, эрэмбэлж сонгоно.

² <http://nda.gov.mn/backend/files/5icJ94C5psrBaYL.pdf>


- 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ.
- Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нь үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоог хийнэ.
- Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төслийг **Засгийн газарт хүргүүлнэ.**

УХОХ-ийн тодотголыг баталсны дараа хариуцах Төсвийн ерөхийлөн захирагч (ТЭЗ) буюу холбогдох салбарын яамд, нийслэлийн төсвийн захирагч нар хэрэгжилтийг хангаж ажиллах бөгөөд УХОХ-г тусгагдсан төсөл хөтөлбөр болон 30 тэрбумаас бага төсөвт өртөгтэй улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, ТХХТ-ийн хүрээнд санхүүжүүлэх төслүүдийг төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль, тэдгээртэй холбоотой дагалдан гарсан журмын дагуу төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.3 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын эрхзүйн орчин

Нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа нь дээр дурдсан улсын богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн гаргасан дараах бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг удирдлага болгодог.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” хэмээх дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг батласны дараа Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг НИТХ-ын 2020 оны 12 сарын 04-ны өдрийн 02/09 дүгээр тогтоол, “Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 02/10 дугаар тогтоолоор тус тус баталсан.





Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн³ гол зорилгуудыг нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1. Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилгууд

№	Бүлэг	Зорилго
1.	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэн, хотын соёлыг түгээн дэлгэрүүлнэ.
2.	Хүний хөгжил	Хүн амыг эрүүл, сайхан амьдрах нөхцөлөөр ханган, чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, өндөр мэдлэг чадвартай, ёс суртахуунтай хариуцлагатай, тогтмол орлоготой, бүтээлч нийслэлийн иргэнийг төлөвшүүлнэ.
3.	Амьдралын чанар ба дундаж давхарга	Нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, албан бус салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлтийг хэрэгжүүлэн ажиллана.
4.	Эдийн засаг	Инновацад тулгуурласан, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан, тогтвортой эдийн засагтай хот болох суурийг бүрдүүлнэ.
5.	Засаглал	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.
6.	Ногоон хөгжил	Байгалийн нөөцийг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар хүрээлэн буй орчны доройтлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицно.
7.	Амар тайван, аюулгүй нийгэм	Иргэдийг аюулгүй, амар тайван, гамшгийн эрсдэлгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
8.	Бүс, орон нутгийн хөгжил	Хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.
9.	Улаанбаатар ба дагуул хот	Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.

³ <http://road.ub.gov.mn/?p=7449>



“Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

<http://stu.ub.gov.mn/media/uploads/b322c974-9f6f-4b9d-aaec-dc459e8e9c0b.pdf>

6 бүлэг
22 тэргүүлэх зорилт
132 зорилт

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталсан.

НЗДТГ-аас төсөл, арга хэмжээ нэг бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг эх үүсвэр бүрээр ялгаж шаардлагатай материалыг бүрдүүлэх, холбогдох төсөвт суулгаж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилладаг.

Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтийг мөн 2020 онд батласан бөгөөд энэхүү нийслэлийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг нь Хүн төвтэй бодлого, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал гэсэн 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжих юм. Тогтвортой хөгжлийн зорилгуудын “Хөгжлөөс хэнийг ч хоцроохгүй байх” үндсэн зарчим дээр тулгуурласан. Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын суурь түвшинг 2018 оноор 17 зорилго, 83 зорилт, 169 шалгуур үзүүлэлтүүдийг хангахаар, хүрэх түвшинг 2021-2030 он хүртэл жил бүрээр тодорхойлон хэрэгжүүлэхээр тусгасан урт хугацааны бодлогын баримт бичиг юм.



МЭДЭЭЛЭЛ
Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт хийхэд нэн тэргүүнд Нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан эсэхийг шалгаж, төсөвт суулгадаг. Ялангуяа, УХОХ-т тусгагдаагүй төсөл, арга хэмжээг жилийн төлөвлөгөө, төсөвт санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж хэрэгжүүлдэггүй.

Мөн Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг⁴ батлан ажиллаж байна.

Богино хугацааны нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд уялдуулан дараах цаглабараар боловсруулж, төсвийн хамт НИТХ-аар хэлэлцүүлж батлуулдаг.

Зураг 3. Улс, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний цагалбар



Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгийн газар

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг дээрх хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэхээс гадна төсвийн тухай хуулийн дагуу Нийслэл өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээ, улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг ялган холбогдох журмын дагуу боловсруулж Сангийн яаманд саналаа хүргүүлдэг.


Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар удирдана.

⁴ <https://www.ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=54146&dataID=541>

2.4 Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн төлөвлөлт, тэдгээрийн ялгаа

Улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшил болон гадаадын зээл, тусламжийн санхүүжилтаар 2011-2020 онд нийт 21.3 их наяд төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн байна. Эдгээр хөрөнгө оруулалт нь 2011 онд 844.9 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 3.8 их наяд төгрөг болж 4.5 дахин нэмэгдсэн нь боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн дэд бүтцийг сайжруулах төслүүдийн санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Зураг 4. Нэгдсэн төсөвт эзлэх нийт хөрөнгийн зардал, сая төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

Өөрөөр хэлбэл, нийт хөрөнгө оруулалтын зардал тасралтгүй нэмэгдэж ирсэн ч цар тахлын нөлөөгөөр эдийн засаг агшсан тул 2021 онд хөрөнгийн зардал 3.4 их наяд төгрөг болж бага зэрэг буурсан.

Дараах хүснэгтэд энэхүү гарын авлагад авч үзэх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн төлөвлөлтийн гол ялгааг товч харуулсан ба дараагийн бүлгүүдэд эх үүсвэр тус бүрээр дэлгэрэнгүй авч үзнэ.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн төлөвлөлтийн гол ялгаа, үе шат

УХОХ /Бүлэг 2/	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт /Бүлэг 3/	Гадаад зээл, тусламж /Бүлэг 4/	ТХХТ /Бүлэг 5/
<p>Гол хариуцагч: ЭЗХЯ</p> <p>Төсөл бэлтгэх: ТЕЗ-аас саналыг авна.</p> <p>Хуулийн хугацаатай эсэх: Тийм</p> <p>Ашигладаг программ хангамж: projects.nda.gov.mn</p> <p>Үе шат 1: ТЕЗ нь 30 тэрбумаас дээш төсөвт өртөгтэй, 1 жилээс дээш хугацаагаар хэрэгжих дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын</p>	<p>Гол хариуцагч: СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Нийслэл ХБТХэлтэс</p> <p>Төсөл бэлтгэх: СЯ нь ТЕЗ-аас, Нийслэл нь харьяа дүүрэг, байгууллагуудаас санал авна</p> <p>Хуулийн хугацаатай эсэх: Тийм</p> <p>Ашигладаг программ хангамж: publicinvestment.gov.mn Нийслэл: brs.ulaanbaatar.mn</p> <p>Үе шат 1: ТЕЗ нь аймаг, нийслэл, харьяа байгууллагуудаас ирүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг</p>	<p>Гол хариуцагч: СЯ-ны Хөгжлийн санхүүжилтийн газар</p> <p>Төсөл бэлтгэх: Шинэ төслийг ОУ-ын байгууллага, хандивлагч улсуудтай байгуулсан ОУ-ын гэрээ хэлэлцээрт үндэслэнэ. Улсын төсөвт тусгахдаа ТЕЗ-аас үргэлжлэн хэрэгжиж буй төслийн саналыг хуулийн хугацаанд авна.</p> <p>Хуулийн хугацаатай эсэх: Тийм /шинээр эхлүүлэх төслийн хувьд тогтоосон хугацаа байхгүй/</p> <p>Ашигладаг программ хангамж: odamis.mof.gov.mn</p> <p>Үе шат 1: ТЕЗ нь тухайн салбарт хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа гадаад, зээл тусламжийн төслийн саналыг</p>	<p>Гол хариуцагч: ЭЗХЯ</p> <p>Төсөл бэлтгэх: ТЕЗ болон Хувийн хэвшилээс санал авна.</p> <p>Хуулийн хугацаатай эсэх: Үгүй</p> <p>Ашигладаг программ хангамж: Одоогоор байхгүй.</p> <p>Үе шат 1: ТЕЗ болон аймаг нийслэлийн Засаг нь ТХХТ-ээр хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг</p>

<p>төсөл, арга хэмжээний саналыг ЭЗХЯ-д хүргүүлнэ.</p> <p>Үе шат 2: ЭЗХЯ нь ТЕЗ-ийн ирүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, эрэмбэлэх бэлтгэл ажил хийгдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ ЭЗХЯ төслүүдэд урьдчилсан ТЭЗҮ хийнэ. ✓ ЭЗХЯ нь урьдчилсан ТЭЗҮ-гээр эдийн засгийн үр ашигтай нь тогтоогдсон төслийг УХОХ-т 	<p>холбогдох хууль, журамд заасан цаглабарын дагуу Сангийн яаманд хүргүүлнэ. Ингэхдээ ЭЗХЯ-аас УХОХ-т батлагдсан 30 тэрбумаас дээш төсөвт өртөгтэй өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төслүүдийг төсөвт тусгуулахаар мөн СЯ-нд ирүүлж болно. ТЕЗ нь 30.0 тэрбумаас бага төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг шинээр эхлүүлэх тохиолдолд мөн Сангийн сайдын холбогдох журмын дагуу СЯ-нд санал хүргүүлнэ. Нийслэлийн харьяа байгууллага, дүүргүүд нь НЗДТГ-т саналаа ирүүлнэ.</p> <p>Үе шат 2: СЯ нь мөн УИХ-ын гишүүд, ТЕЗ-ийн ирүүлсэн бүх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, тухайн жилийн төсвийн хязгаар, ТХМ-д заасан зарлагын дээд хэмжээнд тулгуурлан холбогдох журмын дагуу цахим системээр давхар ирүүлсэн саналыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгана. НЗДТГ-ын ХБТХ нь мөн журамд заасны дагуу бодлогын баримт бичигт</p>	<p>боловсруулан СЯ-нд хүргүүлэх бөгөөд СЯ уг төсөл арга хэмжээг УХОХ, Өрийн удирдлагын тухай хуультай нийцсэн тохиолдолд санхүүжүүлэгч олон улсын байгууллага, хандивлагч орны талд хүсэлт гаргана.</p> <p>Үе шат 2: ОУ-ын байгууллага, хандивлагч орноос СЯ-наас ирүүлсэн саналыг судалж, өөрсдийн холбогдох журмын дагуу төслийн судалгааг хийх, зээлийн гэрээний төслийг СЯ-тай хэлэлцээр хийх, эцэст нь захиралуудын зөвлөл, эсвэл тухайн орны СЯ-аар батлуулах зэрэг бэлтгэл ажил хийгдэнэ.</p>	<p>ТХХТ/концессын зүйлийн жагсаалтад тусгуулахаар ЭЗХЯ-т хүргүүлнэ. Хувийн хэвшил мөн санаачлага гаргаж болно. ЭЗХЯ-аас тухайн төслийн судалгааг хийж Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгах эсэх шийдвэр гаргана. Шийдвэрлэсэн төслийг холбогдох ЗГ-ын тогтоолд өөрчлөлт оруулах замаар ямар төрлөөр хэрхэн хэрэгжүүлэх шийдвэр гаргуулна.</p> <p>Үе шат 2: ЭЗХЯ нь ТХХТ/концессын төслийн бэлтгэл ажиллагааны хүрээнд холбогдох ТЕЗ, Сангийн яамны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, төслийн гүйцэтгэгч буюу хувийн хэвшлийн сонгон шалгаруулалт явуулах, тухай төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшилтэй гэрээний хэлэлцээр, санхүүгийн схем</p>
---	---	---	---

<p>тусган жагсаалтыг бэлтгэнэ.</p> <p>Үе шат 3: ЭЗХЯ-аас УХОХ-ийн төслийг боловсруулж дуусгах, эсхүл батлагдсан УХОХ-т нэмж оруулах тодотголын саналыг ТЕЗ-ийн ирүүлсэн саналд үндэслэн боловсруулж, хуулинд заасан хугацаанд Засгийн газарт хүргүүлж, батлуулна.</p>	<p>тусгагдсан, УТХО-аар хийгдэх боломжгүй, батлагдаагүй төслийн саналыг багтааж ИТХ-д хуульд заасан хугацаанд өргөн барина.</p> <p>Үе шат 3: Төсвийн төслийг ЗГ-ын хуралдаанаар 2-оос багагүй, УИХ-ын чуулганаар нийт 4 удаа хэлэлцүүлэн батлуулна.</p> <p>Нийслэлийн хөрөнгө оруулалтыг НИТХ-аар хэлэлцүүлэн батлуулна.</p>	<p>Үе шат 3: ОУ-ын байгууллага, хандивлагч орнуудаас санхүүжилт батлагдсан тохиолдолд СЯ-наас тухайн төслийн зээлийн ерөнхий хэлэлцээр, тусгайлсан хэлэлцээрийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр төсөл хэрэгжих боломжтой болно.</p>	<p>тохирох зэрэг ажлыг зохион байгуулна. Гэрээний төсөлд уг төслийг хэрэгжүүлэх бүх нөхцөл, шаардлага зэргийг харилцан тохиролцдог.</p> <p>Үе шат 3: Хувийн хэвшилтэй хийсэн гэрээний хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд гэрээ байгуулах эрх авах холбогдох ЗГ-ын тогтоолыг гаргуулж, гэрээг байгуулснаар төсөл хэрэгжиж эхлэх боломжтой болно.</p>
--	---	--	---

Дээрх хүснэгтээс харахад УХОХ-ийн төлөвлөлт нь 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бүх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэгтгэж, хөрөнгө оруулалтын бодлогын гол баримт бичгүүдийн нэг болон батладаг. Гэвч жил бүр хэрэгжиж буй нийт хөрөнгө оруулалтын 90 орчим хувь нь 30 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй байдаг тул тухайн жилийн **Улсын төсвийн хөрөнгө оруулалт** нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд удирдлага болгох хоёр дахь гол баримт бичиг болж хуулиар батлагддаг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалттай харьцуулахад Гадаад зээл, тусламжаар санхүүжсэн төслийн нэгдсэн төсөвт эзлэх хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаас их байдаг. Хэдийгээр төслийн тоо цөөн боловч зээл, тусламжийн ашиглалт нь тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалтаас өндөр байж ирсэн. Түүнчлэн гадаад зээл, тусламжаар санхүүжихээр батлагдсан төсвөөс гүйцэтгэл нь ихэвчлэн хэтэрч иржээ. Өөрөөр хэлбэл, жил бүр тухайн төсвийн хуулиар батлагдсан зээл, тусламжийн ашиглалт хэтрэх хандлагатай байдаг.

Концессын тухай хууль 2010 онд батлагдсан ч энэхүү санхүүжилтийн эх үүсвэр харьцангуй сул хөгжсөн, бусад улс орны жишигээр яваагүй. Үүнээс шалтгаалж эргээд төсөвт 2.3 их наяд төгрөгийн дарамт учруулж байна. Саяхныг хүртэл хэрэгжсэн “Барих-

шилжүүлэх” төрлөөр хийгдсэн төслүүд нь төр, хувийн хэвшлийн үндсэн зарчмаас зөрүүтэй бөгөөд түлхүүр гардуулах гэрээ маягтай боловч хүүгийн зардал, менежментийн зардлыг төр хариуцахаар хийгдсэн зэрэг дутагдалтай байгаа юм. Иймд Концессын тухай хуулийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн суурь зарчим, үндсэн ойлголтууд болох түншлэлийг төлөвлөх, сонгох, эрсдэлийг тооцож хувиарлах зэрэг асуудлыг бүрэн гүйцэд зохицуулдаг болгох, хувийн хэвшлийн оролцоог бүрэн хангаж чаддаг болгох зорилгоор хүчингүй болгож, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн шинэчилсэн хуулийн төслийг Сангийн яамнаас боловсруулж батлуулах ажил хийгдэж байна.

2.5 Жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Төр нь хөгжлийн бодлого, хөтөлбөртөө тусгасан тэргүүлэх чиглэлүүдийг хөгжүүлэх, дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд хэзээ, хаана, хэдий хэмжээний хөрөнгө оруулах/зарцуулах вэ? гэдгээ шийдвэрлэж, төсвөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Иймд тухайн нийгэмд ямар зүйлд мөнгийг зарцуулах нь гэдгийг шийдвэрлэдэг төсвийн төлөвлөлт нь нийгэм, улс төр, эдийн засаг ба жендерийн үзэл санааны илэрхийлэл болдог.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай (2011) хуулийн 16-р зүйлд “... жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх” ажлыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй хэмээн заасан байдаг. Монгол Улс Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн II үе шат (2017-2021)-ыг хэрэгжүүлж байна.⁵ Энэ хүрээнд 21 аймаг, дүүргүүд жендерийн дэд хөтөлбөрөө боловсруулж эхэлсэн билээ. Жендерийн тэгш байдлыг хангах бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд эдгээр зорилтууд нь төсөвт тусгалаа олсон байх учиртай. Ялангуяа, төвлөрлийг сааруулах зорилгын хүрээнд орон нутгийн удирдлагын түвшинд энэхүү үйл ажиллагаа нь ихээхэн хамааралтай юм.

Жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт нь жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн нэг хэсэг юм. Энд жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) гэдэг нь төсвийн циклийн бүхий л үйл явцад жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үйл явц юм. ЖМТ нь санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа аливаа жендерийн тэгш бус асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог шинжилгээний чухал хэрэгсэл юм. ЖМТ нь хөгжлийн төлөө нэг талыг баримтлах бус, харин илүү тэгш хүртээмжтэй, үр ашигтай, тогтвортой хөрөнгө оруулалт хийхэд тусалдаг.

Төсвийн хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд яагаад жендерийн эрх тэгш байдлын тухай бодох хэрэгтэй вэ? гэхээр аливаа хөрөнгө оруулалт нь төрөөс ард иргэдийн сайн сайхан амьдрах нөхцөлийг хангах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих суурь дэд бүтцийг бий болгоход чиглэдэг тул хөрөнгө оруулалтын төслийн үр шимийг хүртэх

⁵ Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр. Холбоос: <https://gender.gov.mn/legal/22>

хүмүүс нь зорилтот бүлгүүд буюу иргэд байдаг. Гэтэл иргэд хэмээх ойлголт нь эмэгтэй, эрэгтэй насанд хүрэгсэд, хүүхдүүд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг олон ялгаатай бүлгийг өөртөө агуулна. Иймд үр шимийг хүртэх нийгмийн бүлгүүдэд ялгаатай ашиг сонирхол, хэрэгцээ шаардлага байдгийг хүлээн зөвшөөрч, цогцоор нь авч үзэх нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний бүх үе шатанд хамааралтай юм.

Хөтөлбөрт/үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн шатанд хөрөнгө оруулалтын болон төсвийн мэргэжилтнүүд нь тухайн салбар, хөтөлбөрийн хувьд дэвшүүлсэн зорилтод хүрэхийн тулд ямар орцыг ашиглан, ямар үйл ажиллагаа явуулж, ямар гарцыг бий болгосноор, ямар үр дүнд хүрэх вэ? гэдгийг сайтар төлөвлөх учиртай.

Зураг 5. Хөтөлбөрт төсвийн төлөвлөлтийн логик гинжин хэлхээ



- **Орц** нь хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд хэрэгтэй нөөц (хүний нөөц, төсвийн хөрөнгө, материал) юм.
- **Үйл ажиллагаа** нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай үйлдэл байдаг тул хөрөнгө оруулалтын төслийг энэ хүрээнд ойлгож болно.
- **Гарц** нь хөрөнгө оруулалтын төслийн дэвшүүлсэн зорилтод хүрэхийн тулд үзүүлж буй үйлчилгээ, нийлүүлж буй бүтээгдэхүүн юм.
- **Үр дүнг** нь зорилтот бүлэг, иргэдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төслийн нөлөөллийг үнэлэх замаар тодорхойлно. Үр дүн нь цаашид аажмаар нөлөө үзүүлэхүйц (жендэрийн тэгш бус байдлыг бууруулах г.м) хэдэн хэдэн гарцын үр дүнд бий болох дунд хугацааны ахиц дэвшил юм.
- **Зорилт** нь хөрөнгө оруулалтын төслийн хүрэхийг хүсч буй тодорхой үр дүн юм. Зорилтод гадаад, дотоод олон хүчин зүйлс нөлөөлдөг боловч ямар ч нөхцөлд үйл ажиллагаа, гарцын үр дүн нь амжилтад хүрэхэд чиглэгдсэн байна. Зорилт нь жендэрийн статистик ашиглан жендэрийн дүн шинжилгээг хийсний үндсэн дээр SMART байдлаар тодорхойлогдох хэрэгтэй. Ингэснээр хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, үнэлгээний шатанд хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээнд чухал ач холбогдолтой.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

3.1 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн эрх зүйн орчин

Төсвийн хөрөнгө оруулалт нь хувийн салбарын хөрөнгө оруулалтыг бодвол улс орны хөгжлийн томоохон суурь салбаруудад хэрэгждэг, нийтийн эрх ашигт зориулсан шинж чанартай, түүнчлэн татвар төлөгчдийн мөнгөөр бүрдүүлсэн төсвийн орлогоос зарцуулалт, санхүүжилтийг хийдэг учраас аль болох үр өгөөжтэй төслийг хэрэгжүүлэхийн тулд нарийн сайн төлөвлөлт, зөв зохистой бодлого шаардсан үйл ажиллагаа юм. Мөн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хамгийн их яригддаг сэдэв бол нийгмийн хэрэгцээг хангахад нөөцийн хувиарлалтыг чиглүүлэх, тухайлбал дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийхийг чухалчилдаг. Энэ бол нийгмийн хөгжилд шууд болон дам байдлаар эерэг үр нөлөөтэйн зэрэгцээ, ирээдүйд эдийн засгийн өсөлтийг бий болгодог үр өгөөжтэй үйл ажиллагаа билээ.

Өмнөх бүлэгт авч үзсэн хөрөнгө оруулалтын талаарх хууль, хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон холбогдох журмууд нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хувьд ч мөн адил үйлчлэх бөгөөд “Төсвийн тухай хууль” нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулдаг гол хууль юм. Иймд уг хуульд заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой асуудлыг орон нутгийн төсөвтэй нь хамт дэлгэрэнгүй авч үзье.

Ингэхдээ Сангийн яамны Fiscal программ хангамжинд төсвийн мэдээллийг шивж оруулахад шаардлагатай ойлголтуудыг цэгцтэй хүргэх үүднээс юуны өмнө төсвийн хөрөнгө оруулалтын ангилал, шатлалын талаар танилцуулъя.

Төсвийн хөрөнгө оруулалтын ангилал

Хөрөнгийн зардал гэдэг нь тухайн жилд төсвийн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө бий болгох чиглэлээр барилга, байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх, стратегийн шинжтэй бараа, бүтээгдэхүүнийг улсын нөөцөд байршуулахтай холбоотойгоор зарцуулах зардлуудыг хэлдэг. Хөрөнгийн зардал нь төсвийн гол зардлуудын нэг учраас төсвийн төсөлд тусгагдан, бусад төсвийн төслийн адил төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх болон тайлагнах гэсэн үйл ажиллагааны үе шатыг дамжина.

Төсвийн тухай хуулиар төсвийн төслийг дунд хугацааны ТХМ-д үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан Засгийн газраас Улсын Их Хуралд, харин орон нутагт бүх шатны Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн саналыг хэлнэ гэж заасан. Иймд төсвийн төсөлд тусгагдах төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардалд дараах төсвийн шатлал, ангиллыг ашиглана.

Хүснэгт 3. Төсвийн хөрөнгө оруулалтын ангилал

№	Төсвийн ангилал	Тайлбар
1.	Төсвийн шатлал	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөв
2.	Төсвийн захирагч	<ul style="list-style-type: none"> Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн төвлөрүүлэн захирагч Төсвийн шууд захирагч
3.	Эдийн засгийн ангилал	<ul style="list-style-type: none"> Сангийн сайдын 2015 оны 7 тоот тушаалаар төсвийн <ol style="list-style-type: none"> орлогын эдийн засгийн ангилал зарлагын эдийн засгийн ангилал хөтөлбөр зориулалт арга хэмжээгээний ангиллыг шинэчлэн баталсан.
4.	Хөтөлбөр	
5.	Арга хэмжээ	
6.	Санхүүжүүлэх эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> Сангийн сайдын 2014.01.10-ны 5 тоот “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалаар баталсан ангиллаас дараах 2 ангиллыг хэвээр үлдээж бусдыг 2015 оны 7 тоот тушаалаар шинэчилсэн. Үүнд: <ol style="list-style-type: none"> төсвийн эх үүсвэрийн ангилал төсвийн бусад мэдээллийн ангилал

Төсвийн шатлал

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрддэг.

Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэх ба сум, дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв болно. Орон нутгийн төсөв болох аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөв нь тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоороо батлагддаг бол бусад төсвийг УИХ-аар хуульчлан баталдаг.

Эдгээр төсвөөс улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтыг тусган хэрэгжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2010-2019 оны нийт зарлагын 23 хувийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн гүйцэтгэлийн 2010-2019 оны мэдээ

Төсвийн захирагч

Төсвийн нийт зарцуулалт нь төсвийн захирагчийн төсвөөр дамжин хэрэгждэг бөгөөд Төсвийн тухай хуульд төсвийн захирагчийн гурван шаттай түвшинг тогтоосон байдаг. Үүнд:

- 1. Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ):** Өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ.
Жил бүр УИХ-аар хуульчлан батлагддаг төсвийн төсөвт төвлөрүүлэх орлого, урсгал болон хөрөнгийн зардал нь ТЕЗ-аас батлагддаг. Мөн тухайн жилд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт нь ТЕЗ-аар гардаг.
Орон нутгийн төсвийн хувьд ИТХ-ын дарга болон аймаг, нийслэл сум дүүргийн Засаг дарга нар ТЕЗ болно.
Төсвийн тухай хуулиар ТЕЗ нь өөрийн доод шатны төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид төсөв захиран зарцуулах, хяналт тавих эрхээ шилжүүлэх боломжтойгоор зохицуулагдсан байдаг.
- 2. Төсвийн төвлөрүүлэн захирагч (ТТЗ):** ТЕЗ-аас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ.
Жишээлбэл, төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх үйлчилгээг хүлээн авсан аймаг, нийслэлийн Засаг дарга ТТЗ байна. Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэлд ажилладаг сургууль, цэцэрлэгийн төсөв нь тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр салбарын сайдын төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт гэрээний үндсэн дээр шилжихэд хүлээн авагч аймаг, нийслэлийн Засаг дарга ТТЗ нь болно.
- 3. Төсвийн шууд захирагч (ТШЗ):** ТЕЗ болон ТТЗ-аас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлдэг. ТШЗ нь тухайн төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар байна.

Төсвийн эдийн засгийн ангилал

Төсвийн орлогын эдийн засгийн ангилал нь татварын болон татварын бус орлогоос бүрддэг. Татварын бус орлогын нэг бүрэлдэхүүн болох хөрөнгийн орлогод төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого, өмч хувьчлалын орлого багтана.

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн гэсэн үндсэн ангилалтай ба хөрөнгийн зардалд дараах 5 төрлийн зардал ордог. Үүнд:

- Барилга байгууламж
- Их засвар
- Тоног төхөөрөмж
- Стратегийн нөөц хөрөнгө

- Бусад хөрөнгө

Төсвийн тухай хуулиар батлагдсан эдийн засгийн ангиллыг зөрүүлж санхүүжилт авах гэсэн тохиолдлууд бодит байдал дээр маш их гардаг. Тухайлбал, барилга байгууламж ангилалд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтээр тоног төхөөрөмж худалдан авах, их засварын ажлын хүрээнд тоног төхөөрөмж авах зэрэг зөрчил элбэг гардаг. Энэ нь эргээд аудитын томоохон зөрчил болдог тул төсвийн тухай хуулиар батлагдсан энэхүү ангилалыг хатуу анхаарах шаардлагатай.

Хөтөлбөр, зориулалт, арга хэмжээний ангилал

Төсвийг боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт болон гадаад харилцаанд зарцуулж буй эсэхийг харуулдаг ангилал юм. Зориулалт, арга хэмжээний ангиллаас төсвийг ямар зориулалтаар зарцуулж байгааг харах боломжтой. Тухайлбал, үйл ажиллагааны урсгал зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, татаас, нийгмийн даатгалын тэтгэвэрт улсаас олгосон шилжүүлгийн зардлыг харж болно. Уг ангиллаар хөрөнгийн зардлыг зориулалтаар нь дараах 20 дэд ангилалд авч үздэг.

Хүснэгт 4. Хөрөнгийн зардлын зориулалтын ангилал

№	Дэд ангилал	
1.	Албан конторын барилга	11. Програм хангамж
2.	Орон сууц	12. Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах
3.	Тусгай зориулалтын барилга	13. Амьтан, ургамал, ой
4.	Нийгмийн зориулалттай барилга байгууламж	14. Геологи хайгуул, судалгаа
5.	Инженерийн шугам сүлжээ, цахилгаан дулааны хангамж	15. Материаллаг бус хөрөнгө
6.	Авто зам, гүүрийн байгууламж	16. Түүхэн үнэт зүйлс
7.	Хөдөө аж ахуйн барилга байгууламж	17. Газар, байгалийн баялаг
8.	Тавилга	18. Бусад
9.	Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт	19. Концессоор хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ
10.	Тээврийн хэрэгсэл	20. Векселээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ

Эх сурвалж: Сангийн яам

Санхүүжүүлэх эх үүсвэрийн ангилал

Аливаа төсөл, хөтөлбөр арга хэмжээг хаанаас буюу ямар эх үүсвэрээс санхүүжүүлж байгааг бүртгэдэг ангилал юм.

Хүснэгт 5. Хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн ангилал

№	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	Тайлбар
1.	Улсын төсвөөс санхүүжих	<ul style="list-style-type: none"> • Улсын төсвөөс санхүүжих • Засгийн газрын тусгай сангаас санхүүжих • Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих

2.	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн төсвөөс • Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих
3.	Нийгмийн даатгал, ЭМД-ын сангийн төсвөөс санхүүжих	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын сангаас санхүүжих • Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих
4.	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	<ul style="list-style-type: none"> • Тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагаатай холбоотой бий болсон орлогын эх үүсвэр.
5.	Зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	<ul style="list-style-type: none"> • Олон улсын зээл, тусламжийн эх үүсвэр хамаарна
6.	Бусад эх үүсвэр	

Эх сурвалж: Сангийн яам

Түүнчлэн улсын болон орон нутгийн төсвөөр санхүүжих концессын гэрээгээр төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг болдог.

Хөрөнгө оруулалтын бусад ангилал

Хөрөнгө оруулалтыг төслийг төсөвт суусан байдлаар нь шинэ буюу тухайн жилийн төсөвт шинээр суусан, шилжих буюу он дамжин үргэлжүүлэн хэрэгжүүлэх гэж ангилдаг.

3.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатууд

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь улсын урт хугацааны хөгжил, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, улс орны тэргүүлэх чиглэлд нөөцийн хувиарлалтыг оновчтой хийж, зардлын хувьд үр ашигтай зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байхыг хуульчилсан тул Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг төсөвт Монгол Улсын төсвийг нэгдсэн төсвөөр танилцуулдаг.

Төсвийн тухай хуулийн 21.1-д Монгол улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд дараах төсвийг багтаасан байна. Үүнд,

1. Улсын төсөв
2. Орон нутгийн төсөв
3. Ирээдүйн өв сангийн төсөв
4. Нийгмийн даатгалын сангийн төсөв
5. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

Эдгээр төсвөөс орон нутгийн төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталдаг бол бусад төсвийг Улсын Их Хурлаар хуульчлан баталдаг.


Төсвийг төлөвлөх, батлан хэрэгжүүлэх болон гүйцэтгэлийг тайлагнах аль ч үе шатанд төсвийн тогтвортой байдлыг хангасан байх шаардлагагыг хуульчилж өгсөн байдаг. Иймд төсвийг дунд хугацааны ТХМ, төсвийн хязгаарт багтааж, шаардлагатай

зардлыг иж бүрнээр төлөвлөх болон төсвийн нэгдсэн үр дүнгийн үзүүлэлт болон төсвийн тусгай шаардлагыг хангаж байх нь төлөвлөлтийн үндсэн зарчим болно.


Төсвийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд үргэлжилж, энэхүү хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, хөрөнгийг бүртгэх зэрэг үе шатууд тодорхой хугацаанд холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд хэрэгждэг байна.

Төсвийн төлөвлөлтийн үе шат, түүний хугацааны цаглабарыг Төсвийн тухай хуулиар зохилцуулсан байдаг бөгөөд үүнийг үе шатаар нь уялдуулан харуулбал:

Зураг 6. Улсын төсөв боловсруулах, батлах цаглабар



Тайлбар: ТХМ- дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, СЯ- Сангийн яам, ЗГ- Засгийн газар, УИХ-Улсын Их Хурал, ТЕЗ- Төсвийн Ерөнхийлөн Захирагч



ЗД - Засаг дарга, СЯ- Сангийн яам, ЗГ- Засгийн газар, УИХ- Улсын Их Хурал, ТЕЗ- Төсвийн Ерөнхийлөн захирагч, ИТХ- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Эх сурвалж: Сангийн яам, НЗДТГ

Эхний үе шат нь дунд хугацааны төсвийн бодлогын баримт бичгээ боловсруулж, УИХ-аар батлуулах үйл явц юм. Дунд хугацааны ТХМ-д дунд хугацаа буюу тухайн жилийн үзүүлэлт ТХМ нэрээр, түүний дараагийн 2 жил нь төсвийн төсөөлөл нэрээр нийт 3 жилийн үзүүлэлт тусгагдана. Үүнд:

1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд /дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ, хэрэглээний үнийн өсөлтийн түвшин/
2. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, **нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ**) /ДНБ-д эзлэх хувь/
3. Засгийн газрын өрийн нийт хэмжээ /ДНБ-д эзлэх хувь/
4. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /ДНБ-д эзлэх хувь/ зэрэг нь тусгагдан батлагддаг.

Дунд хугацааны ТХМ-ийн төслийг 3 дугаар сараас эхлэн боловсруулж, Сангийн яам жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар төслийг хэлэлцэн 5 дугаар сарын 01-ний дотор УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-аар 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, баталдаг. Тус дунд хугацааны ТХМ-д батлагдсан нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ нь улсын болон орон нутгийн төсвийн тухайн жилийн хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтыг тодорхойлох суурь нь болдог байна.

Хоёрдахь үе шат нь Дунд хугацааны ТХМ-д үндэслэн ТЕЗ-ийн жилийн төсвийн хязгаарыг тогтоох үйл явц юм.

Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны ТХМ-д нийцүүлэн ТЕЗ бүрийн дараа оны төсвийн төсөл боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг хэлэх бөгөөд энэ нь Засгийн газрын тогтоолоор батлагддаг. Төсвийн хязгаарыг боловсруулахад ТЕЗ нар төсвийн хязгаарын саналаа боловсруулан Сангийн яаманд жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлж, Сангийн яам жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагч ТЕЗ-ийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газраас 7 дугаар сарын 01-ний дотор төсвийн хязгаарын төслийг батална.

Сангийн яам нь батлагдсан төсвийн хязгаарыг дараа оны төсвийн төсөл хэрхэн боловсруулах удирдамжийн хамт 7 дугаар сарын 05-ны дотор ТЕЗ нар хүргүүлдэг.

Гуравдахь үе шат нь төсвийн хязгаар, төсвийн удирдамжид суурилсан ирэх жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, төсвийг УИХ-аар батлуулах үе шат юм.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төслүүдэд тавигдах шаардлагууд бий. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээний санал нь дараах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. *Нийтлэг шаардлага:* Хөгжлийн бодлогын баримт бичиг, стратегийн бодлого чиглэлийн шаардлагад нийцсэн байх.
2. *Тусгай шаардлага:* Хөрөнгө оруулалтын эдийн засгийн ангилалын хувьд дараах ялгаатай тусгай шаардлагуудыг хангах учиртай байдаг.

Хүснэгт 6. Хөрөнгө оруулалтын эдийн засгийн ангилалын тусгай шаардлагууд

Хөрөнгө оруулалтын эдийн засгийн ангилал	Тусгай шаардлага
Шинээр эхлэх барилга байгууламж	<ul style="list-style-type: none"> - Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу төслийн шинжилгээг хийсэн байх; - Газрын байршил шийдвэрлэсэн байх, хэрэв газар чөлөөлөх шаардлагатай бол тухайн санхүүгийн жилд багтан шийдвэрлэх тооцоолол үндэслэлтэй байх, - Техникийн нөхцөлтэй байх, - Магадлал хийгдсэн зураг төсөлтэй байх
Их засвар	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан зураг төсөвтэй байх, - Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байх, - Барилга байгууламжийн насжилт, ашиглалтын норм, хугацаа, элэгдэлийг тооцоолсон байх
Тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> - Техник, тоног төхөөрөмж худалдан авах эрэлт хэрэгцээг тодорхойлсон судалгаатай байх, - Техник, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг гаргасан байх, - Үр ашгийн тооцоо болон ашиглалтын үеийн зардлын тооцоолол нийлсэн байх
Зөвлөх үйлчилгээ	<p>ТЭЗҮ, Зураг төсөв, ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын байршил шийдвэрлэсэн, газар чөлөөлөх шаардлагатай бол нөхөн олговрын зардлыг шийдвэрлэсэн байх, - Инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын хувьд трасс тодорхойлж, холбогдох газруудтай зөвшилцсөн байх, - Инженерийн шугам сүлжээний анхан шатны судалгаатай байх.
Төслөөс хамааран тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Тухайн төслийн төрлөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа болон Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу төслийн шинжилгээг хийсэн байх; - Тухайн төслийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулсан байх.

ТЕЗ нь ирүүлсэн төсвийн хязгаар, төсвийн удирдамжид суурилан ирэх жилийн төсвийн төслөө нэгтгэн боловсруулж, 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам ирүүлсэн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх бол Засгийн газар төсвийн төслийг хэлэлцэн, 10 дугаар сарын 01-ний дотор УИХ-д өргөн мэдүүлнэ. Жилийн төсвийн төсөл нь жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор УИХ-аар хуульчлан батлагддаг.

Хуульчлагдсан төсөвт улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг (төсөв алдагдалтай аймагт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого) болон орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилт батлагдана. Улсын төсвөөс олгогдох дээрх санхүүжилт нь орон нутгийн төсвийн суурь тооцоонд тусгагддаг.

Түүнчлэн, төсвийн хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг төсөл, арга хэмжээ бүрээрээ хуульчлан батлагддаг болно.

МЭДЭЭЛЭЛ

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг тухайн жилийн төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/-аар баталдаг.

Төсвийн тухай хууль, 2011

ТЕЗ-ийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

- Санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- Жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;
- Хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
- Төсвөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
- Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

ТЕЗ-ийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана. Үүнд:

- Төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо;
- Төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо;
- Шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо;
- Нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй болсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах санал, тооцоо;
- төсвийн гүйцэтгэлийн тайлан болон тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо;
- төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо зэрэг болно.

Мөн ТЕЗ нь жилийн төсвийн хязгаарт багтаагүй саналаа холбогдох үндэслэл, тайлбарын хамт нэмж ирүүлэх боломжтой байдаг.

Дөрөвдэх үе шат нь улсын төсөв батлагдсаны дараа орон нутгийн төсөв батлах үе шат юм. Нийслэлийн төсөв нь орон нутгийн төсөв бөгөөд нийслэлийн шууд харьяа байгууллагын төсөв болон дүүргийн харьяа байгууллагын төсвөөс бүрдэнэ. Нийслэлийн төсөв нь орон нутгийн төсөв болохын хувьд төсөв батлагдах үе шат нь төсвийн тухай хуулийн орон нутгийн төсөв батлагдах шат дарааллыг дагаж мөрддөг.

Хүснэгт 7. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төслүүдийн төлөвлөлтийн үе шатанд оролцогч талууд, тэдгээрийн оролцоо

№	Оролцогч талууд	Одоогийн оролцож байгаа бодит байдал
1	Иргэн	Жил бүрийн төсвийн төслийн иргэдийн хэлэлцүүлэгт оролцдог бөгөөд төсвийн төслийн хэлэлцүүлэгт нийслэлийн хэмжээний нийт ажлыг ерөнхийд нь танилцуулдаг. Иргэдийн төлөөлөл маш бага хувьтай оролцдог. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын саналд саналаа өгөх хуулиар зохицуулагдсан боломжтой эрхтэй. Орон нутгийн хөгжлийн сан нь иргэдийн оролцоонд тулгуурласан төсөвлөлт ⁶ юм.
2.	Хороо	Тухайн жил бүрийн төсвийн хөрөнгө оруулалтын саналд хороо нь дээрээ тулгамдаж байгаа ихэвчлэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр богино хугацаанд хийгдэх ажлын саналуудыг өгдөг. Өгсөн саналууд нь судалгаа, төсөвгүй байдаг.
3.	Дүүрэг	Дүүргийн харьяа хэлтэс, нэгжүүд, хороод, харьяа хэлтэс нэгж, албан байгууллагуудаас авсан саналаа нэгтгэн жагсаалт хэлбэрээр хүргүүлдэг ба энэ шатанд үнэлгээ эрэмбэлэлт хийгддэггүй.
4.	Нийслэлийн Иргэдийн хурлын төлөөлөгч	Иргэдийн хурлын төлөөлөгч өөрийн сонгогдсон тойрогтоо шаардлагатай ажлуудын саналаа хороо иргэдээс аван нэгтгэн жагсаан хүргүүлдэг ба нарийвчилсан жагсаалт, эрэмбэлэлт хангалтгүй байдаг.
5.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь УБ хотын аж ахуйн асуудлыг хариуцах бөгөөд байгууллагын чиг үүргийн хүрээнд санал өгөхөөс илүү нийслэлийн төсөвт багцаар батлагдсан тохижилт, гэрэлтүүлэг, засварын ажлуудын худалдан авалтийг зохион байгуулж, тендер зарлаж хэрэгжүүлдэг. Ихэнх ажлууд нь багц дүнгээр нийслэлийн төсөвт суудаг тул зураг төсөвгүй тендерийг ихэвчлэн түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр эсвэл зураг төсөв боловсруулахаар зарлаж, хэрэгжүүлдэг нь хугацаа алдах шалтгаан болдог.
6.	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудаас ирүүлдэг хөрөнгө оруулалтын саналууд зөвхөн тухайн байгууллагын чиг үүргийн хүрээнд хамаарах саналуудаа харьяа хэлтэс нэгж, байгууллагуудаасаа аван нэгтгэн хүргүүлдэг. Мөн үйл ажиллагаа, чиглэлийн хувьд байгууллагуудын санал нь уялдаагүй, тодорхой

⁶ ОНХС-ын гарын авлага нь 5 үе шат бүрээр тус, тусдаа байдаг тул энэхүү гарын авлагад ОНХС-гийн асуудлыг авч үзээгүй болно.

		судалгаанд суурилж үндэслэлтэй боловсруулагддаггүй. Жишээ нь: зам тавих, газар шугам төлөвлөх, тохижилт хийх г.м
7.	Нийслэлийн өмчит төсөвт байгууллагууд	Нийслэлийн өмчит төсөвт байгууллагууд өөрсдийн байгууллагуудын чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад шаардлагатай болон тулгамдаж байгаа асуудлуудаа шийдвэрлүүлэх ажлуудын талаар саналаа өгдөг.

Нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага адилхан үйлчилдэг боловч Нийслэлийн өөрийн онцлогт тохируулан заасан дараах нийтлэг шаардлагууд бий. Үүнд:

- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан, ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх,
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх,
- Гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагатай хийсэн гэрээ хэлэлцээрийн хүрээнд Улаанбаатар хотын хүлээсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн байх,
- Амьдрах орчны зураглалд суурилсан байх,
- Эрүүл, аюулгүй байдлын индексэд суурилсан байх,
- Үр ашгийн тооцоолол болон ашиглалтын үеийн зардал, төсөвт үзүүлэх ачааллыг тооцоолсон байх,
- Тухайн төслийг хэрэгжүүлснээр Нийслэлийн төсвийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх, нийслэлийн эдийн засагт ямар нөлөөлөл үзүүлэх, өртгөө нөхөх тооцоолол хийсэн байх зэрэг болно.

3.3 Орон нутгийн төсөв төлөвлөх, батлах үйл явц

Улсын төсөв батлагдсаны дараа улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг буюу алдагдалтай төсөвтэй аймагт олгох улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ болон орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг аймаг, нийслэлд хүргүүлнэ. Орон нутаг төсөв хоорондын шилжүүлгийн дүнг өөрчлөхгүйгээр өөрийн төсвийн орлогоо нэмэгдүүлэх замаар зарлагаа нэмэх эсвэл орлогоо бууруулбал зарлагаа бууруулах боломжтой байдаг. Аймаг, нийслэлийн хувьд тухайн шатны Засаг дарга жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны ИТХ-даа өргөн мэдүүлж, 12 дугаар сарын 05-ны дотор ИТХ-аар төсвөө батлуулна.

Энэхүү төсөвт аймаг, нийслэлээс сум, дүүргийн төсөвт олгох шилжүүлгийн дүн, төвлөрүүлэх орлого батлагдах ба батлагдсан дүнг сум, дүүрэгтээ хүргүүлнэ. Сум, дүүргийн Засаг дарга шилжүүлгийн дүнг өөрчлөхгүйгээр тухайн шатныхаа жилийн төсвийн төслийг боловсруулан, 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатныхаа ИТХ-даа өргөн мэдүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор төсвөө батлуулдаг.

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх асуудлыг Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар зохицуулж байна. Уг журамд орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад баримтлах зарчим, орон нутгийн суурь төсвийн санал боловсруулах, төсвийн удирдамж, тусгай сангуудыг төлөвлөх, төсвийн тодотголын төсөл боловсруулах, төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах зэрэг асуудлыг тусгасан байдаг.

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аар батлагдах тухайн шатны жилийн төсвийн маягтыг Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 204 тоот тушаалаар батлагдсан загвар маягтаар батлан мөрдүүлж байна. Энэ хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтууд нь тус тусдаа хавсралтаар батлагдан хэрэгжиж байна. Мөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хэрэгжих төсөл, арга хэмжээ бүрээр нь, төсөл хэрэгжиж эхлэх болон дуусах хугацаа, төсөвт өртөг, тухайн жилд санхүүжих дүн зэргийг тодорхой тусган батлуулахаар зохицуулж өгсөн байна.

ИТХ-аар төсвийн төслийг хэлэлцүүлэх явцад хэрэв шинэ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал гарвал тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс төсвийн тухай хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана гэж хуульчлагдсан байна. Өөрөөр хэлбэл ИТХ-аар төсөв хэлэлцэгдэж байх үед хөрөнгө оруулалтын төсөл шинээр нэмэгдэх бол тухайн төслийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн эсэх, шаардлагатай бусад зөвшөөрөл нь олгогдсон эсэхийг нягтална. Мөн тухайн хөрөнгө оруулалт нь ашиглалтад орсноор урсгал зардал нэмэгдэх эсэх талаар холбогдох тооцооллыг хийгдсэн байх шаардлагатай бөгөөд хэрэв зардлыг нэмэгдүүлэхээр бол тэрхүү зардлыг ямар эх үүсвэрээр, хэрхэн шийдвэрлэх тооцоо, тайлбарыг авч үзэх шаардлагатай. Түүнчлэн хөрөнгө оруулалтын төслийг тусгахдаа эхний жилд тавигдах санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан дүнгээс багагүй байх шаардлагыг хуульчилсан байдаг.

Харин Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хувьд ИТХ-аар хэлэлцэх явцад иргэдийн саналыг аваагүй төслийг шинээр нэмж тусгах боломжгүй байна.

Эдгээрээс гадна төсвийн тухай хуулиар хуульчлагдсан орон нутгийн жилийн төсвийн төсөлд тавигдах үндсэн шаардлагын нэг нь чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх асуудал бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр, нийслэлийн газар нутагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтад:

- Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох;
- Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох;

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох;
- Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ;
- Үерийн хамгаалалт;
- Авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжуудыг бий болгох;
- Тохижилт, нийтийн эзэмшлийн ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг;
- Өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ зэрэг багтсан болно.

Төсвийн байгууллагын хувьд төсвийн төслөө боловсруулж, дээд шатны төсөвт нэгтгүүлэх үйл ажиллагааг хүснэгтэд дурдсан цаглабар, үе шатны дагуу зохион байгуулдаг.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар

Хариуцагч	Баримт бичиг	Төсвийн төслийн санал хүргүүлэх хугацаа	Төсвийн төсөл хүргүүлэх
Орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Байгууллагын суурь төсвийн санал		
Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор	Сум, дүүргийн Засаг даргад
Сум, дүүргийн Засаг дарга	Орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналын нэгтгэл	Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Төлөөлөн гүйцэтгэх гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор	Холбогдох ТЕЗ-д

	Орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	Сангийн яаманд
	Орон нутагт гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санал		
Сангийн яам	УИХ-д өргөн мэдүүлсэн орон нутгийн суурь төсвийн мэдээлэл	Жил бүрийн 10 дугаар сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, танилцуулгын хамт	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тухайн шатны төсвийн төсөл	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн аудитор
Аймаг, нийслэлийн аудитор	Жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлт	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Иргэдийн төлөөлөгчдийн хуралд
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Баллагдсан жилийн төсөв	Жил бүрийн 12 дугаар сарын 5-ны дотор	-
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тухайн шатны жилийн төсвийг нэгтгэл	Жил бүрийн 12 дугаар сарын 31-ны дотор	Сангийн яам

Эх сурвалж: Төсвийн тухай хууль

Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь нь төсвийн сар улирлын батлагдсан хуваарь юм. Иймд төсөв батлагдсаны дараа сум, дүүрэг нь батлагдсан төсвөө аймаг, нийслэлийн төсөвт нэгтгүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийг нэгтгэн үр дүнг 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлдэг.

МЭДЭЭЛЭЛ

Төсвийн хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг, сум, дүүргийн Засаг дарга сум, дүүргийнхээ жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэх болсон. Ингэснээр улсын төсвөөс олгогдсон санхүүжилтийн дүндээ багтаан санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийх замаар дансны үлдэгдлээ удирдах, хугацаа хэтэрсэн өр авлага үүсгэхгүйгээр төсөвтөө шийдвэр гаргах эрхтэй болсон.

Нийслэлийн төсөв: Орон нутгийн төсөв бөгөөд хотын шууд болон дүүргийн төсвөөс бүрдэнэ:

- *Хотын шууд төсөв: Улаанбаатар хотын харьяа төсөвт байгуулагын урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ.*
- *Дүүргийн төсөв: Тухайн дүүргийн харьяа төсөвт байгуулагын урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ.*

3.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлттэй холбоотой журмуудын хэрэглээ

Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах харилцааг зохицуулахад дараах **хоёр журмыг** мөрдлөг болгож байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”. Тус журмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслүүдийг төсвийн тухай хуульд тусгахад цахим системээр үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг зохицуулна. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөнд гол ашиглагдаж буй журам.
2. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам. Энэхүү журмаар дараах харилцааг зохицуулдаг.
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг **төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах** харилцааг.
 - Бусад эх үүсвэр болох орон нутгийн төсөв, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа хөрөнгө оруулалт, концессын гэрээний эргэн төлөлт, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг **санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад** энэ журмыг мөрдлөг болгоно.

Гэвч энэхүү журам нь УТХО-ын төлөвлөлт гэхээсээ илүүтэйгээр санхүүжилт, хяналт, тайлагналтад ашиглагддаг бөгөөд төлөвлөлттэй холбоотой харилцаанд Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан журам, аргачлалуудыг дагаж мөрддөг.

Эдгээр 2 журмыг дараах дэд хэсгүүдэд дэлгэрүүлэн авч үзье.


3.1.1 “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”

Энэхүү журам болон аргачлалын зорилго нь УТХО-аар хэрэгжүүлж буй болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлсний үндсэн дээр улсын төсөвт тусгах шийдвэр гаргах, төсвийн зардлыг бууруулах, төсвийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгоход оршино.

Урьд нь Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлдэг байсан бол Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд” батлагдсанаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төлөвлөх, үнэлэх хугацаа, боломж олгосон. Энэ нь төлөвлөлтийг төсвийн тухай хуулийн цаглабартай уялдуулахын зэрэгцээ олон улсад хэрэгжүүлдэг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын чиг хандлагад нийцэхэд чиглэсэн ахиц дэвшил болсон юм.

Монгол Улсын хэмжээнд өмнө нь УТХО-ын төслүүдийг ингэж тусгай шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлж сонгох ажиллагаа хийгддэггүй байсан бөгөөд энэхүү аргачлал, журам батлагдсанаар УТХО-ын үр ашигтай төлөвлөлтийг хийх боломжтой болсон. Түүнчлэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага (publicinvestment.gov.mn) цахим системийн тусламжтайгаар төслийн удирдлагыг хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм. Ингэснээр цахим системээр УТХО-ыг төлөвлөх, төслүүдийн гэрээг байгуулахаас эхлэн ашиглалтад орох хүртэлх санхүүжилт тус бүрийг цахим системээр хянах боломжтой болсон.


Зураг 7. Төслийг үнэлж, эрэмбэлэх журам, аргачлал



Эх сурвалж: Сангийн яам

Уг аргачлийн хүрээнд Үнэлэх, Эрэмблэх болон Сонгох гэсэн үе шаттайгаар 4-р сарын 01-ний өдрөөс 9-р сарын 30 хүртэлх хугацаанд төлөвлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Зураг 8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны үе шат



Эх сурвалж: Сангийн яам, НЗДТГ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад багтаах төслийг төлөвлөхдөө санхүү, эдийн засгийн шинжилгээнүүдийг хийж, холбогдох шалгууруудыг хангасан эсэхийг нягталж оноо өгнө. Ингэхдээ 1-3-р аргачлалыг ашиглан үнэлж, холбогдох сайжруулалтыг хийж ажиллана. Эдгээр аргачлалыг хэрхэн хэрэглэх тайлбар схемийг холбогдох цаглабарын хамт дараах зурагт харуулав.

Зураг 9. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалын тайлбар схем



Эх сурвалж: Сангийн яам

Дээрх зургыг дараах байдлаар дэлгэрэнгүй тайлбарлаж болно:

Хүснэгт 9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны цаглабар

ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ	
4 дүгээр сарын 1	Төсвийн төсөлд тусгах ШИНЭЭР хэрэгжүүлэх төслүүдэд эхний үе шат буюу үнэлгээ хийх тухай албан тоотыг холбогдох хавсралтын хамт СЯ-наас ТЕЗ нарт цахимаар болон хэвлэмэл байдлаар хүргүүлнэ.
4 дүгээр сарын 15	НЗДТГ-аас хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах аргачлалын сургалтыг 4 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэд зориулан зохион байгуулж, гарын авлагаар хангана.
5 дугаар сарын 1	Нийслэлийн хувьд НЗДТГ нь нийслэлд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийн саналыг нэгтгэн холбогдох ТЕЗ нарт 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлдэг.
6 дугаар сарын 1	ТЕЗ нар нь Аргачлал 2, 3-т заасны дагуу цахим системд үнэлж, ШИНЭЭР барих барилга, байгууламжийн төслийн жагсаалт болон “нөөцийн жагсаалт” систем дээр үүсэх бөгөөд СЯ-нд илгээж, албан бичгээр давхар явуулдаг. <ul style="list-style-type: none"> Аргачлал 2. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээ, Аргачлал 3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал /эхний 7 шалгуураар үнэлж, эрэмбэлнэ/.
7 дугаар сарын 5	СЯ-наас үнэлгээ хийгдсэн төслүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийж сонгох жагсаалтад орсон, дараагийн шатны үнэлгээнд хамаарах төслүүдийг,

	төсвийн удирдамжийн хамт 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор ТЕЗ нарт хүргүүднэ.
8 дугаар сарын 1	НЗДТГ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас улсын төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв болон шилжих барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсвийн санал авч нэгтгэн холбогдох ТЕЗ нарт 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлсэн байна. ТЕЗ нар ирүүлсэн төслийн саналыг цахим системийн тусламжтайгаар үнэлгээ, эрэмбэлэлтийг хийсэн байна.
ТӨСЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ ҮЕ ШАТ	
8 дугаар сарын 15	ТЕЗ нар нь нийт төслийн жагсаалт (үүнд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж болон бусад шинэ төсөл)-ыг төслийг сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч, эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах санал бэлтгэнэ. Ингэхдээ Аргачлал 3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалын сүүлийн 9 шалгуураар үнэлж, эрэмбэлнэ. Төслүүдийг оноогоор эрэмбэлж, төсөвт суулгах дарааллаар жагсаан 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор СЯ-д бичгээр хүргүүлэх ба цахим систем дээр мэдээлэл нь давхар хадгалагдсан байна.
9 дүгээр сарын 15	ТЕЗ нараас ирүүлсэн төслүүдийг СЯ сонгох шалгуур үзүүлэлтийн оноог өгч эрэмбэлж төсвийн төсөлд тусгах нэгдсэн жагсаалтыг боловсруулж, 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулна.
10 дугаар сарын 1	Засгийн газраас УИХ-д төсвийн төслийн төслийг өргөн барина.

Төслийг эрэмбэлэхийн тулд өмнө дурдсан шаардлагуудыг хангасан эсэхэд оноо өгч төсөл бүрийг үнэлнэ. Ингэж оноогоор үнэлэхдээ ТЕЗ болон СЯ нь тус тусын оноог нэгтгэснээр төслүүдийг эрэмбэлж, сонголт хийх боломж бүрдэнэ. Доорх хүснэгтэд үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаанд ашигладаг онооны системийг нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, онооны систем

Үе шат	Шалгуур үзүүлэлт	ТЕЗ			СЯ			
		Оноо	Жин	Дүн	Оноо	Жин	Дүн	
I. Үнэлэх	1-1	Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	5	1.5	7.5	5	1.5	7.5
	1-2	Бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эсэх	5	2.5	12.5	5	2.5	12.5
	1-3	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол	5	3	15	5	3	15
	1-4	Төслийн хүчин чадлын ашиглалт	5	2.5	12.5	5	2.5	12.5
	1-5	Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	1-6	Төслийн болзошгүй эрсдэл	5	2	10	5	2	10
	1-7	Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	5	2	10	5	2	10
Нийт:				82.5			82.5	

Ц. Сонгох	2-1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал	5	1	5	5	1	5
	2-2	Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд нийцэж буй байдал	5	1	5	5	1	5
	2-3	Тухайн жилийн үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал	5	1	5	5	1	5
	2-4	Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	2-5	Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	5	1.5	7.5	5	1.5	7.5
	2-6	Урсгал зардлыг тогтвортой санхүүжүүлэх боломжтой эсэх, төсөвт өгөх ачаалал	5	1	5	5	1	5
	2-7	Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	5	2.5	12.5	5	2.5	12.5
	2-8	Төслийг хэрэгжүүлэх бусад нөхцөл бүрдсэн эсэх	5	1.5	7.5	5	1.5	7.5
	2-9	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрэмбэлсэн байдал	5	1	5	5	1	5
Нийт:				67.5			67.5	

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн хувьд хөрөнгө оруулалтын төрлөөс хамаараад аргачлалыг ялгавартайгаар хэрэгжүүлж байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалуудын ашиглалт

Шилжих төслүүд	Шинээр хэрэгжих барилга, байгууламж	Шинээр хэрэгжих бусад төсөл /их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ/
Аргачлал 1. Шилжих төслүүдийг дахин үнэлэх аргачлал	Аргачлал 2. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал Аргачлал 3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал	Аргачлал 3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал ЗГ-ын 2021 оны 160 тоот тогтоолд заасан шалгуур

Иймд журмын хавсралтаар батлагдсан аргачлал тус бүрийг дараах хэсэгт дэлгэрүүлэн танилцуулж, эдгээрийн онцлог, хэрхэн хэрэглэгддэгийг танилцуулах болно.

Аргачлал 1. УТХО-аар он дамжин хэрэгжих буюу шилжих төслийг дахин үнэлэх аргачлал

ТЕЗ нар улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төслөө 7 дугаар сарын 5-ны өдрөөс 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор саналаа боловсруулж, Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалын 2 дугаар хавсралт буюу Аргачлал 1-ийн дагуу үнэлж хүргүүлнэ.

Улсын төсвөөр хэрэгжиж байгаа бүх шилжих төслүүдийг үнэлж, эрэмбэлснээр дараа жилийн төсөвт суулган үргэлжлүүлэх, тохируулга хийх эсвэл төслийг зогсоох зэрэг шийдвэр гаргадаг.

Төслийг дахин үнэлэх үйл ажиллагаа нь 3 үе шаттай хийгдэнэ.

1. Төслийг ангилах
2. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
3. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх

ТЕЗ нь улсын хөрөнгө оруулалтын удирдлагын системийн “шилжих төслүүдийг үнэлэх” цэсийг сонгож ажиллах ба дахин үнэлэхэд шаардлагатай, мэдээллийг оруулахад систем боловсруулалт хийж, төслүүдийг “**хэвийн**” болон “**эргэлзээтэй**” гэсэн хоёр тусдаа цэсэнд ангилж харуулна.

Хэдий эргэлзээтэй ангилалд орсон ч дараах нөхцөлд хамаарах төслийг төсөвт тусгах саналаа ТЕЗ нь СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж болно. Үүнд:

1. Олон улсын болон бусад гэрээгээр зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төсөл;
2. Төслийн ажлын гүйцэтгэл 80-аас дээш хувьтай;
3. Төслийн санхүүжилтийн гүйцэтгэл 80-аас дээш хувьтай


ТЕЗ нь эргэлзээтэй ангилалд орсон төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 хувилбараас сонгохдоо шууд аль нэг хувилбарыг сонгохоос илүүтэйгээр хувилбар тус бүрийг харьцуулан үзэх нь зүйтэй. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд аль ч хувилбарыг сонгосон систем нь дараах мэдээллийг шаардана. Үүнд:

- i) төслийн ерөнхий мэдээлэл
- ii) хувилбарыг сонгосон үндэслэл, хүлээгдэж буй үр дүн, зардал, хугацаа, хөрөнгө зэрэг ирээдүй рүү чиглэсэн мэдээллүүд
- iii) тус хувилбараас үүдэн гарах үр дагаварын талаарх тайлбар мэдээлэл, тэдгээрийг нотлох баримт, бусад хавсралт материалыг оруулна.

Эргэлзээтэй ангилалтай төслийг шинэчлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналын маягт, Эргэлзээтэй ангилалтай төслийг хойшлуулах төлөвлөгөөний саналын маягт, Эргэлзээтэй ангилалтай төслийг хаах төлөвлөгөөний саналын маягт нь цахим систем дээр байх бөгөөд эдгээр маягтыг “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл,

арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон холбогдох аргачлалуудыг хэрэгжүүлэх гарын авлагаас дэлгэрүүлэн харах боломжтой.

Зураг 10. Төслийг дахин үнэлэх Аргачлал 1-ийн үйл ажиллагааны зураглал



Эх сурвалж: Сангийн яам

Аргачлал 2. Шинээр эхлэх барилга байгууламжийн төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал


Шинээр барих барилга, байгууламжийн хувьд Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг Аргачлал 2-ын дагуу заавал хийнэ.

Аймаг, нийслэлийн ЗД-ын оруулсан мэдээллийг холбогдох ТЕЗ нар 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 1-нийг хүртэл аргачлалын дагуу цахим системд үнэлж, төслийн жагсаалтыг 6 дугаар сарын 1-ний дотор СЯ-д хүргүүлдэг.

Тухайн төсвийн жилд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийг гурван үе шаттай үнэлдэг. Үүнд:

- 1. Аймаг, нийслэл:** Орон нутгийн ТЕЗ нар нутгийн захиргааны харьяа байгууллагаас 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрийн хооронд СЯ-ны “Шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийх тухай” албан тоот, удирдамж, маягтын дагуу MS Excel хэлбэр болон бичгээр санал авч, холбогдох мэдээллийг системд оруулдаг. Ингэхдээ орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт тусгагдсан төсөл мөн эсэхийг харгалзаж үзнэ.
- 2. Яам, агентлаг:** Аймаг, нийслэлээс ирүүлсэн саналыг нэгтгэж салбарын бодлого, төлөвлөлтийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслүүдийг үнэлж, тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор СЯ-д хүргүүлнэ.
- 3. Сангийн яам:** Урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх эхний шат нь Аргачлал 2-ын дагуу тухайн төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тодорхойлж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлж, 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор ТЕЗ-д 2 дахь шатны үнэлгээг хийлгүүлэхээр хүргүүлнэ.

Зураг 11. Төслийг үнэлэх Аргачлал 2-ын оролцогч талууд, цаг хугацааны зураглал




Шинээр барих барилга, байгууламжийн хувьд Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг Аргачлал 2-ын дагуу заавал хийнэ. Тухайн төслийн нийт өртгөөс хамааран улс, аймаг, нийслэл, сум дүүргийн ТЕЗ нь тохирох аргачлалыг сонгож (Зураг 12), СЯ-ны Улсын хөрөнгө оруулалтын цахим системийн “төслийн дэлгэрэнгүй мэдээлэл” цэсийн холбогдох талбарт шаардлагатай тоон болон чанарын мэдээллийг оруулж, нотлох баримтыг файлаар хавсаргахаас гадна СЯ-д бичгээр хүргүүлдэг.

- Зардал, үр ашгийн шинжилгээ:** Тухайн төслийн санхүү, эсхүл эдийн засгийн үр ашиг, зардлын зөрүүг тооцож тогтсон жишиг үзүүлэлттэй харьцуулж, хамгийн

ашигтай төслийг тодорхойлж эрэмбэлнэ. Тус шинжилгээг 30 тэрбумаас дээш төсөвт өртөг бүхий том төслүүдэд ашигладаг. Хялбаршуулсан шинжилгээнд ТЭЗҮ шаардахгүй.

- **Зардал, үр дүнгийн шинжилгээ болон хамгийн бага зардлын шинжилгээ:** Хамгийн бага зардлаар тавьсан зорилт, үр дүнд хүрэх төслийн хувилбарыг тэргүүн эгнээнд авч үздэг.

Зураг 12. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээний зураглал



Эх сурвалж: Сангийн яам

Шинжилгээг хийхдээ тухайн салбарын онцлог байдлыг харгалзан үзэж шаардагдах үзүүлэлт, маягтуудыг татах, тохируулж сайжруулах боломжтой байдлаар цахим системийг хөгжүүлсэн байна.

Аргачлал 3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал

Уг аргачлалыг үнэлэх болон сонгох 2 үе шатын аль алинд ашиглана. Шинжилгээ болон суурь мэдээллүүдэд тулгуурлан 1 дүгээр үе шатанд 7 шалгуур үзүүлэлтээр **хэрэгцээ шаардлагад** оноо өгч үнэлдэг бол, 2 дугаар шатанд Шинжилгээ болон суурь мэдээллүүдэд тулгуурлан 9 шалгуур үзүүлэлтээр **бэлэн байдалд** оноо өгч сонгоход ашиглана.

ТЕЗ нар УТХО-аар хэрэгжүүлэх шинээр барих барилга байгууламж, шилжих төслийн мэдээллээ СЯ-ны хөрөнгө оруулалтын цахим системд оруулж, холбогдох баримт бичгүүдийг хавсарган, системийн тусламжтайгаар дээрх аргачлалуудаар үнэлж, эрэмбэлж, сонгон төсөвт суулгадаг. Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байх ёстой. Хэрэв төслийг энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлээгүй тохиолдолд улсын төсөвт тусгахаас татгалзах үндэслэл болно.

Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд оролцогч талуудын чиг үүрэг

№	Оролцогч тал	Чиг үүрэг
1.	Аймаг нийслэлийн Засаг дарга	Журам аргачлалын дагуу төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн сонгосны үндсэн дээр ТЕЗ-д хүргүүлнэ.
2.	ТЕЗ-ийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсхүл мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> • Төслийн саналыг үнэлэхдээ аргачлалын дагуу цахим системд тулгуурлан гүйцэтгэнэ. • Төслийн саналд журамд заасны дагуу судалгаа хийж үнэлэх, эрэмбэлэх, сонгох жагсаалт гаргах • Төслийн сонгон шалгаруулах үнэлгээг хийх 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсгийг байгуулан хурал хэлэлцүүлэг хийх. Бүрэлдэхүүнд заавал байх этгээд: <ul style="list-style-type: none"> ○ тухайн байгууллагын газар, хэлтэс ○ дэд бүтцийн байгууллага, холбогдох этгээд ○ тухайн төсөл нь бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдаатай бол холбогдох байгууллагын төлөөлөл ○ холбогдох хот төлөвлөлт, газрын асуудал хариуцсан алба, нэгж. • Ажлын хэсэг нь нийт төслийн жагсаалтыг гаргахдаа нэгдсэн шийдвэр гаргах ба хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хавсаргана. • Журмын гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлэх • СЯ-тай хамтран ажиллах, хэрэгжилтийг тайлагнах • Төслийн саналыг төсвийн төсөлд тусгуулахаар СЯ-д хүргүүлэх;

3.	Сангийн яам	<p>СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төслийн төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтыг хариуцаж ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> • Саналыг хүлээн авах нэгтгэх • Саналуудыг эрэмбэлэх, дүгнэлт гаргах • Холбогдох мэдээллийг шаардлагатай газруудаас гаргуулж авах • Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх • Цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх
----	-------------	---

3.1.2 “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 160 тоот тогтоолоор шинэчлэн⁷ батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон санхүүжилтийн удирдлагыг боловсронгуй болгох замаар төсвийн зардлыг бууруулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

Уг журмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламж, их засвар, зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмж зэрэг төслүүдийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах харилцааг зохицуулахаас гадна бусад төсвийн эх үүсвэр болох орон нутгийн төсөв, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа хөрөнгө оруулалт, концессын гэрээний эргэн төлөлт, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад бас мөрдлөг болгоно. Журам нь нийт 6 бүлэг, 17 зүйл болон 17 хавсралттай.

Хүснэгт 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалуудын ашиглалт

Бүлэг	Хамрах хүрээ
I бүлэг. Нийтлэг үндэслэл	<ul style="list-style-type: none"> • Зорилго, хамрах хүрээ • Хууль эрх зүйн орчин
II бүлэг. Эрх бүхий байгууллагын чиг үүрэг	<ul style="list-style-type: none"> • Эрх бүхий байгууллагын чиг үүрэг • Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх • Захиалагчийн чиг үүрэг
III бүлэг. Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Төсөл, арга хэмжээний төлөвлөлт • Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага • Төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгах

⁷ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчилсэн.

IV бүлэг. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн баримт бичиг	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн ерөнхий зохицуулалт • Барилга байгууламжийн ажлын санхүүжилт • Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилт • Зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилт • Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт
V бүлэг. Ил тод байдал, хяналт, тайлагналт, үр дүн	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн ил тод байдал • Хяналт • Тайлагналт, үр дүн
VI бүлэг. Бусад зүйл	Бусад зүйл

Журмын хавсралтууд:

- 1) Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн маягт
- 2) Барилга угсралт, их засварын ажлын хяналтын хуудас
- 3) Худалдан авах барилга байгууламжийн санхүүжилтийн хяналтын хуудас
- 4) Концессын гэрээний эргэн төлөлтийн хяналтын хуудас
- 5) Зөвлөх үйлчилгээний хяналтын хуудас
- 6) Тоног төхөөрөмжийн хяналтын хуудас
- 7) Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга угсралтын ажлын санхүүжилтийн хүсэлтийн маягт
- 8) Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн маягт
- 9) ажлын барилга угсралт/их засварын ажлын үе шатны ажлын хуваарь
- 10) Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн -р сарын мэдээ
- 11) Тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын акт
- 12) Гэрээ дүгнэх маягт
- 13) Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн өмнөх онд ашиглалтад орсон барилга байгууламжийн талаарх хүснэгтэн мэдээ
- 14) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгжээс төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид санхүүжилтийн эрх нээж хүргүүлэх маягт №1
- 15) Санхүүжилтийн хүсэлтийн маягт №1
- 16) Зураг төсөл зохиогчийн ба хяналтын зардлын гүйцэтгэлийн нэгдсэн акт №
- 17) “Санхүүжилтийн төлбөрийн хүсэлтийн маягт”


Энэхүү журмын тухай төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ. Учир нь өмнө дурдсанчлан энэхүү журмыг санхүүжилт, хяналт, тайлагналтад түлхүү ашигладаг бөгөөд төлөвлөлтийн шатанд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан холбогдох журам, аргачлалуудыг ашигладаг.

БҮЛЭГ 4. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

4.1 Гадаад зээл, тусламжийн төслүүдийн онцлог

Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын банк санхүүгийн байгууллага, гадаад улс орны засгийн газар, хөгжлийн байгууллагуудаас хүлээн авсан зээл, тусламжийн санхүүжилт нь хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх нэг гол эх үүсвэр болдог. Иймд зээл, тусламжийн санхүүжилтээр төслийг хэрхэн хэрэгжүүлдэг талаар авч үзье.

Зураг 13. Гадаад зээл, тусламжийн батлагдсан дүн /гэрбум ₮/




Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Засгийн газрын шугамаар хүлээн авсан зээлийг дотор нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор хүлээн авсан бол төслийн зээл, улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор хүлээн авсан бол хөтөлбөрийн зээл гэж ангилдаг.

Манай улсад төсөл хэрэгжүүлэх зорилгоор хүлээн авсан зээлийн ашиглалт 2005-2015 оны хооронд тогтвортой байсан ба 2016 оноос 2 дахин нэмэгдэж, 2019 он гэхэд жилд 1.2 их наяд төгрөгт хүрч нэрлэсэн дүнгээр 3 дахин өссөн. Гэхдээ ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь харьцангуй тогтвортой буюу 3%-иас хэтрээгүй байна.

Зураг 14. Төслийн зээлийн ашиглалт, салбараар (2005-2019), тэрбум ₮



Монгол Улсын 2005-2019 онуудад ашигласан гадаад төслийн зээлийн дийлэнх нь буюу 66.1%-ийг дэд бүтэц, эрчим хүч, хотын хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалтад зарцуулжээ. Тухайлбал, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт хамгийн өндөр буюу нийт ашигласан зээлийн 42.9%, хотын хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтад 11.9%, эрчим хүчний хангамжийг сайжруулах хөрөнгө оруулалтад 11.4%-ийг тус тус зарцуулжээ. Үүнээс гадна эрүүл мэндийн салбарыг дэмжих зээлд 7.2%, хөдөө аж ахуйн салбарыг дэмжсэн

зээлд 6.5%-ийг тус тус зарцуулсан байна.

Гадаадын зээл болон тусламжаар хэрэгжих төсөл нь улсын болон орон нутгийн төсөвт тусгагдан хэрэгждэг. Гадаадын тусламж нь төсвийн орлого болон зарлага талд зэрэг тусгагддаг тул төсвийн алдагдалд нөлөө үзүүлдэггүй. Харин гадаад зээл нь санхүүжилтийн эх үүсвэр хэсэгт тусгагдаж, харин зээлээр хэрэгжих төсөл нь зарлага талдаа тусгагдана. Ингэснээр зээлийн дүнгээр төсвийн алдагдлыг нэмэгдүүлдэг байна.

Иймд тухайн жилд авч хэрэгжүүлэх зээлийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт нь төсвийн алдагдлаар хязгаарлагдах төдийгүй урт болон дунд хугацаанд Монгол Улсын нийт өрийн хязгаарт нийцсэн байх зарчим үйлчилдэг байна.

Мөн гадаад зээл, тусламж нь ямар төсөл хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан төсвийн эдийн засгийн ангилалд хуваагдан батлагддаг. Тухайлбал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал болон аймаг, нийслэлд дамжуулан зээлдүүлж буй эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл гэсэн 3 зардалд хуваагдаж, төлөвлөгддөг байна.

Үүнээс, хөрөнгө оруулалтын зардал болон эргэн төлөгдөх нөхцөлтэй орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлээр нь хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2022 оны төсөвт батлагдсан нийт гадаад зээл, тусламжийн 14 хувийг урсгал зардлыг санхүүжүүлэхээр, 86 хувийг нь хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэхээр хөрөнгийн зардал болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд төлөвлөжээ. Мөн улсын хэмжээний төсвийн хөрөнгийн зардлын 25 орчим хувийг нь гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалт бүрдүүлдэг тооцоо бий.

Зээлийн төслийг төлөвлөх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 1 дүээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, ара хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-аар зохицуулна. Харин тусламжийн эх үүсвэрээр төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн

газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар зохицуулж байна.

4.2 Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт

Засгийн газрын шугамаар авч буй зээл нь төлөгдөж дуусталаа улсын өрд бүртгэгддэг. Иймд зээлийг хүлээн авахтай холбоотой асуудал нь Өрийн удирдлагын тухай хууль, түүнийг дагаж гарсан холбогдох журмын хүрээнд зохион байгуулагдана.

Өрийн удирдлагын тухай хуулиар гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг зээлдэгчид тавьж, хэлэлцээр хийх эрхийг СЯ-д олгосон байдаг. Гэхдээ төслийн санал бэлтгэх, санал гаргах асуудал нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагаасаа эхлэх бөгөөд дараах 3 үе шаттайгаар боловсруулагдана. Үүнд:

Эхний үе шат. Гадаад зээлийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх саналыг төсөл хэрэгжүүлэх байгууллага эхлэн боловсруулах бөгөөд ингэхдээ Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, ара хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 5 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг уг журмын 12 дугаар хавсралтад заасан Төсөл, арга хэмжээний саналын баримт бичгийн үлгэрчилсэн загварын дагуу боловсруулж харьяалах төрийн захиргааны төв байгууллагад 8 дугаар сарын 01-ний дотор хүргүүлдэг.

Хоёр дахь үе шат. Энэ шатанд харьяалах төрийн захиргааны төв байгууллага нь шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг салбарын хөгжлийн бодлого, зорилт, тэргүүлэх чиглэл, өмнө хэрэгжсэн төслүүдтэй уялдуулах, давхардуулахгүй байх, салбарын болон салбар хоорондын зохицуулалтыг хангах үүргийн дагуу хянан, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлнэ. Мөн төслийн танилцуулгын хамт боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчийн албан бичгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Гурав дахь үе шат. Энэ шатанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ТЕЗ-аас ирүүлсэн гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал нь холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлах бөгөөд дараах арга хэмжээг авдаг байна. Үүнд:

1. Зээлийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөрөнгө оруулалтын төсөл нь өрийн удирдлагын хуульд заасан тодорхой шаардлагууд болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтална.
 - Тухайн жилийн төсөвт тусгагдсан байх: Төсвийн тухай хуулийн төсөв боловсруулах цаглабарын дагуу ТЕЗ-аас 8 дугаар сарын 15-ны дотор СЯ-д ирүүлдэг. Жилийн төсвийн төслийн саналд тухайн төсөл нь тусгагдаж ирсэн эсэх, хянагдаж зээл, тусламжаар хэрэгжих төслийн жагсаалтад тусгагдсан эсэхийг нягтална.

Мөн ТЕЗ-аас ирэх зээлийн төслийн санал нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх зээлийн зардлын ангиллаар боловсруулагдсан байхыг шаарддаг.

- Дунд хугацааны ТХМ-д нийцсэн байх: Төсвийн тухай хуульд тусгагдсан цаглабарын дагуу 6 дугаар сарын 01-ний дотор УИХ-аар батлагддаг дунд хугацааны ТХМ болон Засгийн газраар батлагддаг зарлагын хязгаарын суурь төсөв, зээлийн санхүүжилтээр хэрэгжих төслийн жагсаалтад тухайн төсөл нь тусгагдсан эсэхийг нягталдаг.

Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр журамд төсөл хэрэгжүүлэгч байгууллагын харьяалах ТЕЗ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн саналыг Төслийн удирдах хороогоор батлуулсан төсөл, арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хамт жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор СЯ-д хүргүүлэхээр заасан нь зээлийн төслийг ТХМ-д тусгах боломжийг олгосон байна.

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байх: Энэ хүрээнд зээлийн төсөл нь урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй хэрхэн уялдсан байх, нэн тэргүүнд зээлийн төслийн санал нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан эсэхийг нягталдаг. ТЕЗ-даас ирүүлсэн саналууд тэргүүлэх ач холбогдлоороо эрэмбэлэгдсэн эсэхийг нягталж үздэг байна.
- Зээл олгож байгаа гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллага болох хөгжлийн түншийн хамтын ажиллагааны бодлого, стратегитай хэрэгжүүлэх төсөл нь нийцсэн байх: Зээлдэгч улс орнуудын хамтын ажиллагааны бодлого, стратегитай хэрэгжүүлэх зээлийн төслийн санал нь нийцэхгүй бол хэлэлцээр амжилтгүй болдог. Иймд ямар төслийг аль зээлдэгчид тавихаар санал хүргүүлэхээ зээл хүлээн авах байгууллага нь төсөл боловсруулах шатандаа анхаарч, судалсан байх шаардлагатай.
- Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг хийж баталгаажуулсан, барилгын ажил гүйцэтгэх бол газрын асуудлыг шийдвэрлэсэн байх: Хамгийн чухал шаардлага бөгөөд төслийг цааш үргэлжлүүлэн хэлэлцэх эсэхэд шууд нөлөөлдөг төдийгүй төсөл амжилттай хэрэгжих урьдач нөхцөл нь болдог.
- Төсөлтэй холбоотой татвар, төлбөр, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрхэн шийдвэрлэх болон төсөл, арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгийн тооцоог эх үүсвэр тус бүрээр тухайлбал, улсын төсвөөс үү? эсвэл орон нутгийн төсөв, өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн үү? гэдгийг хамт тооцон ирүүлсэн эсэхийг нягталдаг.
- Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх шаардлагатай болно.

2. Дээрх шаардлагуудыг нягталж үзээд СЯ-аас шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний саналыг санал ирүүлсэн харьяалах төрийн захиргааны төв байгууллагад 30 хоногийн дотор буцаадаг.
3. Шаардлага хангасан төсөл, арга хэмжээний саналыг Засгийн газрын гадаад зээлийн нэгдсэн бодлого, удирдлага, Засгийн газрын өрийн удирдлагын стратеги, хөгжлийн түншийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлд нийцүүлэн эрэмбэлж, Өрийн удирдлагын тухай хуулийн 23.1 болон 24.1-д заасны дагуу тодорхойлон Засгийн газарт хүргүүлдэг байна.

Дөрөв дэх үе шат. Хэрэв төсөл, арга хэмжээний саналыг Засгийн газар дэмжсэн бол гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг СЯ-наас зээлдэгч талд тавьж, хэлэлцээр хийнэ. Ингэхдээ Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан дагуу арга хэмжээ авдаг ба төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээг байгуулахтай холбогдон гарах зардлыг хариуцна.

УХОХ нь Засгийн газраар батлагддаг тул тус хөтөлбөрт тусгагдан батлагдсан гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг СЯ-наас хөгжлийн түнш байгууллагад хууль, тогтоомжийн хүрээнд санал болгож болдог байна.

Хэрэв зээлийн төслийн саналыг Засгийн газар дэмжээгүй бол санал ирүүлсэн төслийн харьяалах төрийн захиргааны төв байгууллагад буцаана.

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зорилго, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, эргэн төлөгдөх чадвараас нь хамааруулж эх үүсвэрийг шууд төсөлд нь санхүүжүүлэх эсвэл дамжуулан зээлдүүлэх боломжтой. Хэрэв зээлийг дамжуулан зээлдүүлэх бол тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээлийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх төдийгүй дамжуулан зээлдүүлж байгаа зээлийн төслийн гэрээний хугацаа нь үндсэн зээлийн гэрээний хугацаанаас ихгүй байх шаардлага тавигдана. Дамжуулан зээлдэх эх үүсвэрээс ихэвчлэн орон нутагт хэрэгжүүлж буй төслүүд болон эрчим хүчний салбарын томоохон төслүүд санхүүжиж байна.

Хэрэв олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газрын гадаад зээлийн гэрээ, хэлэлцээр нь тухайн төсвийн жилийн дундуур байгуулагдсан бол уг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47.1.2-т заасныг үндэслэн нэмэлт төсөвт тусган хэрэгжүүлэхээр зохицуулж өгдөг.

БҮЛЭГ 5. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

5.1 ТХХТ-ийн төслийн эрхзүйн орчин

УИХ-аас 2009 онд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг” батлагдаж, үүний дагуу Концессын тухай хуулийг 2010 онд баталснаар Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) талаарх эрх зүйн орчин, бодлого тодорхой хэмжээгээр бий болсон.

Концессын тухай хууль 2010 оноос хэрэгжсэнээр өдгөө 10 гаруй жил болж байгаа боловч Концесс, ТХХТ-ийн хөгжил сул хэвээр л байна. Түүнчлэн, бусад улсад төдийлөн хэрэглэдэггүй, эргээд төсөвт дарамт болох 23 их наяд төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий “Барих-шилжүүлэх”, “Барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн төслүүд нь ТХХТ-ийн үндсэн зарчмаас зөрүүтэй бөгөөд түлхүүр гардуулах гэрээ маягтай боловч, нэмэлт хүүгийн болон менежментийн өндөр зардлыг төр хариуцахаар хийгдсэн зэрэг дутагдалтай тал байсаар байна. Иймд концесс гэж ерөнхийд нь нэрлэдэг өнөөгийн ТХХТ нь манай улсын хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцооны нэг сул болжээ.

Иймд Концессын тухай хуулийг ТХХТ-ийн суурь зарчим, үндсэн ойлголтууд болох түншлэлийг төлөвлөх, сонгох, эрсдэлийг тооцож, хуваарилах зэрэг асуудлыг бүрэн гүйцэд зохицуулдаг болгох, хувийн хэвшлийн оролцоог бүрэн хангаж чаддаг болгох зорилгоор хүчингүй болгож, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бүхий төслийг СЯ-наас боловсруулж батлуулах ажил хийгдэж байна. ТХХТ-ийн шинэ хуулийн хүрээнд төрөөс үзүүлдэг үйлчилгээ, дэд бүтцийн томоохон төслүүдийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдэнэ. ТХХТ-ийн хуулийн онцлог нь “Барих-шилжүүлэх” төрлийг дахин санхүүжүүлэхгүй байхаар тусгасан байна. ТХХТ-ийн гэрээнд ашиглалтын зардлыг Засгийн газар, хэрэглэгч, эсвэл холимог байдлаар хариуцах төрөлтэй байх бөгөөд дан ганц дэд бүтцийн салбар төдийгүй боловсрол, сургуулийн үйлчилгээг үзүүлэх боломжийг олгох юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Концессын хуулийн дагуу "концесс" гэж төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор Концессын гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрхийг хэлэх бөгөөд “концессын зүйл” гэж концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгасан төсөл юм гэж тодорхойлохоор байна.

Концесс нь дараах төрөлтэй байж болно гэж заажээ. Үүнд:

1. "Барих-ашиглах-шилжүүлэх": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан

- хугацаанд ашиглан, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;
2. "Барих-шилжүүлэх": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;
3. "Барих-өмчлөх-ашиглах": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр өмчлөх, ашиглах эрх эдэлж, үүрэг хүлээх;
4. "Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан хугацаанд өмчлөн ашиглаж, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;
5. "Барих-түрээслэх-шилжүүлэх": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдэд санхүүгийн түрээсээр эзэмшүүлэх, түрээсийн хугацаа дуусгавар болоход төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;
6. "Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах": Концесс эзэмшигч нь концессын зүйлийн зураг төслийг боловсруулан өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж гэрээнд заасан хугацаанд ашиглан, хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;
7. "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх": Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр шинэчлэн сайжруулж гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг шинэчлэн сайжруулсан зүйлийн хамт төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх төрөл юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу төлөвлөлт хэрхэн хийгдэж байгаа тухай энэхүү бүлэгт авч үзье.


5.2 Төрийн өмчийн концессын төслийн төлөвлөлт

Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдэл нь өөрийн санаачилгаар концессын гэрээ байгуулах төслийн саналаа зардал, үр ашгийн тооцооны хамт холбогдох Засгийн газрын гишүүнд ирүүлж болно. ТЭЗ нь уг концессын зүйлийн саналыг судалж, эсвэл өөрөө салбарын бодлогын хүрээнд шинээр төслийн санал боловсруулж, ЭЗХЯ-д хуулийн шаардлагад нийцүүлэн хүргүүлнэ. ЭЗХЯ нь концессын зүйлийн жагсаалтын талаар судалгаа хийж, санал боловсруулан, саналаа хуулийн шаардлагад нийцүүлэн зардал, үр ашгийн тооцооны хамт боловсруулж, төсвийн дэмжлэг шаардлагатай бол СЯ-наас санал, зөвшөөрөл авсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлнэ.

Засгийн газар нь 2013 оны 317 дугаар тогтоолоороо төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батласан. Одоо энэхүү тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар төлөвлөлтийг хийж байна. Уг жагсаалт нь концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ, төсвийн хөрөнгөөр санхүүгийн

дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх, уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэхийг тусгасан байдаг.

Зураг 15. Төрийн өмчийн концессын төслийн төлөвлөлт



Засгийн газрын тогтоолд заасан дээрх мэдээлэл, шаардлагын дагуу ЭЗХЯ нь Концессын тухай хуулийн 11-17 дугаар зүйлд заасны дагуу уралдаант шалгаруулалтын баримт бичгийг төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, уралдаант шалгаруулалтыг зарлах, түүнийг зохион байгуулж дүгнэх, оролцогчтой хэлэлцээр хийх, концессын гэрээ болон түүнтэй холбоотой бусад гэрээ, тухайлбал, концесс эзэмшигч санхүүжилт олохтой холбогдсон гэрээг концесс эзэмшигч болон бусад этгээдтэй байгуулах, шаардлагатай тохиолдолд хоёр шаттай төслийн санал гаргах, хуулийн шаардлагад нийцүүлэн шууд гэрээ байгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч Засгийн газарт гэрээний төслийг, гэрээ байгуулах эрх авах Засгийн газрын тогтоолын төслийг хүргүүлнэ.

Засгийн газар концессын гэрээ байгуулахыг дэмжээгүй бол хэлэлцээрийг дахин хийх эсэх, эсхүл уралдаант шалгаруулалтыг дахин явуулах эсэх шийдвэрийн аль нэгийг гаргана. Засгийн газар нь ЭЗХЯ-аас ирүүлсэн концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг ЭЗХЯ-т олгоно. ЭЗХЯ нь холбогдох журмын дагуу концесс эзэмшигчээс концессын гэрээний ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулан авч, нэгтгэн СЯ-д хүргүүлнэ.


5.3 Орон нутгийн концессын зүйлийн төлөвлөлт

Харин орон нутгийн концессын төслийн төлөвлөлтийн хувьд Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын төслийг бэлтгэж, ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

Ингэхдээ Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах концессын зүйлийн талаар концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ, төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх, уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэх зэргийг багтаасан саналаа, зардал, үр ашгийн тооцоо болон СЯ-ны зөвшөөрлийн хамт тухайн аймаг, нийслэлийн ИТХ-д хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь саналаа ИТХ-д хүргүүлэхээс өмнө тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.

Зураг 16. Орон нутгийн өмчийн концессын төслийн төлөвлөлт



Аймаг, нийслэлийн ИТХ нь орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Гэхдээ Аймаг, нийслэлийн ИТХ нь “Барих-Шилжүүлэх” төрлөөс бусад концессын төрлийн төслийн жагсаалтыг баталдаг. Мөн концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг Аймаг, нийслэлийн ЗДТГ-т өгнө.

Аймаг, нийслэлийн ИТХ нь тухайн зүйлийг концессын зүйлийн жагсаалтад тусгахаар шийдвэрлэсэн бол эрх бүхий этгээд энэ хуульд заасны дагуу уралдаант шалгаруулалт явуулна. Уралдаант шалгаруулалтад оролцох хүсэлтээ өөр оролцогч ирүүлээгүй бол эрх бүхий этгээд анх санаачилга гаргасан этгээдийг хамгийн сайн нөхцөл санал болгосон оролцогч гэж үзэж дүгнэлт гарган аймаг, нийслэлийн ИТХ-д хүргүүлнэ. Уралдаант шалгаруулалтад хэд хэдэн оролцогч оролцсон бол төслийн саналыг үнэлж, дүгнэлт гаргахдаа анх санаачилга гаргасан этгээдэд давуу байдал олгох бөгөөд энэ талаар уралдаант шалгаруулалтын баримт бичигт урьдчилан заана. Аймаг, нийслэлийн ИТХ-аас гэрээ байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгоно.

Аймаг, нийслэлийн ИТХ концессын гэрээ байгуулахыг дэмжээгүй бол хэлэлцээрийг дахин хийх эсэх, эсхүл уралдаант шалгаруулалтыг дахин явуулах эсэх шийдвэрийн аль нэгийг гаргана.

Нийслэлийн хувьд Нийслэлийн ИТХ, Нийслэлийн Засаг даргаас тэргүүлэх ач холбогдолтойд тооцсон хөгжлийн төсөл, хөтөлбөрийг үнэлэх, эрэмбэлэх, хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшил хамтран ажиллах, ТХХТ-ийн төрөл, хэрэгжүүлэх арга, хэлбэр болон оролцогч талуудын эрх, үүрэг, хоорондын харилцаа, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа, зохион байгуулагч талуудын чиг үүргийн хуваарилалт, харилцааг зохицуулах зорилгоор 2018 онд Хараат бус судалгааны хүрээлэнгээс “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ыг⁸ боловсруулсан байдаг.

Уг журмыг Нийслэлд ТХХТ-ийн барих-шилжүүлэх төрлөөс бусад төрөл, хэлбэрээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дагаж мөрдөнө. Нийслэлийн хэмжээнд ТХХТ-ийн талаар баримтлах бодлогод тусгагдсаны дагуу ТХХТ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Дэд бүтцийн салбарын түншлэл;
2. Нийгмийн салбарын түншлэл;
3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх түншлэл;
4. Байгаль орчны салбарын түншлэл зэрэг болно.

Нийслэлд ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах арга, хэлбэрийн аль нэгийг эсвэл хослуулан хэрэглэж болно. Үүнд:

1. Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ (барилга угсралтын гэрээ, түлхүүр гардуулах гэрээ, хувьчлал ба зохицуулалт, тусгай зөвшөөрөл олголт ба зохицуулалт гэх мэт);
2. Менежмент буюу удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх;
3. Түрээсийн гэрээ;
4. Хамтарсан төслийн нэгж /компани/ байгуулан хэрэгжүүлэх;
5. Бусад зэрэг болно.

Дээрх төрийн болон орон нутгийн өмчийн концессын зүйл болон түүний эд анги, тоног төхөөрөмжийн өмчлөлийн асуудлыг концессын гэрээгээр зохицуулж дараах байдлаар ангилан гэрээнд тусгаж болно. Үүнд:

1. Концессын гэрээний дагуу төрийн болон орон нутгийн өмчлөлд, эсхүл бусад этгээдэд шилжүүлэх эд хөрөнгө;

2. Концесс эзэмшигчээс төр болон орон нутаг өмчлөлдөө худалдан авч болох эд хөрөнгө;
3. Концессын гэрээг дуусгавар болсны дараа концесс эзэмшигч өөртөө үлдээх болон захиран зарцуулж болох эд хөрөнгө зэрэг болно.

Мөн Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын гэрээгээр шинэчлэн сайжруулах концессын зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарч, концессын зүйлийг ашиглах явцад бий болсон биет эд хөрөнгө болон оюуны үнэт зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарна. Түүнчлэн концессын зүйлийг эзэмших, ашиглах хугацаанд олсон бусад орлого, ирээдүйд бий болох ашиг нь концесс эзэмшигчийн өмчид хамаарна. Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концесс эзэмшигчид ашиглуулахаар шилжүүлсэн концессын зүйл, газар ба бусад эд хөрөнгө нь гэрээнд заасан зориулалтаар цаашид ашиглагдах боломжгүй, эсхүл шаардлагагүй болсноос бусад тохиолдолд эрх бүхий этгээд болон төрийн бусад байгууллага, албан тушаалтан концессын гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг буцаан авах, эсхүл захиран зарцуулах шийдвэр гаргахыг хориглодог.

БҮЛЭГ 6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

6.1 Төслийн хэрэгжилтийн үе шат

Төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үе шат гэдэг нь төлөвлөлтийн үе шатанд хөрөнгө нь батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат юм. Уг үе шат нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагаа (ХАА) буюу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас эхлээд гэрээ байгуулж, ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх хүртэлх хугацааг хамарна.

Зээл, тусламжийн гэрээнд ХАА-ны талаар тусгайлан заагаагүй эсхүл хөгжлийн түншийн журам, заавраар зохицуулаагүй тохиолдолд ХАА-г Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангадаг. Гэхдээ энэхүү гарын авлагад Монгол Улсын Засгийн газрын ХАА-ны талаар оруулсан, харин олон улсын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийх худалдан авалтыг оруулаагүй. Учир нь манай улсад орж ирдэг зээл, тусламжийн дийлэнх нь тухайн олон улсын байгууллага, донор улсын ХАА-ны журмаар зохицуулахаар гэрээндээ заасан байдаг. Тухайлбал, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, улс орны Эксим банк зэрэг нь бүгд өөр өөрийн ХАА-ны журмыг ашигладаг тул энэхүү гарын авлагад оруулах боломжгүй юм.

Зураг 17. Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үе шат



Энэхүү бүлэгт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үе шат буюу хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатнаас сонгогдож хөрөнгө нь батлагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тайлбарлана.




6.1.1 Худалдан авах ажиллагааны тухай

Засгийн газрын худалдан авах ажиллагаа гэдэг нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахын тулд төлөвлөх, зохион байгуулах болон тайлагнах цогц үйл ажиллагаа юм.

Засгийн газрын ХАА-д дараах хууль тогтоомжийг мөрдлөг болгодог. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ХАА-ны тухай хууль),
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

Нэр томъёоны хувьд:

Бараа		Эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох зүйл болон тухайн барааг нийлүүлэхэд шаардагдах ажил юм. Ажлын үнэ нь барааны үнээс их байвал тухайн гэрээг “ажлын гэрээ” гэж тооцно.
Ажил		Барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлт юм. Бараа нийлүүлэлтийн үнэ нь ажлын үнээс их байвал тухайн гэрээг “барааны гэрээ” гэж тооцно.
Зөвлөх үйлчилгээ		Гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээ юм.






ХАА-ны талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга зүй, хяналтын асуудлыг СЯ хариуцах бөгөөд ХАА-тай холбоотой журам, заавар, аргачлал, тендерийн жишиг баримт бичгийг баталдаг.

- Төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой;
- Олон улсын байгууллагатай байгуулсан гадаадын зээл, тусламжийн гэрээнд өөрөөр заасан бол;
- Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээ;
- Монголбанкны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой;
- Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээлтэй холбоотой хуульд заасан үйлчилгээ;
- Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч сонгон шалгаруулах.

ХАА-ны тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, уг хуулийг зөрчигчдөд хариуцлага

хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг үндсэн эрхзүйн акт юм. ХАА-ны хуулиар доор дурдсан худалдан авалтыг зохицуулахгүй. Үүнд:

Худалдан авах ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

	Ил тод	Тендер шалгаруулалт нь ил тод, нээлттэй байх
	Өрсөлдөх тэгш боломжтой	Тендер шалгаруулалт нь бүх оролцогчид тэгш эрхтэй, ижил шалгуур тавих
	Үр ашигтай	Худалдан авалт чанартай, үр өгөөжтэй буюу захиалагчийн шаардлагыг бүрэн хангах
	Хэмнэлттэй байх	Ил тод, өрсөлдөөнийг өрнүүлэх замаар төсөвт хэмнэлт бий болгох
	Хариуцлагатай	Оролцогч талууд хариуцлагатай байх

6.1.2 Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд

Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын чиг үүргийг дараах хүснэгтэд үзүүлжээ.

Хүснэгт 14. Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг


Оролцогч талууд	Чиг үүрэг
Захиалагч	ХАА-г төлөвлөх, зохион байгуулах, Үнэлгээний хороо байгуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээ байгуулах эрх олгох болон гэрээ байгуулах
Тендерт оролцогч	ХАА-д хуулийн дагуу хариуцлагатайгаар оролцож, үнэн зөв мэдээлэл бүхий тендер ирүүлэх, шаардсан тендерийн баталгаа болон гүйцэтгэлийн баталгааг хуулийн хугацаанд нь ирүүлэх, гэрээний хэлэлцээрт орох
Сангийн яам	Эрх зүйн орчинг сайжруулах, олон нийтэд ил тод болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих
Худалдан авах ажиллагааны газар	ХАА-ны хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах, ХАА-ны цахим систем tender.gov.mn-ийг хариуцах, цахим тендер зохион байгуулах, захиалагч болон тендерт оролцогчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ерөнхий гэрээ байгуулах
Үнэлгээний хороо	ХАА-нд үнэлгээ хийх, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж гарган захиалагчид хүргүүлэх
Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан байх тохиолдолд тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хуулийн дагуу хүлээн авч, хянан үзнэ.

Шүүх

СЯ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар тендерт оролцогчийн хуулийн дагуу ирүүлсэн гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь хүлээн зөвшөөрөөгүй тендерт оролцогчийн гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх

ХАА-д гол оролцогч тал болох захиалагч болон тендерт оролцогчийн тодорхойлолтыг доорх Зурагт харуулав.

Зураг 18. Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын тодорхойлолт



Хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагч үнэлгээний хороо байгуулдаг. Захиалагч Сангийн сайдын 2014 оны 212 тоот “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын дагуу Үнэлгээний хороог байгуулан ажиллана.

Зураг 19. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавих шаардлага



Үнэлгээний хороо тендерийн үнэлгээний талаарх мэдээлэл, ААН байгууллагын нууцыг задруулахгүй байх тухай заасан маягтын дагуу баталгаа гаргаж, баталгаажуулна.

Үнэлгээний хорооны гишүүний чиг үүрэг:

- Тендерийн урилга зарлах (tender.gov.mn-д), хүлээн авах, нээх;
- Тендерийн үнэлгээг Тендерийн баримт бичигт тусгасан үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэн зохих аргачлал, зааврын дагуу үнэлэх (тендер нээснээс хойш 28 хоногийн дотор), үнэлгээний дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Захиалагчид үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж өгөх;
- Тендер шалгаруулалтын үр дүнг ХАА-ны цахим хуудас (www.tender.gov.mn)-т байршуулах үүрэгтэй.

Үнэлгээний хорооны үйл ажиллагаа

- Ирц 75 хувиас дээш хүчин төгөлдөрт тооцогдоно.
- Тендер нээсэн өдөр тендерийн үнэлгээний эхний хурлыг хийнэ.
- Бүх гишүүд саналын тэгш эрхтэй, саналаа хараат бусаар өгнө.
- Илээр санал хураана.
- Хурлаас хамтын шийдвэр гарна. Нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- Үнэлгээний дүгнэлтэд бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн энэ тухайгаа тэмдэглэж, гарын үсгээ зурна.
- Үнэлгээний хорооны хурлын шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.
- Зөвлөмж, дүгнэлт, тайлангаа тендер хүчинтэй байх хугацаанд багтааж захиалагчид хүргүүлнэ.
- Захиалагч Үнэлгээний хорооны дүгнэлтийг хууль, тогтоомж болон тендерийн баримт бичигт нийцээгүй, илт зөрчсөн гэж үзвэл Үнэлгээний хорооны дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зөрчлийг арилгах тухай шаардлагыг бичгээр эргэж мэдэгдэнэ.
- Мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор Үнэлгээний хороо дахин хуралдаж шаардлага үндэслэлтэй бол залруулж, дахин дүгнэлт гарган хүргүүлнэ, эсхүл урьд гаргасан шийдвэрээ үндэслэлтэй болохыг нотолж, дүгнэлтээ хэвээр үлдээх шийдвэр гаргана.
- Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга холбогдох баримт материалыг бүрдүүлж, хавтаст хэрэг болгон архивт шилжүүлнэ.

Ашиг сонирхлын зөрчил



Нийтийн албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд зүй бус нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ.

Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилөөс сэргийлэхийн тулд дараах байдлаар ажиллана. Үүнд:

1	Тендер нээсэн өдөр тендерт оролцогч нартай “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, эсхүл зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргах;
2	Ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөлд үнэлгээний хорооны гишүүний үүргээсээ татгалзаж, бичгээр мэдэгдэх;
3	Ашиг сонирхлын зөрчил үүссэн үнэлгээний хорооны гишүүнийг үүргээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;
4	“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” үүсвэл бичгээр тайлбар хийж, хүргүүлэх;
5	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;
6	Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно.

6.1.3 Худалдан авах ажиллагааг төлөвлөх

ХАА-г төлөвлөх, зохион байгуулах болон тайлагнах гэсэн үе шатаар авч үзэж болно. Энэ хэсэгт ХАА-ны төлөвлөх үе шатыг дэлгэрүүлж тайлбарлая.

Захиалагч нь хууль болон бусад эрх бүхий этгээдээс баталсан төсвийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 102 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу гүйцэтгэх ба тус журмын хавсралтад заасан маягтын дагуу ХАА-ны цахим систем (www.tender.gov.mn)-д хөтөлнө.

Энэхүү шинэчлэн баталсан журамд заасны дагуу Захиалагч нь ХАА-ны төлөвлөгөөг төсвийн төслийн хамт харьяа ТЕЗ-д цахимаар хүргүүлнэ.



Худалдан авах эрх шилжүүлэх тухай


Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний эрхээ шилжүүлсэн эсэх мэдээллийг тусгадаг. ТЕЗ нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болно. ТЕЗ нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан СЯ-д хүргүүлнэ. Эрх шилжсэн ХАА-ны хэрэгжилтийг эрх хүлээн авсан этгээд нь шилжүүлсэн этгээдэд, шилжүүлсэн ТЕЗ нь СЯ-д тус тус цахим системээр тайлагнадаг.

Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ХАА-г зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.

Захиалагч нь тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн, төсөл, арга хэмжээ нэг бүрээр дээр дурдсан журмын Маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, ХАА-д мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа, эрх шилжүүлсэн эсэх, ерөнхий гэрээний журам болон холбогдох тайлбар, тодруулгыг тодорхой тусгасан байна.

ТЕЗ нь өөрийн харьяа төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын тухайн онд худалдан авахаар баталсан төлөвлөгөөг хянан нэгтгэн цахим системээр баталж, СЯ-д цахим системээр ирүүлнэ. Улс, орон нутгийн төсөв батлахад ХАА-ны төлөвлөгөөг хамт батлагддаг тул доор үзүүлсэн төсвийн цаглабарыг дагаж мөрддөг.

Зураг 20. Төсвийн төлөвлөлттэй уялдуулан ХАА-г зохион байгуулах цаглабар



Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа батлагдсан төсөв ба босго үнийг харгалзаж ХАА-ны арга буюу журмыг тодорхойлон, төсвийн хамт ХАА-ны төлөвлөгөөнд тусган батлуулна. Төсөв батлагдсанаас ажлын 10 хоногийн дотор ТЕЗ ХАА-ны төлөвлөгөөг СЯ-нд хүргүүлж холбогдох цахим хуудас (tender.gov.mn)-д оруулж, төсөв батлагдсан дариуд ХАА-г зохион байгуулна. Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

Мөн 2021 оноос эхлэн өөрчлөгдсөн нэгэн онцлог бол тухайн жилийн төсөв өмнөх жилийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлагдмагц ХАА-г эхлүүлж, бэлтгэл ажлыг хийх, тендер зарлах боломжтой болгосон явдал юм.




ХАА төлөвлөгөө, төсөв батлахад анхаарах зүйл

Орон нутгийн төсөвт ихэвчлэн зураг төсөв, газаргүй ажлын хөрөнгийг баталснаар тухайн ажлуудын холбогдох материалыг бүрдүүлэхэд хугацаа их ордог. Хэдийгээр зураг төсөвгүй ажлуудыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр тендерийг зарладаг ч аль ч тохиолдолд төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих боломжгүй болдог. Учир нь зураг төсөв боловсруулж дуусахад тухайн ажлын бодит өртөг гардаг ба батлагдсан хөрөнгөнөөс нэмэгдэх тохиолдол их байдаг. Иймд аль болох зураг төсөвтэй, газрын асуудал болон холбогдох зөвшөөрөл бүхий төслүүдийг ХАА-ны төлөвлөгөөнд тусгах, төсвийн санал өгч байгаа байгууллагуудын хувьд урьдчилан судалгаа зураг төсвөө боловсруулах, газар чөлөөлөх, хугацаа болон хөрөнгийг тооцож төсөвт тусгайлан оруулж батлах шаардлагатай.

ХАА-ны төлөвлөгөө боловсруулахдаа ХАА-ны журмыг (Зураг 21) тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

Зураг 21. Худалдан авах ажиллагааны арга



Босго үнэ



Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг ХАА-ны журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаар.


Хүснэгт 15. Худалдан авах ажиллагааны босго үнэ болон дээд хязгаарын харьцуулалт

№	Ангилал*	Бараа (сая ₮)	Ажил (сая ₮)	Үйлчилгээ (сая ₮)	
				Зөвлөх	Бусад
1	Харьцуулалтын аргын дээд хязгаар	70.0	100.0	-	70.0
2	Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар	20.0	20.0	20.0	20.0
3	Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар	-	-	70.0	-
4	Цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар	20.0	20.0	20.0	20.0

*Дээрх босго үнийн өөрчлөлт нь Засгийн газрын 2021 оны 124-р тогтоолоор батлагдсан.

Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалт явуулдгийг доорх схемээр харууллаа.

Зураг 22. Босго үнийн харьцуулалт, худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулах шаардлага



Тендер шалгаруулалтын онцгой журмыг дараах тохиолдолд ашиглана.

Хязгаарлагдмал	Харьцуулалтын арга	Гэрээ шууд байгуулах
Нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь төсөвт өртөгтэй холбоотой, Чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал	Бараа, ажил, зөвлөхөөс бусад үйлчилгээний төсөвт өртөг нь хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд	Хуулийн 34.1-д заасан нөхцлүүд үүссэн тохиолдолд

Босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн **багцад** хувааж тендер шалгаруулалт явуулна. Зураг төсөл, барилга угсралт,

тохируулгын ажлыг **түлхүүр гардуулах гэрээгээр** гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно.

Түлхүүр
гардуулах
гэрээ



Барилга байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн ажил, бараа, үйлчилгээг бүхэлд нь хамарсан нэг гэрээ юм.

ХАА-ны хуулийн 8.10-д Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно гэж заасан байдаг.

6.1.4 Олон нийтийн оролцоот худалдан авах ажиллагаа

Сум, дүүргийн төсвийн хүрээнд 20.0 сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй Төсвийн тухай хуульд заасан дараах бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад хэрэглэнэ.

ДҮҮРЭГ

58.3.3 Дүүргийн нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулах ажил;
58.3.4 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;
58.3.5 Дүүргийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;
58.3.6 Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгаа хийх, зохион байгуулах;
58.3.7 Дүүргийн тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах.

СУМ

58.4.3 Нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулах ажил;
58.4.4 Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн усгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ;
58.4.5 Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;
58.4.6 Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;
58.4.7 Сумын нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах;
58.4.8 Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах.

Сангийн сайдын 2013 оны 39 тоот тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-аар ХАА-г дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:




1. Үнэлгээний хороо байгуулна;
2. Иргэд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр бүлэг байгуулж Сум, дүүргийн засаг даргын тамгын газарт бүртгүүлэх хүсэлтээ гаргана;
3. ЗДТГ “Иргэдийн бүлгийн жагсаалт” бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нээлттэй байлгана;
4. Гурав ба түүнээс дээш бүлэгт үнийн санал авах урилгыг албан бичгээр, цахим шуудангаар хүргүүлнэ. Урилга хүлээн аваагүй ч тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай бүлэг оролцох хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд тендер шалгаруулалтад оролцуулна;
5. Ажлын 5-аас доошгүй хоногийн дараа саналын урилгыг хүлээн авна;

6. Ирсэн саналуудыг харьцуулалтын аргаар шалгаруулна.

6.1.5 Цахим худалдан авах ажиллагаа

Цахим худалдан авалтыг Сангийн Сайдын 2019 оны 255 тоот тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-аар зохицуулна.

ХАА-ны газар нь ХАА-ны цахим систем буюу www.tender.gov.mn цахим хуудсаар цахим ХАА-г зохион байгуулна. Сүүлийн жилүүдэд цахим худалдан авалтын системийг түлхүү хэрэглэж байгаа бөгөөд энэ нь санхүү, төсвийг нилээд хэмжээгээр хэмнэж байгаа төдийгүй ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг шуурхай хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болох нь харагдана.

ХАА-ны цахим систем		Цахим программ хангамжийг ашиглан ХАА-г төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог хэлнэ.
Цахим Дэлгүүр		Ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан ХАА-ны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ.
Ногоон Худалдан авах ажиллагаа		Эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний ХАА


6.1.6 Зөвлөх сонгон шалгаруулах

Хөрөнгө оруулалтын худалдан авалт, ялангуяа барилга байгууламжийн ажлыг хэрэгжүүлэхэд инженерийн зураг төсөл, Техник эдийн засгийн үндэслэл, судалгаа боловсруулсан эсэхийг харгалздаг ба эдгээр ажлуудыг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлдэг.

Зөвлөх үйлчилгээний хувьд олон салбарын мэдлэг, нарийн мэргэжлийн боловсон хүчин шаардагдахаар бол хуулийн этгээдийг, шаардлагатай мэргэжил туршлага бүхий хувь хүн илүү сайн гүйцэтгэж чадахаар бол түүнийг сонгон гэрээ байгуулна.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг дараах үе шатны дагуу сонгон шалгаруулна.

Зураг 23. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үе шат



Зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулалт, ажлыг гүйцэтгэх хугацаа нь дараа дараагийн ажлын үр дүнд нөлөөлдөг тул практик дээр зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад зарцуулж буй хугацааг тоймлон харуулав.

Хүснэгт 16. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад зарцуулж буй хугацаа

Д/д	Ажлын үе шат	Зарцуулж буй хоног /хамгийн багадаа/
1	Ажлын даалгавар бэлтгэх /Тендерийн баримт бичиг боловсруулах, батлуулах/	30
2	Үнэлгээний хороо байгуулах, хуралдах	2
3	Зарлан мэдээллэх / Урилга нийтлэх	1
4	Мэдүүлэг хүлээж авах	15
5	Дэлгэрэнгүй жагсаалт үүсгэх, үр дүнг хүргүүлэх	5
6	Саналын урилга хүлээн авах	30
7	Үнэлгээ хийх	5
8	Санхүүгийн санал нээх, үр дүнг хүргүүлэх, батлуулах	5
9	Гэрээ байгуулах	6
	Нийт	99

Зөвлөх сонгон шалгаруулах журамд заасан дараах аргуудаас тохирохыг сонгон саналын урилгад тусгадаг. Үүнд:

Хосолмол үнэлгээний арга:

- Техникийн саналын авбал зохих доод оноог тендерийн баримт бичигт заана;
- Техникийн саналын үнэлгээг хийж, доод оноо буюу түүнээс дээш оноо авсан техникийн саналуудыг сонгоно;
- Санхүүгийн саналд оноо өгч хамгийн өндөр оноо авсан зөвлөх;
- Нийт дүнгээр хамгийн өндөр оноо авсан зөвлөхийг сонгон гэрээний хэлэлцээ хийнэ.

Бага үнийн арга

- Техникийн саналын үнэлгээг хийж, зохих оноо авсан техникийн саналуудыг сонгоно;
- Хамгийн бага санхүүгийн санал ирүүлсэн зөвлөхийг сонгоно;

Чанарын үнэлгээ

- Техникийн саналын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээнэ
- Сонгосон зөвлөхтэй гэрээний санхүүгийн болон бусад нөхцөлийн талаар хэлэлцээ хийнэ.

Чадварын арга

- Зөвлөх хувь хүнийг сонгоход чадварын үнэлгээний аргыг хэрэглэх бөгөөд зөвлөхийн мэдлэг, туршлага, мэргэшлийн түвшин, мэргэжлийн бусад ур чадварыг үндэслэл болгоно.

6.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үе шатууд

ХАА-ны төлөвлөх тухай өмнөх хэсэгт дурдсан бөгөөд төсвийн эх үүсвэр батлагдсанаар ХАА-г эхлүүлнэ. Энэ хэсэгт ХАА-г зохион байгуулах үе шатуудыг тайлбарлав. Тендер шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна.

Хүснэгт 17. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үе шат

Тендер шалгаруулалтыг зохион байгуулах	
Үнэлгээний хороо байгуулах	Захиалагч харьцуулалтын аргаас бусад тохиолдолд үнэлгээний хороо байгуулна. Үнэлгээний хороонд дарга, нарийн бичиг болон хөндлөнгийн хоёроос доошгүй гишүүн оруулна.
Тендерийн баримт бичиг (ТББ) бэлтгэх	Үнэлгээний хороо нь Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийг ашиглан тендерийн баримт бичгийг боловсруулж захиалагчаар батлуулна.
Тендерийн урилга нийтлэх	Захиалагч тендерийн урилгыг өдөр тутмын сонин, tender.gov.mn болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. Хэрэв гадаадын этгээд оролцуулах бол өргөн хэрэглэгддэг гадаад хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Тендерийн баримт бичгийг тендерт оролцохыг сонирхсон этгээдэд саадгүй худалдана
ТББ-тэй холбоотой тодруулга хүлээн авах, хариу өгөх	Тендер хүлээн авах эцсийн хугацаа болохоос ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас тодруулга авах хүсэлтийг бичгээр гаргаж болно.


Тендер шалгаруулалтыг зохион байгуулах	
	<p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээллийг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр эсхүл www.tender.gov.mn цахим системд нийтэлнэ.</p>
Тендер хүлээн авч, нээх	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацааг зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн</p> <ul style="list-style-type: none"> • нээлттэй тендер шалгаруулалтын үед 30 • хязгаарлагдмал тендер 15 буюу түүнээс дээш хоногоор тус тус тогтооно. <p>Тендер оролцогч энэ хугацаанд тендер нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах саналаа ирүүлж болно.</p> <p>Тендерийн баримт бичгийг товлосон хугацаанд, дурдсан хаягаар, заасан хэлбэрээр техникийн болон санхүүгийн саналыг хамтад нь ирүүлнэ.</p> <p>Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор бүх тендерийг тендерийн баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд нийтийн өмнө нээнэ.</p> <p>Тендер нээхэд тендер оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй. Дараах мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Тендер оролцогчийн нэр • тендерийн үнэ, хувилбарт саналтай тендерийн хувьд хувилбарт саналын үнэ, тендер тусгасан үнийн хөнгөлөлт • тендерийн баталгаа ирүүлсэн эсэх • Оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. <p>Тендер нээснээс хойш шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.</p>
Тендерийг хянан үзэх	<p>Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий нөхцөлийг магадлах; • Санхүүгийн чадавхыг үнэлэх; • Техникийн чадавх болон туршлагыг үнэлэх; • ТББ-д заасан бусад шаардлагын дагуу үнэлэх; • техникийн тодорхойлолт; • тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага. <p>Дээрх бүх нөхцөлийг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ. Нөхцөл, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзана.</p>
Тендерийг үнэлэх	<p>Нэг үе шаттай тендер шалгаруулалтын хувьд:</p> <p>Тендер хүчинтэй байх хугацаанд шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэлгээг хийх ба үнэлгээ хийх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна. Тендерийн үнэд татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг багтааж тооцно.</p>

Тендер шалгаруулалтыг зохион байгуулах

	<p>Шаардлагад нийцсэн тендерийг дараах байдлаар харьцуулж үнэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, болон бусад шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж харьцуулах үнийг тодорхойлно; • Давуу эрх олгох бол хуульд заасан хувь хэмжээг тооцно; • Үнэлгээ хийсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно; • Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ. <p>Хоёр үе шаттай тендер шалгаруулалтын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • тендерт оролцогч нь техникийн саналаа ирүүлэх бөгөөд түүнийг захиалагч үнэлж, нэмж оруулах тодотгол, өөрчлөлтийг тендерт оролцогчтой тохиролцох; тодотгол өөрчлөлт оруулсан техникийн саналыг үндэслэн хийсэн санхүүгийн саналаа тендерт оролцогч ирүүлэх бөгөөд энэхүү тодотгосон саналыг үнэлнэ.
<p>Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэх</p>	<p>Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6 өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.</p> <p>“Хамгийн сайн” үнэлэгдсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл ХАА-ны хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн бол гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож, удаах “хамгийн сайн” үнэлэгдсэн оролцогчтой гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол 30.4-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.</p> <p>Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол СЯ-д хүсэлт гаргаж нэг удаа 15 хоногоор сунгуулж болно.</p>

ХАА-ны нээлттэй өрсөлдөөнт болон харьцуулалтын аргуудыг ашиглан зохион байгуулах үе шатийн зураглалыг Зураг 24-д үзүүлэв.

Зураг 24. Нээлттэй (нэг үе шаттай) тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар худалдан авалт зохион байгуулах





Үнэлгээний хороог байгуулахад анхаарах зүйл

Үнэлгээний хороонд тухайн хөрөнгө оруулалттын онцлогоос шалтгаалж нарийн мэргэжлийн хүмүүсийг сонгон оролцуулах нь чухал байдаг. Гэтэл зарим тохиолдолд ХАА-ны АЗ сертификаттай мэргэжлийн бус хүмүүс оролцдог. Тухайлбал барилгын зураг төсөв дээр мэргэжлийн бус хүмүүсийг ажиллуулснаар ажлын тоо хэмжээг орхигдуулах, буруу тооцох гэх мэт алдаа дутагдал нийтлэг гардаг. Нөгөө талдаа үнэлгээний хороонд хариуцлага тооцох систем хангалтгүй учраас дээрх алдаа дутагдал, зөрчил давтагдсаар байна.

Дараах нөхцөлд нээлтэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулж болно.

Үүнд:

- ажлын цар хүрээ их, төсөвт өртөг өндөртэй, цогцолбор гэрээ байгуулах шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх, эсхүл хоёроос дээш техникийн шийдэлтэй;
- техникийн тодорхойлолт, ажлын цар хүрээг эцэслэн тогтоох боломжгүй, эсхүл техникийн тодорхойлолт бэлтгэхэд туршлагатай гүйцэтгэгч, нийлүүлэгчээс туслалцаа авах шаардлагатай.

Тендер амжилтгүй болж бүх тендерээс татгалзах нөхцөлүүдийг дор жагсаав.

- Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй;
- тендер шалгаруулалтад үнийг урьдчилан тохиролцож оролцсон, өрсөлдөгчөө тендер шалгаруулалтын бодит нөхцөлөөс төөрөгдүүлсэн, тэдэнд дарамт, шахалт үзүүлсэн нь шүүх, эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;
- шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн;
- Гэрээний хэлэлцээ амжилтгүй болсон.

Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч амжилтгүй болсон нөхцөлийг судлаад тендер шалгаруулалтыг дахин явуулах, эсхүл дахин ийм байдал нөхцөл үүссэн бол шууд гэрээ байгуулах ажиллагааг хуульд заасны дагуу гүйцэтгэнэ.

1) Тендерийн баримт бичиг бэлтгэх

Сангийн сайдын баталсан дараах тендерийн жишиг баримт бичгүүдийг ашиглан тендерийн баримт бичгүүдийг бэлтгэнэ.

Хүснэгт 18. ХАА-ны төрөлд хэрэглэх тендерийн жишиг баримт бичгүүд

№	Тендерийн жишиг баримт бичиг (ЖББ)-ийн төрөл	ХАА-ны журам
1	Үнийн санал авах ЖББ (Бараа)	Гэрээ шууд, харьцуулалт
2	Үнийн санал авах ЖББ (Ажил)	Гэрээ шууд, харьцуулалт
3	Үнийн санал авах ЖББ (Зөвлөхөөс бусад)	Гэрээ шууд, харьцуулалт
4	Ажил гүйцэтгэх ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
5	Бараа нийлүүлэх ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
6	Зөвлөхөөс бусад үйлчилгээний ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
7	Зөвлөх үйлчилгээний ТЖББ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
8	Олон нийтийн оролцоотой ХАА-ны ЖББ	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам
9	Урьдчилсан сонголт явуулах ЖББ	
10	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
11	Эм, эмнэлэгийн хэрэгсэл худалдан авах ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
12	Сурах бичиг худалдан авах ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал
13	Мэдээллийн систем нийлүүлж, суурилуулах ТЖББ	Нээлттэй, хязгаарлагдмал

Тендерийн баримт бичиг нь тендерт оролцогчид зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг юм. Тендерийн баримт бичигт дараах бүлгүүдийг агуулна. Үүнд:

1. Тендерт оролцогчдоод өгөх зааварчилгаа (ТООЗ)
2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)
3. Тендер шалгаруулалтын жишиг маягтууд
4. Техникийн тодорхойлолт, ажлын шаардлага болон бусад шаардлага
5. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН)
6. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)
7. Гэрээний маягт
8. Баталгааны маягт
9. Тендерийн урилга
10. Бусад (ТББ-д оруулсан нэмэлт өөрчлөлт) орно.

Тендерийн баримт бичгийн гол бүрэлдэхүүн буюу техникийн тодорхойлолт нь Захиалагчид шаардлагатай байгаа бараа, ажил, болон холбогдох үйлчилгээний техник үзүүлэлтүүд буюу үйлчилгээний чанар, материал, хүчин чадал, үйл ажиллагаанд шаардагдах стандарт, шаардлагатай тоо хэмжээ зэргийг тусгана. Техникийн тодорхойлолт нь захиалагчийн бодит шаардлагыг хангахуйц, ойлгомжтой, өрсөлдөөнийг дэмжих нөхцөлийг хангасан байх шаардлагатай.

2) Тендерийг хянан үзэх

Тендерийг хянан үзэх болон үнэлэхдээ Тендерийн үнэлгээний зааврыг ашиглана.

Энэ шатанд дараах зүйлсийг харгалзана.

Хүснэгт 19. Тендерийг хянан үзэх, үнэлэхэд ашиглах тендерийн үнэлгээний заавар

Шалгуур	Нотлох баримт бичгүүд, шаардлагуудыг хангасан эсэх
Эрх бүхий эсэх	<ul style="list-style-type: none"> • Төлбөрийн чадвартай • Татан буугдаагүй • Хуулийн дагуу татвар хураамжаа төлсөн • Шаардсан мэдээллийг үнэн зөв мэдээлсэн зэргийг эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ (Улсын бүртгэлийн гэрчилгээ), Төрийн захиргааны эрх бүхий байгууллагын албан бичиг, Шүүхийн шийдвэр зэрэгт үндэслэнэ.
Гэрээ хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх (ерөнхий нөхцөлийг магадлах)	<p><i>Санхүүгийн чадавхыг магадлах:</i></p> <ul style="list-style-type: none"> • Харилцагч банкны мэдэгдэл • Тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт • Зөвлөхийн орон тоо, цалин, бусад зардлын тооцооны хүснэгт, • Сүүлийн 5 хүртэлх жилийн ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаарх мэдээлэл. <p><i>Техникийн чадавхыг магадлах:</i></p> <ul style="list-style-type: none"> • Голлох мэргэжилтний боловсрол ур чадвар • Ижил төстэй нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээлэл • Шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт • Чанарын хяналтын арга хэмжээ • Үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн итгэмжлэл зэрэг.
Шаардлагад нийцэж буй эсэх	<ul style="list-style-type: none"> • Тендерийг маягтуудын дагуу ирүүлсэн эсэх, үнийн хуваарь болон үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарьт гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулсан эсэх, • Тендер хүчинтэй байх хугацааг ТББ-г захиалагчийн шаардсаны дагуу ирүүлсэн эсэх • Түншлэл болж тендерт оролцож бйагаа бол түншлэлийн гэрээг ирүүлсэн эсэх гэх мэт.
Тендерийн баталгаа	<ul style="list-style-type: none"> • Тендерийн баталгааны төрөл • Төлөөлөх эрх бүхий этгээд гаргасан эсэх • Тендерийхн баталгааны хугацаа • Тендерийн баталгааны хэмжээ үнэн зөв эсэх
Үндсэн шаардлагагыг хангасан эсэх	<ul style="list-style-type: none"> • Нөхцөлт үнэ ирүүлсэн эсэх, • ТББ-г заасны дагуу үнийн тохируулгыг зөвшөөрсөн эсэх, • Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан эсэх, • Гэрээний эхлэл, хүргэлт, угсралт зэрэг чухал үе шатанд шаардлагсан хугацаа таарч буй эсэх, • ТББ-д тусгайлан заасан туслан гүйцэтгэгчийн ажлын хэмжээг хасгасан эсэх гэх мэт.

3) Тендерийг үнэлэх

Тендерийн нарийвчилсан үнэлгээг хийхдээ хянан үзэх шатанд тэнцсэн буюу шаардлагад нийцсэн тендерийг үнэлэх бөгөөд тендерийн үнэлгээнд хамгийн сайн үнэлэгдсэн тендер болох магадлалтай, шаардлагад нийцсэн бүх тендерийг хамруулах шаардлагатай. Нарийвчилсан үнэлгээг хийхдээ дараах алхмуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэлгээнд хамруулах тендерийн тоог тогтоох;
- Алдааг залруулах (арифметик алдааг залруулах бөгөөд үсгээр бичсэн дүн, нийг үний дүн, нэгж үнэ зэргийг харгалзана);
- Магадлашгүй ажлын зардлын дүнг залруулах (энэ дүн бүх тендерийн хувьд ижил байх учир зөрүүтэй дүнг залруулна);
- Нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тооцох;
- Тохируулга (тохируулгын талаар үнэлгээний тайланд нарийвчлан дурдана);
- Мөнгөөр үнэлж болох зөрүүг залруулах;
- Дотоодын дагуу эрх тооцох.

4) Гэрээ байгуулах эрх олгох тухай

Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу сонгон шалгарсан хуулийн этгээд, иргэнтэй захиалагчийг төлөөлж гэрээ байгуулж баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ. Тендер шалгаруулалтыг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгоход дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээтэй холбоотой харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг. Шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээний хэлэлцээрийн үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.



Гэрээ шууд байгуулах нөхцөл

- Тендер шалгаруулалт хоёр удаа амжилтгүй болсон бол;
- Оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;
- Нэмэлт нийлүүлэлт ахны гэрээний үнийн 20%-иас хэтрэхгүй бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед;
- нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15% болон хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд ажлын нэмэлт болон ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд;
- Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед;
- Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай үед;
- Хорих анги дахь үйлдвэрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах;
- Яаралтай дархлаажуулалтад шаардагдах, олон улсын лавлагаа лабораториор баталгаажсан вакциныг үйлдвэрлэгчээс нь шууд худалдан авах;

Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс хэтэрсэн тохиолдолд захиалагч 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хэлэлцээ хийх бөгөөд ийнхүү хэлэлцээ хийхдээ захиалагч тендерт оролцогчийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардахыг хориглоно. «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно. Гэрээ байгуулахдаа шаардлагатай нөхцөлийг заавал тусгана.

Гэрээ нь ихэвчлэн үндсэн 2 нөхцөлөөс бүрддэг

- **Гэрээний ерөнхий нөхцөл** нь гэрээний удирдлагатай холбоотой нөхцөлийг агуулах бөгөөд тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөлийг өөрчлөх боломжгүй,
- **Гэрээний тусгай нөхцөл** нь захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулах үндсэн нөхцөлийн талаар гэрээний тусгай нөхцөлд тусгана. Мөн гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгох зүйл заалтыг оруулж болдог. Жишээлбэл ажлын даалгавар, алданги, түүний хувь хэмжээ гэх мэт.

Хүснэгт 20. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл

Гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээний тусгай нөхцөл
<ul style="list-style-type: none"> • Гэрээний үүрэг; • Гэрээний үнэ; • Талуудын хүлээх эрх, үүрэг; • Хүлээх эрсдэл болон бусад. 	<ul style="list-style-type: none"> • Бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээний хуваарь (ажил); • Ашиглалт, засвар үйлчилгээний хуваарь; • Голлох мэргэжилтний хуваарь; • Ажлын талбайн судалгааны тайлан; • Бараа, үйлчилгээний товч тодорхойлолт; • Гүйцэтгэх хугацаа/ бусад гүйцэтгэгчдийн хуваарь; • Байршил; • Гэрээний хэл, хууль; • Захиалагчийн хяналт; • Төлбөр хийх нөхцөл, хэлбэр; • Худалдааны нөхцөл; • Алдангийн хувь хэмжээ; болон бусад. <p>Хэрэв шаардсан бол:</p> <ul style="list-style-type: none"> • Даатгал; • Чанарын баталгаат хугацаа; • Барьцаа хөрөнгийн хувь (5-10%); • Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр; • Гүйцэтгэлийн баталгааны дүн, хэлбэр (1-2%, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлэх); • Тохируулга хийх нөхцөл, аргачлал.

Хүснэгт 21. Гэрээний бүтэц, бараа худалдан авах гэрээний жишээ

Гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл	Зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулахыг хориглох нөхцөл	Хүчин төгөлдөр бус гэрээ
<ul style="list-style-type: none"> • хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн (2 жилээс дээш хэрэгжих гэрээний явцад); • суурь үнэ огцом өөрчлөгдсөн 	<ul style="list-style-type: none"> • тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх • гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх • Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • захиалагч журмыг зөрчиж гэрээ байгуулсан; • ХАА журмыг хэрэгжүүлэхдээ гаргасан зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн



Гэрээний хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал

Барилга байгууламжийн угсралтын ажилд хяналт тавих мэргэжлийн байгууллага гэрээг байгуулаагүйгээс болж гэрээний хэрэгжилтийн явцад шийдвэрлэх боломжгүй асуудлууд гарч байна. Мөн захиалагчийн хяналтыг гүйцэтгэгч байгууллага нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавих гүйцэтгэгчид хариуцлага тооцох боломжгүй байдал үүсээд байна. Иймд гэрээ байгуулахад гүйцэтгэгч тал, захиалагч, захиалагчийн хяналтын байгууллагын хамтарсан гурван талт гэрээг хэрэгжүүлж байсан сайн туршлагыг эргэн нэвтрүүлэх нь зүйтэй.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний хувьд ХАА-г дараах байдлаар зохион байгуулдаг.

Хүснэгт 22. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний ХАА-ны оролцогч талуудын үүрэг

№	Үйл ажиллагаа	Оролцогч талууд	Үүрэг
1.	Хөрөнгө оруулалтын ажлын эрх шилжүүлэх	Нийслэлийн Засаг дарга	НИТХ-н тогтоолоор тухайн жилийн нийслэлийн төсөвт хөрөнгө нь батлагдсан төсөл арга хэмжээнүүдийн ХАА-г зохион байгуулах эрхийг холбогдох газруудад шилжүүлэх захирамжийг гаргадаг.
2.	ХАА-ны бэлтгэл ажил	Нийслэлийн Засаг дарга эрх шилжүүлдэг байгууллагууд: <ul style="list-style-type: none"> ✓ Хэрэгжүүлэгч агентлагууд ✓ Захирагчийн ажлын алба ✓ Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот газрууд ✓ Дүүргүүд 	Эрх шилжүүлсэн байгууллагууд эхлээд ХАА-г зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулна. Үнэлгээний хороо төсөл арга хэмжээ тус бүрийн зураг, төсөв, ажлын даалгавар, зургийн даалгавар ажлын тоо хэмжээ, газрын зөвшөөрөл, тусгай шаардлага зэрэг холбогдох материалыг судлан бүрдүүлж техникийн бичиг баримтыг боловсруулдаг.
3.	ХАА-г зохион байгуулах		Үнэлгээний хорооноос тендер зарлахад шаардлагатай холбогдох материал бэлэн болсны дараа төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулах тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хэлбэрээр нийтэд зарлан мэдээлдэг. ХАА-г үнэлгээний хороо “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулдаг. Төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгчийн холбогдох материалыг үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийн

			хамт албан тоотоор НЗДТГ-н Хуулийн хэлтэст хүргүүлдэг.
--	--	--	--



Худалдан авах ажиллагааны үе шатанд тулгамдаж байгаа асуудал

ХАА-ны үе шатанд хамгийн их анхаарах зүйл бол төсөл арга хэмжээ тус бүрийн холбогдох материал /газар, зураг, төсөв, техникийн нөхцөл, ажлын даалгавар/-г бүрдүүлэх ажил. Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас хамаарах ба хэрэв дээрх материалуудыг бүрдүүлж чадахгүй бол эдгээрийг бүрдүүлэх бэлтгэл ажлын хугацаанаас шалтгаалж тендерийг баталсан төлөвлөгөөт хугацаанд нь зарлаж чадахгүй хугацаа алддаг. Сүүлийн 2 жилийн байдлаар НХОГ дээр хэрэгжсэн ажлуудын 70-с дээш хувь нь төлөвлөгөөт хугацаанд тендер зарлагдаагүй, хамгийн бага нь 1 сар хамгийн их нь 8 сарын дараа зарлагдсан. Үүнээс шалтгаалж хөрөнгө татагдах, ажил хугацаандаа хийгдэх боломжгүй болдог.

5) Гомдол, маргаан шийдвэрлэх

Тендерт оролцогч нь ХАА хууль зөрчсөн гэж үзсэн бол дараах байдлаар гомдол гаргаж болно.

Зураг 25. Гомдол гаргахүйл ажиллагааны зураглал

Гомдол	Шийдвэрлэх хугацаа	Гомдол гаргах тохиолдол
<p style="text-align: center;">Тендерийн урилга нийтэлсэн өдөр</p> <p>Тендер нээхээс 10-аас доошгүй өдрийн өмнө</p> <p style="text-align: center;">↓</p> <p style="text-align: center;">Тендерийн нээлтийн өдөр</p> <p>Захиалагч хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор</p> <p style="text-align: center;">↓</p> <p style="text-align: center;">Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл</p> <p>Ажлын 6 хоногийн дотор</p> <p style="text-align: center;">↓</p> <p style="text-align: center;">Гэрээ байгуулсан өдөр</p> <p style="text-align: center;">↓</p> <p style="text-align: center;">Шүүхэд гомдол гаргана</p>	<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газарт</p> <p>14 хоногийн дотор</p> <p>Захиалагчид</p> <p>10 хоногийн дотор</p> <p>СЯ-д</p> <p>14 хоногийн дотор</p>	<ul style="list-style-type: none"> Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендерт оролцож буй этгээдээс өрсөлдөөн хязгаарлахад хүргэж болохуйц зөвлөгөө авсан. Тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэг зөрчил гарсан гэж үзвэл. Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл бичгээр гомдол гаргах бөгөөд зөрчлийн нотлох баримтыг хавсаргана. СЯ болон ШӨХТГ гомдлын заасан хугацаанд шийдвэрлээгүй эсхүл Гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй, Гэрээнд гарын үсэг зурснаас хойш.

Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг захиалагч хүлээн авсны дараа гомдлын агуулгыг бүх тендерт оролцогчид мэдэгдэнэ. Захиалагч гомдлыг хянан, шийдвэр гаргах бөгөөд гомдлыг хүлээн зөвшөөрсөн бол гомдлыг барагдуулах арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллана. Харин эс зөвшөөрсөн тохиолдолд тендерт оролцогч СЯ-нд гомдол гаргаж болно.


Тендерт оролцогч захиалагчийн шийдвэрт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт эсхүл СЯ-д гомдол гаргасан бол гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана. Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.

Гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл тендерт оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно.

б) Худалдан авах ажиллагааг тайлагнах

Захиалагч ХАА явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална. Хавтаст хэрэгт ХАА-ны төлөвлөгөө, гүйцэтгэл, бараа, ажил, үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер, тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ, тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан, үндэслэл, гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг болон бусад баримт бичгүүдийг оруулна.

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан тендерийг дараах Үе шатийн дагуу тайлагнана.



Захиалагч нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2021 оны 102 тоот тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын хавсралтын Маягт 2-ын дагуу боловсруулж, цахим системийн холбогдох талбарт оруулж харьяа ТЕЗ, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

Харин ТЕЗ, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын Маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний ХАА-ны хэрэгжилтийг эрх шилжүүлсэн ТЕЗ нь СЯ-д цахим системээр тайлагнана. СЯ ирүүлсэн тайланг нэгтгэн, нэгдсэн тайлан боловсруулж, Засгийн газарт тайлагнана.

Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ХАА-г зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.

6.3 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь хөгжлийн түнш гэрээг хүчин төгөлдөр болсныг хүлээн зөвшөөрч, албан бичгээр мэдэгдлээ ирүүлснээр эхэлнэ.

Ерөнхий хэлэлцээр, зээл, тусламжийн гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээ, төсөл, арга хэмжээний баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн түнштэй зөвшилцөж, харилцан албан бичиг солилцох замаар шийдвэрлэдэг. Ингэхдээ эхлээд төсөл хэрэгжүүлэгч байгууллага гэрээ, төсөл, арга хэмжээний баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг холбогдох үндэслэл, тооцоо, судалгаа, нотлох баримтын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд төсөл хэрэгжүүлэгч байгууллага, түүний харьяалах ТЕЗ нь гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих үүргийг хүлээж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага нь төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах болон төслийн удирдах хороог байгуулан ажиллуулж болдог. Хэрэв төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах бол урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг зээл, тусламжийн гэрээнд анхнаас нь тусгаж өгсөн байх шаардлагатай бөгөөд тухайн гэрээг дагаж мөрддөг. Заримдаа зээлдэгч болон тусламж үзүүлэгч тал нь зээл, тусламжийн эх үүсвэрээс төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал зардлыг санхүүжүүлэхийг зөвшөөрч зээл, тусламжийн төсвийн нэг бүрэлдэхүүнд зардлыг тусган баталдаг. Нөгөө талаар зээл, тусламжаас шийдвэрлэгдээгүй тохиолдолд зардал нь орон нутгийн төсөв болон тухайн байгууллагын төсөвт тусгагдах шаардлагатай тохиолдолд улсын төсвийн урсгал зардалд тусгагддаг байна.

Хэрэв зээл, тусламжийн гэрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулахаар тусгайлан заасан бол төсөл хэрэгжүүлэгч байгууллагын харьяалах ТЕЗ нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тооны саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тус саналыг үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц болон орон тоог зээлийн төсөлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тусламжийн төсөлд хамтран баталдаг байна.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага батлагдсан бүтэц, орон тоонд үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг нээлттэй сонгон шалгаруулж, томилох ба харин төслийн зохицуулагчийг томилохдоо санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг.

Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн, ХАА-ны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтныг сонгон шалгаруулж, тухайн ажилтныг томилуулах хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлдэг байна. Ажилчдын цалинг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоодог.

Заримдаа салбарын онцлог, хүний нөөцийн боломж болон санхүүгийн үр ашигтай байдлыг харгалзан үзэж, төсөл, арга хэмжээний уялдаа холбоо, зохицуулалтыг тооцон тухайн салбарт хэрэгжиж байгаа хоёр болон түүнээс дээш төслийг хэрэгжүүлэх нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж болдог байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж үйл ажиллагаагаа тухайн төслийн захирал, Төслийн удирдах хороонд тайлагнадаг бөгөөд Төслийн захирал болон төслийн удирдах хороог ТЕЗ-ийн тушаалаар томилж, байгуулдаг.


БҮЛЭГ 7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛТ

7.1 Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх

Улсын төсөв, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл болон санхүүжилт нь Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан 160 тоот “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, журам”-ын дагуу явагддаг.


Дараах Зурагт улс болон нийслэлийн төсвөөр санхүүжүүлэхээр батлагдсан нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийг харуулав.

Зураг 27. Улсын төсвийн санхүүжилтийн ерөнхий схем



Харин нийслэлийн төсвийн санхүүжилтийн хувьд дараах байдлаар хийгдэнэ.

Зураг 28. Нийслэлийн төсвийн санхүүжилтийн ерөнхий схем



Ингэхдээ тухайн төсөл арга хэмжээний Захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллагатай байгуулсан гэрээ болон холбогдох журамд заасан холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн НЗДТГ-т хүргүүлнэ. Эдгээр бичиг баримтыг НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс чиг үүргийн дагуу бичиг баримтыг шалган санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу олгодог.

Харин доорх хүснэгтэд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт авахад шаардлагатай материалыг аль үе шатанд хэрхэн гаргахыг харуулав.

Хүснэгт 23. УТХО-ын барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт авахад бүрдүүлэх материал

Бүрдүүлэх материал	Зөвхөн анхны гүйцэтгэлд нэг удаа ирүүлэх	Бүх гүйцэтгэлд /анхны, дундын, эцсийн/ ирүүлэх	Тухайн зардал гарахаар гүйцэтгэлд туссан тохиолдолд тухай бүр	Эцсийн санхүүжилтэд
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан бичиг, үнэлгээний хорооны шийдвэр;	Тийм			
Захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь /Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Гэрээний маягт”-ын дагуу гэрээг байгуулна/;	Тийм			
Тухайн төсөл, арга хэмжээний ХАА-ны үр дүнг цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох баримт;	Тийм			
Эрх шилжүүлсэн тохиолдолд холбогдох шийдвэрийн хуулбар;	Тийм			
pims.publicinvestment.gov.mn цахим хуудсанд гүйцэтгэлийн хүсэлтийг цахимаар оруулж, QR кодыг хэвлэж гүйцэтгэлд хавсаргасан хуудас		Тийм		Тийм
Тендер шалгаруулалтад шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх дүнгээр тодорхойлсон барилгын ажлын үе шатны хуваарь / заасан маягтын дагуу гаргана/;		Тийм		Тийм
Гүйцэтгэлийн баталгаа / “Гүйцэтгэлийн баталгааны маягт”-ын дагуу гаргана/;	Тийм			

Бүрдүүлэх материал	Зөвхөн анхны гүйцэтгэлд нэг удаа ирүүлэх	Бүх гүйцэтгэлд /анхны, дундын, эцсийн/ ирүүлэх	Тухайн зардал гарахаар гүйцэтгэлд туссан тохиолдолд тухай бүр	Эцсийн санхүүжилтэд
Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /заасан маягтын дагуу гаргана/;		Тийм		Тийм
Барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэлийг нотлох гэрэл зураг /10-аас ихгүй байх/;		Тийм		Тийм
Магадлашгүй ажлын зардлын барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон акт, хурлын тэмдэглэл, магадлашгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл;			Тийм	
Зураг төсөл боловсруулах гэрээ, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналтын тухайн төсөл дээр байгуулсан гэрээний хуулбар, хийсэн ажлын тайлан;			Тийм	
Барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын актыг үйлдэж, комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана;				Тийм
Захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын ил далд ажлын акт;		Тийм		Тийм
Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудаст тендер шалгаруулалтын мэдээллийг бүрэн оруулсан байх.	Тийм			

Санхүүжилтийн гүйцэтгэл ирүүлэхэд шаардлагагүй материалууд:

- Гүйцэтгэгч компанийн захирлын тушаал, ажилтнуудын мэдээлэл
- Барилгын материалын сорьцын шинжилгээний материал, гарал үүслийн бичиг
- Нэхэмжлэх баримт гэх мэт.

Санхүүжилтийн гүйцэтгэлийн материал ирүүлэхэд анхаарах зүйлс:

- Барилгын фото зургийг бичгийн цаасан дээр хэвлэх /фото цаас болохгүй, фото зураг 10-с дээшгүй, тухайн ил далд ажлын акттай холбоотой зураг байх/
- Гүйцэтгэлийн материалыг нуруулдаж хавтаслахгүй байх, үдээсний машинаар үдэхгүй байх зэрэг юм.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар Бүлэг 3-т дурдсанчлан ЗГ-н 2021 оны 160-р тогтоолыг санхүүжилт, тайлагналтад түлхүү ашигладаг тул журмын зүйл заалтыг зөв ойлгох, бодит байдалд гардаг жишээ, асуудлыг ойлгуулах үүднээс дараах тайлбар, мэдээллийг оруулав.

Хүснэгт 24. ЗГ-ын 160 дугаар тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтын тайлбар, хэрэгжилт

ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралт журмын холбогдох заалт		Хэрэгжилт, тайлбар
Дөрөв.Төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн баримт бичиг		
Санхүүжилтийн ерөнхий зохицуулалт		
1.	<p>ТЕЗ:</p> <ul style="list-style-type: none"> • өөрийн багцад батлагдсан төслийн гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актад захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилно • томилсон тухай шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. 	<p>Нийслэлийн хувьд ТЕЗ нь Нийслэлийн Засаг дарга байх бөгөөд захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж захирамж гаргаж, СЯ-нд хүргүүлнэ. Үндсэн захиалагч нь Нийслэлийн Засаг даргын тамгын газар байна.</p>
2.	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд (цаашид захиалагч гэх)</p> <ul style="list-style-type: none"> • Барилга захиалагчийн хяналт тавих этгээдтэй захиалагчийн хяналтын гэрээ заавал байгуулна. • Гэрээний хуулбарыг тухайн төслийн гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргаж, СЯ-д ирүүлнэ. 	<p>Захиалагчийн хяналтыг голлон Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Авто зам хөгжлийн газар болон чиглэл салбарын хариуцсан агентлаг, газрууд бас захиалагчийн хяналтыг хийнэ. Гэрээг НЗДТГ-ын дарга, Захиалагчийн хяналтын байгууллага, гүйцэтгэгч байгууллага гэсэн 3 тал байгуулдаг.</p>

3.	Захиалагч нь төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.	Нийслэлд худалдан авах ажиллагаа Нийслэлийн засаг дарга захирамжаар эрх шилжүүлсэн агентлаг, дүүрэг, газрууд зохион байгуулдаг.
4.	Санхүүжилтийн гүйцэтгэлийг барилга угсралтын гэрээнд тусгасан ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.	Гүйцэтгэлийг зураг төсөл, төсөвтэй тулгах ажлыг хамгийн эхэнд Захиалагчийн хяналтын байгууллага хянаад дараа НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн хянаж баталгаажуулдаг.
5.	<p>ТЕЗ эсхүл төсвийн шууд захирагч нь санхүүжилтийн гүйцэтгэлийг энэ журмын хавсралт №7, №8, №9-д заасан маягтуудын дагуу баталж, санхүүжилт хүссэн албан бичгийг СЯ-д ирүүлнэ.</p> <p>Албан бичигт дараах мэдээллийг тусгасан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн дугаар, нэр, төслийн хэрэгжилт • Олгох санхүүжилтийн дүн, гүйцэтгэгчийн дансны мэдээлэл /нэр, дугаар/ • Гүйцэтгэгчээс бусад байгууллагад олгох санхүүжилтийг шилжүүлэх захиалагчийн дансны мэдээлэл • татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс татварын өрийг суутган шилжүүлэх талаар тусгах 	<p>Журмын хавсралт №7, №8, №9-д заасан маягтуудыг эхлээд гүйцэтгэгч байгууллага гаргаж, холбогдох баримтуудыг хавсарган Захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллагад хүргүүлнэ.</p> <p>Захиалагчийн хяналтын байгууллага хянан баталгаажуулаад НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ.</p> <p>НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн хянан баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлнэ.</p> <p>СЯ-наас уг маягтуудад НЗДТГ-аас эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулж байхыг шаардаж байгаа бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийг зохион байгуулах эрхээ шилжүүлэх нь НЗДТГ-аас уг маягтуудыг баталгаажуулахгүй байх, хариуцлага хүлээхгүй байх үндэслэл болохгүй тухай Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэхийг шаарддаг байна.</p>
6.	<p>Захиалагч болон СЯ нь төсөлд тохирох хяналтын хуудсыг / журмын хавсралт/ хөтөлж, санхүүгийн баримт болгон гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргана.</p> <ul style="list-style-type: none"> • Хавсралт №2: Барилга угсралт, их засварын ажлын хяналтын хуудас 	Хяналтын хуудсыг Захиалагчийн хяналт болон тус төслийн гэрээг байгуулсан байгууллага нь хянан баталгаажуулж ЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтэс эцсийн баталгаажуулалтыг хийн Сангийн яаманд хүргүүлнэ. Эдгээр

	<ul style="list-style-type: none"> • Хавсралт №3: Худалдан авах барилга байгууламжийн санхүүжилтийн хяналтын хуудас • Хавсралт №4: Концессын гэрээний эргэн төлөлтийн хяналтын хуудас • Хавсралт №5: Зөвлөх үйлчилгээний хяналтын хуудас • Хавсралт №6: Тоног төхөөрөмжийн хяналтын хуудас 	хяналтыг хуудсыг мөн Сангийн яамны холбогдох мэргэжилтэн дахин гаргаж баталгаажуулан, асуудал хариуцсан нэгжийн дарга гарын үсэг зурж санхүүжилтийн эрх нээнэ. Уг хяналтын хуудасанд заасан
7.	<p>Захиалагчаас хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийн баримт бичиг нь хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж ажлын 3 хоногийн дотор санхүүжилтийн эрхийг</p> <ul style="list-style-type: none"> • гүйцэтгэгч байгууллагад олгох • захиалагч байгууллагад олгох байдлаар нээнэ. 	Дээрх хянан баталгаажуулсан гүйцэтгэлийн санхүүжилтийн бичиг баримтыг НЗДТГ-н Санхүү төрийн сангийн Хэлтэс Сангийн яаманд ЗД-н албан тоотын хамт хүргүүлнэ. Ирүүлсэн бичиг баримтыг журамд заасан маягт тус бүрээр дахин хянан шаардлага хангаж байгаа тохиолдолд СЯ-ны Төрийн сангийн газарт холбогдох маягтын дагуу эрх нээсэн санхүүжилтийн жагсаалтыг хүргүүлдэг. СЯ-ны Төрийн сангийн газраас ЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтэст гүйцэтгэлийн төлбөр шилжүүлж, эрхийг нээнэ.
8.	<p>СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж санхүүжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт №14-т заасан маягтын дагуу гаргаж, хавсралт №17-ын хамт төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.</p>	СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас СЯ-ны Төрийн сангийн газарт холбогдох маягтын дагуу эрх нээсэн санхүүжилтийн жагсаалтыг баталгаажуулан гүйлгээ хийх дансны хамтаар хүргүүлдэг.
9.	<p>Энэ журмын 8-д заасан жагсаалтад тухайн жилийн төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын нэр, дэс дугаар, захиалагч, гүйцэтгэгчийн нэр, гүйцэтгэгч болон захиалагчийн дансны дугаар, санхүүжих мөнгөн дүнг тэмдэглэсэн байна.</p>	СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас СЯ-ны Төрийн сангийн газарт хүргүүлэх маягтад тусгах мэдээллийг энд заасан бөгөөд ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэг онцлох өөрчлөлт орсон нь Захиалагчаас ирүүлсэн гүйцэтгэлд үндэслэн шууд компанийн дансанд гүйлгээг хийх зохицуулалттай болсон.

10.	СЯ захиалагчаас ирүүлсэн шаардлага хангаагүй баримт бичгийг ажлын 3 хоногийн дотор цахимаар болон албан бичгээр буцаана.	Сангийн яам НЗДТГ-т, НЗДТГ-аас Захиалагч байгууллагад буцаадаг. Буцаах шалтгаан нь хяналтын хуудасанд заасан материалын иж бүрдэл дутуу, эсвэл шаардлага хангаагүй байвал pimis.publicinvestment.gov.mn цахим систем болон албан бичгээр буцаан хүргүүлэх бөгөөд шалтгааныг дурдсан байдаг.
11.	Эрх шилжүүлсэн төслийн хувьд тухайн шийдвэр нь захиалагчийн холбогдох дансанд санхүүжилтийн эрхийг нээх үндэслэл болно.	Эрх шилжүүлсэн захиалагчийн дансанд санхүүжилтийг шилжүүлэх нь гүйцэтгэгч компанид олон байгууллагын гүйлгээг хүлээх, цаг алдахаас сэргийлдэг. Жишээ нь БШУ-ны яамнаас Нийслэлийн Засаг даргад эрхээ шилжүүлсэн бол Нийслэлийн Засаг дарга захиалагч болж, БШУЯ-ны дансаар санхүүжилт дамжих шаардлагагүй юм.
12.	<p>Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:</p> <ul style="list-style-type: none"> • Урьдчилгаа олгох талаар ХАА-ний баримт бичиг болон гэрээнд тусгасан байх; • Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт”-ын дагуу гаргана); • Банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгоход урьдчилгаа төлбөрийн банкны баталгааг банканд байршуулсан эсэх баримтыг санхүүжилт хүсэх баримтад хавсаргасан байх; • ТЕЗ-н улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төслийн урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн жилийн батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас хэтрэхгүй. 	<p>Санхүүжилтийг гүйцэтгэлээр буюу бодит гүйцэтгэлээр олгоно.</p> <p>Харин урьдчилгаа олгох нөхцөлийг Тендерийн баримт бичиг болон талууд гэрээндээ тусгасан байна.</p>
13.	<p>Төслийн гүйцэтгэлд дараах эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурна</p> <ul style="list-style-type: none"> • Захиалагч • захиалагчийг төлөөлж техник хяналт, зохиогчийн хяналт тавьж байгаа • санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцогч. 	Гүйцэтгэлийн бичиг баримтад ялангуяа Барилга угсралт, их засварын ажлын санхүүжилт авах бичиг баримтад зураг төслийг боловсруулсан зохиогч заавал гарын үсэг зурдаг ба үүнийг захиалагчийн хяналтын байгууллага хариуцдаг.

		СЯ-наас гүйцэтгэлд захиалагч болох НЗДТГ-аас эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулж байхыг шаардаж байгаа бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийг зохион байгуулах эрхээ шилжүүлэх нь НЗДТГ-аас гүйцэтгэлийг баталгаажуулахгүй, хариуцлага хүлээхгүй байх үндэслэл болохгүй тухай Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэхийг шаарддаг байна.
14.	Төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой аливаа зохицуулалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.	Тендерийн зохион байгуулж байгаа захиалагч хариуцан гэрээндээ тусгадаг. Гэрээний тусгай нөхцлийн талаар өмнөх бүлэгт дэлгэрэнгүй танилцуулсан.
15.	Төслийн гэрээнд дараах зардлыг нэг бүрчлэн тусгана <ul style="list-style-type: none"> • барилга угсралтын дүн • зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт • зураг төсөл, хайгуулын ажил • барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл • магадалшгүй ажил • нэмэгдсэн өртгийн албан татвар гэх мэт Мөн гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай заалтыг тусгасан байна.	Уг зардлуудыг нэг бүрчлэн тусгах шалтгаан нь дараа нь гүйцэтгэл баталгаажуулахад хяналтын байгууллага болон захиалагчдад хялбар болгох, мөн гэрээний дүнгээс хэтэрсэн магадлашгүй ажил, зохиогчийн хяналт зэргийн зардал гарахаас сэргийлнэ.
16.	Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгын үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадалшгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэг бүрчилсэн төсвийн зардлыг тооцно.	Санхүүжилтийн гүйцэтгэлийн бичиг баримтад санхүүжилт авахаар тусгагдсан бол заавал уг зардлуудын холбогдох баримт, нотолгоог хавсаргах хэрэгтэй бөгөөд Захиалагчийн хяналтын байгууллага шалгаж баталгаажуулаад НЗДТГ-г хүргүүлдэг.
17.	Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажилд зарцуулна. Уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.	Магадалшгүй ажлын санхүүжилтийг олгохдоо Захиалагчийн хяналтын байгууллага хуралдаж журамд заасны дагуу бичиг баримтыг бүрдүүлдэг. Магадалшгүй ажлын хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото

		зураг болон гүйцэтгэлийг заавал гаргах хэрэгтэй.
18.	<p>Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг холбогдох норм дүрмийг үндэслэн олгохдоо</p> <ul style="list-style-type: none"> • төслийн гэрээ • ажлын тайлан • хавсралт №16-д заасан маягтыг бөглөж олгоно. 	<p>Зураг төслийн зохиогчтой Захиалагчийн хяналтын байгууллага тусад нь гэрээ байгуулан журамд заасны дагуу 16-р маягтыг бөглөн баталгаажуулдаг.</p> <p>Мөн Зохиогчийн хяналт хийсэн тайланг гэрээний хамт ирүүлнэ.</p>
19.	Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс хамаарч тогтоосон хугацаанд хөрөнгө оруулалтын төсөл нь санхүүжилт авч чадаагүй бол энэ нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.	Тус шалтгааны улмаас гүйцэтгэгч талд санхүүжилтийг шилжүүлээгүй бол захиалагч талыг гэрээ зөрчсөн гэж үзэхгүй.
20.	Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс ажлын 3 хоногт багтаан төслийг санхүүжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь санхүүжилтийн эрхийг нээхдээ бүртгэгдсэн огнооны дарааллыг баримтална.	Өөрөөр хэлбэл, төсвийн орлого бүрдэхгүй байгаа нөхцөлд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн эрхийг нээхдээ Сангийн яаманд ирсэн дарааллаар буюу хүлээгдэж буй гүйцэтгэлийн жагсаалт бий болгож түүнээс төсвийн орлого бүрдэлтэй уялдуулан ирсэн дарааллаар санхүүжилтийг хийх тухай заалт юм. Харин журмаараа санхүүжилтийн материал иж бүрэн бол ажлын 3 хоног багтаан эрх нээх ёстой. Материал иж бүрдэл дутуу нөхцөлд албан бичгээр мөн хугацаанд буцаана.
21.	Санхүүжилтийн эрх нээснээс хойш ажлын 2 хоногийн дотор СЯ-ны төрийн сангийн нэгж нь гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгоно.	Засгийн газрын тогтоолоор батлагдсан энэ журмын дагуу өмнө нь гарч байсан хүндрэл болох СЯ-наас Захиалагчийн дансанд санхүүжилтийг шилжүүлсэн байхад Захиалагч нь гүйцэтгэгч компанийн дансанд шилжүүлэг хийхгүй удах, гүйцэтгэгч компанийг хүндрүүлэх нөхцөл байдлыг шийдвэрлэж, СЯ-ны Төрийн сангаас шууд гүйцэтгэгч компанийн дансанд шилжүүлж байхаар зохицуулсан.

22.	Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч нь санхүүжилтийн гүйцэтгэлийг цаасаар болон цахимаар баталгаажуулж ирүүлснээр СЯ-ны төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь захиалагчийн данснаас гүйцэтгэгч байгууллага руу санхүүжилтийг олгох эрх олгогдоно.	Өөрөөр хэлбэл, цахим системээр гүйцэтгэл ирүүлэхийг мөн шаардаж байгаа бөгөөд уг системээр гүйцэтгэл баталгаажуулах нь эргээд ил тод, нээлтэй хаана ямар санхүүжилт гацсан, аль шатанд явааг гүйцэтгэгч компани харах боломж зэргийг нээж өгсөн.
23.	Санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу олгосноос гарах аливаа эрсдэл, үр дагаврыг санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж ирүүлсэн захиалагч байгууллага хүлээнэ.	Шинэ журмаар батлагдсан нэг онцлог бөгөөд Сангийн яамны төрийн сан Захиалагч байгууллагын дансаар шууд дамжуулж, гүйцэтгэгч байгууллагын дансанд шилжүүлгийг хийх бөгөөд энэ нь захиалагчийн анх гүйцэтгэл гарган хянан баталгаажуулан ирүүлсэн маягтад үндэслэж буй тул хариуцлагагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй болохыг журамласан заалт юм.
24.	СЯ-ны төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу олгосноор захиалагч байгууллага хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.	Шинэ журмаар батлагдсан нэг онцлог бөгөөд Сангийн яамны төрийн сан Захиалагч байгууллагын дансаар шууд дамжуулж, гүйцэтгэгч байгууллагын дансанд шилжүүлгийг хийх бөгөөд энэ нь захиалагчийн анх гүйцэтгэл гарган хянан баталгаажуулан ирүүлсэн маягтад үндэслэж буй тул хариуцлагагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй болохыг журамласан заалт юм.
25.	Гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэхийг гүйцэтгэлийн материалд хавсаргасан байх, мөн энэ журмын хавсралт №17-д заасан “Санхүүжилтийн төлбөрийн хүсэлтийн маягт”-ыг 2 хувь үйлдэж баталгаажуулан ирүүлнэ.	Энэхүү журамд орсон гол өөрчлөлт болох Сангийн яамнаас шууд гүйцэтгэгчид төлөх төлбөрийн Төрийн санд хийх гүйлгээний баримтыг гүйцэтгэлийн хамт ирүүлэхээр зохицуулалт хийсэн заалт юм.
26.	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийх шалтгаан нөхцөл үүссэн тохиолдолд санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг захиалагч болон СЯ төлөвлөгөө батлагдтал түр хугацаагаар зогсоож,	Өөрөөр хэлбэл, зохицуулалт хийснээр өөрчлөгдөх дүнгээс илүү хэмжээний санхүүжилт гарахаас сэргийлэх зорилготой заалт бөгөөд төсвийн тодотголоор санхүүжилтийг бууруулахаар

	шинэчлэгдсэн төлөвлөгөө батлагдсаны дараа шийдвэрлэнэ.	УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байхад анх байсан өндөр дүнгээрх санхүүжилт гарсан тохиолдол байдаг.
27.	Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төслөөс <ul style="list-style-type: none"> • Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутагт эрх шилжин худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах ажлын жагсаалтыг тушаалаар батална. • Тушаалыг худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөнд хавсарган төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор СЯ-д хүргүүлсэн байна. 	ТЭЗ нь тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлаа тушаал гарган эрхээ шилжүүлэх бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны газар болон аймгуудад эрхээ шилжүүлдэг бөгөөд уг тушаалаа журмын дагуу Сангийн яаманд хүргүүлснээр Сангийн яам хаанаас гүйцэтгэл нь хянагдаж ирэх мэдээлэлтэй болж, санхүүжилтийг хянах процессыг хөнгөвчлөх онцлогтой юм.
28.	Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг даргын төрийн сан дахь хөрөнгө оруулалтын данс төсвийн жилийн эцэст үлдэгдэлгүй байх бөгөөд энэ нь барьцаа хөрөнгийн болон техник хяналтын дансанд хамаарахгүй.	Өөрөөр хэлбэл, Сангийн яамнаас орж ирсэн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид аль болох түргэн шуурхай санхүүжилтийг олгох ёстой бөгөөд жилийн эцэст төрийн сангийн дансандаа байлгаж байгаад эргээд төсвийн орлого болгон татуулах тохиолдол гардаг.
29.	Захиалагч нь батлагдсан маягтын дагуу дараах хяналтын хуудсыг төсөл тус бүрээр бөглөн баталгаажуулж ирнэ. Үүнд <ul style="list-style-type: none"> • барилга байгууламж • их засварын ажил • тоног төхөөрөмж худалдан авах • зөвлөх үйлчилгээ 	Холбогдох хяналтын хуудсын маягт нь уг санхүүжилтийг авахад ямар ямар шаардлага, материал байх ёстойг заасан байдаг тул нэг талаасаа шалгах жагсаалт (check-list) гэж хэлж болох бөгөөд үүнийг анхаарч шалгасан тохиолдолд гүйцэтгэлийн материалыг буцаах магадлал бага юм.
30.	Төслийн эцсийн санхүүжилтийн хүсэлтэд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.	Гэрээ дүгнэсэн маягт ирүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг буцаах шалтгаан болох тул үүнийг анхаарах шаардлагатай.
31.	Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.	Бүрэн дууссаны дараа ашиглагч байгууллагаас тус бичиг баримтыг авч бүрдүүлнэ.
32.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төслийг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно.	Өөрөөр хэлбэл, өмнөх хэрэгжилтийн бүлэгт нарийвчлан авч үзсэн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байвал материалыг буцаах үндэслэл болно. Бодит

		байдал дээр ихэвчлэн гэрээ байгуулах мэдэгдэл олгосноос хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулаагүй байх тохиолдол гардаг.
33.	Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.	Бодит байдал дээр байршил солих, эдийн засгийн ангилал солих зэрэг зөрчил түгээмэл байдаг. Тухайлбал, барилга байгууламж ангилалаас тоног төхөөрөмж авах тохиолдол гарсан байдаг.
34.	Төсвийн орлого бүрдүүлэлтээс хамаарч тогтоосон хугацаанд төсөл нь санхүүжилт авч чадаагүй бол тухайн хугацаагаар төслийн гэрээний хугацааг санхүүжилт орсон өдөр хүртэл хойшлуулан тооцож санхүүжилт гаргана.	Сүүлийн жилүүдэд бий болж байгаа цар тахал, эдийн засгийн хүндрэл зэрэгтэй холбоотойгоор гүйцэтгэлээ гаргаж ирүүлсэн боловч Сангийн яамнаас санхүүжилт хийх боломжгүй, төрийн сангийн үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд уг арга хэмжээг авч ажиллана.
35.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл нь урьдчилсан худалдан авах ажиллагаанд хамаарч буй тохиолдолд гүйцэтгэлийн баримт бичигт уг төслийг баталсан Засгийн газрын тогтоолыг хавсаргаж ирүүлнэ.	Сангийн сайдын 2019 оны 208 тоот тушаалаар Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам батлагдсан байдаг бөгөөд үүнтэй танилцах шаардлагатай юм.
36.	Урьдчилгаа төлбөрийн банкны баталгаа болон барилгын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд СЯ нь санхүүжилтийг зогсоож, энэ талаар арга хэмжээ авхуулахаар асуудлыг захиалагч болон холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.	Урьдчилгаа төлбөр, банкны баталгааг Захиалагч тухайн гаргасан арилжааны банкнаас лавлаж, шалгах ёстой бөгөөд хэрэв хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол үүнийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх шаардлагатай юм.
Дөрөв.Төсөл, арга хэмжээний санхүүжилт,гүйцэтгэлийн баримт бичиг		
4.2. Барилга байгууламжийн ажлын санхүүжилт		
4.2.1.	Барилга байгууламжийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт нь Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байна.	Захиалагчийн хяналтын байгууллага бүрэн хариуцна
4.2.2.	Барилга байгууламжийн ажил нь барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах дараах баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна. <ul style="list-style-type: none"> • техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг 	Барилгын тухай хууль болон журмын дагуу эдгээр иж бүрдлийг хангаж байж ажил эхэлж, санхүүжилт авах боломжтой болно.

	<ul style="list-style-type: none"> • барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл • инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг орно. 	
4.2.3.	Эрх бүхий даргын гарын үсгээр хянан баталгаажуулсан захиалагчийн барилга байгууламжийн ажлын санхүүжилт хүсэл, холбогдох материалыг албан бичиг болон цахим системээр дамжуулан СЯ-ны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.	Гүйцэтгэгч-Захиалагч–НЗДТГ-н Санхүү төрийн сангийн хэлтэс - СЯ-ны ТХОГ- СЯ-ны Төрийн сан гэсэн дарааллаар явуулж байна.
4.2.4.	Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана	Захиалагч гэрээнд заасан ажлын үе шатны төлөвлөгөөний дагуу явж байгаа эсэхэд хяналт тавихад уг заалтыг ашигладаг.
4.2.5.	СЯ-д ирүүлэх гүйцэтгэлийн баримт бичгийг хавсралт №7-д заасан “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга угсралтын ажлын санхүүжилтийн хүсэлтийн маягт”-ийн дагуу санхүүжилтийн хүсэлтийг баталгаажуулж ирүүлнэ.	Нийслэлийн хувьд өмнө дурдсанчлан зөвхөн НХОГ-аар баталгаажин ирж байгаа гүйцэтгэлийг баталгаажуулахад НЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтан байхгүй байгаатай холбоотой СЯ-наас шаардлага тавьж байгаа.
4.2.6.	Захиалагч нь төслийн эцсийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлэхдээ барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.	Комисс ажилласан шийдвэр дүгнэлтийг баталгаажсаны дараа комиссын актад гишүүд бүрэн гарын үсэг зурж баталгаажуулан эх хувийг СЯ-д ирүүлдэг. Олонхи санхүүжилтэд хуулбар хувийг ирүүлж материалыг буцаах тохиолдол гардаг.
4.2.7.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж хянан баталгаажуулж, холбогдох баримт бичгийг энэ журмын хавсралт №2, №3 дахь хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг дараах баримт бичгийг үндэслэн санхүүжүүлнэ: <ul style="list-style-type: none"> • гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан бичиг, үнэлгээний хорооны шийдвэр; • Захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь 	Шаардлагатай бүрдэл материалыг Захиалагчийн хяналтын байгууллага нь бүрдүүлэн хянан шалгаж, баталгаажуулан НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, санхүү төрийн сангийн хэлтэс хянан баталгаажуулж СЯ-д хүргүүлнэ. Эдгээр матераилыг хэзээ, ямар гүйцэтгэлд гаргаж ирүүлэх шаарлагатай өмнө нь нэг бүрчлэн харуулсан Хүснэгт 22-ыг дэлгэрүүлж харахыг зөвлөж байна.

	<ul style="list-style-type: none"> • Тендер шалгаруулалтад шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх дүнгээр тодорхойлсон барилгын ажлын үе шатны хуваарь (энэ журмын хавсралт №9-д заасан маягтын дагуу гаргана); • Гүйцэтгэлийн баталгаа • Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл (энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана); • Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг нотлох гэрэл зураг (10-аас ихгүй байх); • Магадалшгүй ажлын зардлын барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон акт, хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл; • Зураг төсөл боловсруулах гэрээ, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналтын тухайн төсөл дээр байгуулсан гэрээний хуулбар, хийсэн ажлын тайлан; • Барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын актыг үйлдэж, комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана; • Захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын ил далд ажлын акт; • Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудаст тендер шалгаруулалтын мэдээллийг бүрэн оруулсан байх. 	
4.2.8.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах төслийн санхүүжилтийг хавсралт №3-т заасан хяналтын хуудсыг хөтөлж олгоно.	Сүүлийн жилүүдэд хувийн хэвшил, эсвэл Орон сууцны хорооллын сургууль, цэцэрлэг, нийгмийн үйчилгээний барилга байгууламжийг төсвийн хөрөнгөөр худалдан авч төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлага гарч байгаа бөгөөд мэдээж өмнө нь баригдсан бэлэн барилга, байгууламжийг худалдан авахад хяналтын хуудас

		өөр маягтаар бөглөгдөх шаардлагатай болсо тул уг хавсралтыг журамд шинээр оруулсан болно.
4.2.9.	Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацааг Барилгын тухай хуулийн 14.6-д, авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4-т заасныг баримтлах бөгөөд баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна.	Барилгын тухай хуулийн дагуу туршилт тохируулгын хугацаа 1 жил, хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил, Авто замын тухай хуулийн дагуу 3 жил тус тус байна.
4.3. Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилт		
4.3.1.	Захиалагч их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана.	Захиалагчийн хяналтын байгууллага бүрэн хариуцаж хянаж баталгаажуулж дараагийн шатны байгууллагад хүргүүлнэ.
4.3.2.	Захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.	Өөрөөр хэлбэл, Барилга байгууламжийг Улсын комисс хүлээн авдагтай ижлээр их засварын ажлыг холбогдох комисс байгуулан мөн хүлээж авах тухай заалт юм.
4.3.3.	Их засварын ажлыг хийж дуусаад комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана.	Санхүүжилтийн материалыг цаасаар хүргүүлэхдээ уг бичиг, баримтыг хавсаргана.
4.3.4.	Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, хавсралт №11-д заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.	Тоног төхөөрөмжийн хувьд их засвар, барилга байгууламжийн ажлаас ялгаатай нь бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг шалгах шаардлагата байдаг.
4.3.5.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь тоног төхөөрөмжийн санхүүжилтийг олгоходоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн хавсралт №6-д	Өөрөөр хэлбэл СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын асуудал хариуцсан мэргэжилтэнд хамаарах заалт бөгөөд Тоног төхөөрөмжийн хяналтын хуудас их засвар, барилга байгууламжийн

	заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.	ажлын санхүүжилтээс ялгаатай байдаг.
4.3.6.	Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд уг журмын 4.1 болон 4.2 дугаар зүйлд заасан холбогдох зохицуулалт мөн адил үйлчилнэ.	Санхүүжилтийн ерөнхий зохицуулалтын заалтууд мөн адил үйлчилнэ.
4.4.Зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилт		
4.	<p>Зөвлөх үйлчилгээний ажлыг холбогдох хуульд зааснаар тодорхойлох бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ТЭЗУС болон ТЭЗҮ-д дараах ажлууд хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> • ТЭЗУС-ны хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, зорилт, хүрэх үр дүн, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг урьдчилсан байдлаар тоймлон судлах, хэрэгжих боломжийг тоймлон тогтоох судалгааны ажил болон холбогдох тайланг боловсруулах; • ТЭЗҮ боловсруулах ажилд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг эрэлт хэрэгцээ, нөөц боломж, техник-технологи, эдийн засаг, хууль, эрх зүй, үйл ажиллагаа болон цаг хугацааны хувьд хэрэгжих боломжийг судлан тогтоох, тухайн төслийн үр дүн болон үр ашгийг тодорхойлох, гарч болзошгүй эрсдэл, зардлуудыг тодорхойлох судалгааны ажил болон холбогдох тайланг бэлтгэх 	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ТЭЗУС болон ТЭЗҮ-д заавал орох шаардлагатай асуудлыг тусгаснаараа эргээд уг төслийг Улсын төсөвт дараа онуудад батлуулж хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг урьдчилан бэлтгэхэд бэлтгэх зорилготой юм.
4.4.2.	Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх шилжүүлснээр хэрэгжүүлж буй төслийн ажилд шаардлагатай зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэж, зөвлөхийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар сонгон шалгаруулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг сонгож, гэрээ байгуулна	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг холбогдох чиг үүргийн байгууллагууд боловсруулж батлуулдаг. Зөвлөх үйлчилгээг хэрхэн сонгон шалгаруулах тухай дэлгэрэнгүй өмнөх бүлэгт авч үзсэн болно.
4.4.3.	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.	Өөрөөр хэлбэл, гэрээнд тусгагдаагүй боловч ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг зөвлөх заавал хийж гүйцэтгэхийг шаардах эрхийг Захиалагчид олгох заалт юм. Учир нь бодит байдал дээр ажлын даалгаварт заасан боловч гэрээ байгуулах үед орхигдсон ажлыг

		зөвлөх үйлчилгээний хүрээнд хийхгүй үлдээх асуудал гардаг.
4.4.4.	Зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна.	Зөвлөх үйлчилгээний үнэ боддог БХБЯ-ны холбогдох аргачлал байдаг.
4.4.5.	Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дагуу ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж ажиллана.	Захиалагч хариуцна
4.4.6.	Зөвлөх үйлчилгээний зардлыг олгох санхүүжилтийн баримт бичигт гэрээний эх хувь, зохиогчийн хяналтын зардал өгөх тохиолдолд зохиогчийн хяналтын гэрээ, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөв тус бүрийн эх хувь, эсхүл хуулбар, хүлээн авсан акт заавал хавсаргана.	Журмын дагуу захиалагч бүрдүүлнэ.
4.4.7.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн хавсралт №5-д заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.	Өөрөөр хэлбэл СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын асуудал хариуцсан мэргэжилтэнд хамаарах заалт бөгөөд Зөвлөх үйлчилгээний хяналтын хуудас тоног төхөөрөмж, их засвар, барилга байгууламжийн ажлын санхүүжилтээс ялгаатай байдаг.

Бид энэхүү бүлэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрхэн хийж байгаа, ямар материал, баримт бичгийг хэзээ, аль шатны гүйцэтгэлд гаргах, мөн шинээр батлагдсан журмын гол зүйл заалтыг хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хэрэг болох байдлаар тайлбарлаж оруулав.

Энд заавал дурдах ёстой нэг асуудал бол журамд байнга дурдагдаж байгаа цахим систем (<https://pimis.publicinvesment.gov.mn>)-д гүйцэтгэлийг хэрхэн илгээх асуудлыг СЯ-наас алхам бүрээр гаргасан гарын авлага тусдаа байдаг тул оруулаагүй болно.

7.2 Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилт

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь батлагдсан төсөвт нийцүүлэн төсөл, арга хэмжээний тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөг зээл, тусламжийн цахим систем (<https://odamis.mof.gov.mn/>)-д оруулна.

Зээл, тусламжийн гэрээнд ХАА-ны талаар тусгайлан заагаагүй эсхүл хөгжлийн түншийн журам, заавраар зохицуулаагүй тохиолдолд ХАА-г Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангана гэдгийг өмнө дурдсан.

Зээл, тусламжийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийг олгодог.

Иймд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн тухай өгүүлсэн өмнөх хэсэгт заасан бүрдүүлэх материал, хянах процесс нь ижил тул энд дахин дурдах шаардлагагүй билээ. Харин төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хувьд батлагдсан хуваарийн дагуу цахимаар удирдан зохион байгуулдаг бөгөөд дараах зохицуулалтыг хэрэгжүүлэхээр журамлагдсан байна. Үүнд:

1. Зээл, тусламжийн төслийг хэрэгжүүлэгч байгууллагын ТЕЗ нь тухайн жилийн төсвийн санхүүжилтийн хуваарийн саналыг СЯ-д 12 дугаар сарын 25-ны дотор албан бичгээр болон цахимаар ирүүлж, төсвийн хуваарьт нэгтгүүлнэ.
2. Төсвийн санхүүжилтийн хуваарьт төсөл арга хэмжээ бүр нь эдийн засгийн ангиллаараа, урсгал, хөрөнгө, эргэн төлөгдөх зээлээс санхүүжих зардлаар тусгагдаж, Сангийн сайдын тушаалаар дараа оны 1 дүгээр сарын 01-ний дотор батлагдсанаар төслийн санхүүжилтийг олгох боломж бүрдэнэ.
3. Санхүүжилтийн хуваарьт шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах боломжтой байхаар зохицуулагдсан бөгөөд дараа сарын санхүүжилтийн хуваарийн өөрчлөлтийн саналыг өмнөх сарын 25-ны өдрийн дотор СЯ-д албан бичгээр болон цахимаар ирүүлж, тухайн сарын сүүлийн өдөрт багтаан өөрчлөлтийг тусгана.
4. Энэхүү батлагдсан санхүүжилтийн хуваарь нь зээл, тусламжийн цахим системд байршсанаар төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага жилийн турш бүрэн хянах, удирдах боломжтой. СЯ-ны хувьд санхүүжилтээ цахимаар гаргах, хянах, баталгаажуулах бүх шат нь цахимаар хэрэгждэг байна.
5. Цахим системд хандах эрхийг СЯ-наас төсөл хэрэгжүүлэгч байгууллага, хөгжлийн түнш, төслийн захирал, төслийн зохицуулагчид өгнө.

Төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үеийн ханш болон зээл, тусламжийг хөгжлийн түнш орноос хүлээн авах хугацаа хоорондоо зөрүүтэй байх тохиолдол байдаг. Иймд ханшны тохируулгыг сар бүрийн 2-ны өдрийн дотор хийж зээл, тусламжийн ашиглалтын тооцоо болон жилийн эцсийн тайлангийн шатанд тооцоо нийлж тайлагнана. Төсөл, арга хэмжээний гадаад валютын гүйлгээг төгрөг рүү хөрвүүлэн тайлагнахдаа зээл, тусламжийг хүлээн авсан өдрийн өмнөх өдрийн Монголбанкны хаалтын ханшийг ашигладаг болно. Энэ нь жилийн эцэст зээл, тусламжийн ашиглалтын тооцоо нийлэх акт болон төслийн тайлангаар баталгааждаг байна.

Зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төслийн үр ашигтай байдлыг хангах нэг нөхцөл нь хяналт-шинжилгээ бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсны дараа төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөл, арга хэмжээний анхан шатны буюу суурь үнэлгээг

хийж, төсөл, арга хэмжээ хэрэгжиж эхлэх үеийн нөхцөл байдлыг үнэлдэг. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, байнгын дотоод хяналт тавьж, Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад, цаашлаад харьяалах ТЕЗ-д тайлагнаж байх үүргийг хүлээдэг. ТЕЗ нь салбарын хэмжээнд зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэн 1 дүгээр сарын 25-ны дотор СЯ-д албан бичгээр болон цахимаар тайлагнах бөгөөд тус тайлангийн нэгтгэл Засгийн газарт жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хүргэгддэг байна.

Мөн төсвийн ил тод байдлыг хангах үүргийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу оруулахаар журамлагдсан ба энэ мэдээлэл нь зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг олгох тухай бүрд хавсаргагдаж явна.

7.3 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн санхүүжилт


Концессын гэрээний дагуу төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсхүл төлбөр төлөх бол Төсвийн тухай хуульд заасны дагуу уг дэмжлэг, төлбөрийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулсан байх ёстой. Харин улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахад уг гэрээ нь Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувьд нөлөөлөх тул Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагын дагуу СЯ-наас гэрээ байгуулахаас өмнө зөвшөөрөл авсан байх ёстой.

Төрөөс дараах төрлийн санхүүгийн дэмжлэгийг концесс эзэмшигчид үзүүлж болно. Үүнд:

1. зээлийн баталгаа гаргах;
2. концессын санхүүжилтийн тодорхой хэсгийг гаргах;
3. татварын болон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
4. даатгалд хамруулах;
5. концесс эзэмшигчийн концессын гэрээний дагуу олох орлогын хамгийн доод хэмжээнд баталгаа гаргах;
6. концессын гэрээнд заасан бол нөхөх олговор олгох зэрэг бөгөөд эдгээр санхүүгийн дэмжлэгээс гадна “Барих-Шилжүүлэх” төслийн эргэн төлөлтийн санхүүжилтийг улсын төсвөөс хийж байна.

Монгол Улсад анх 2016 оноос эхлэн төсвийн тухай хуулийн холбогдох хавсралтаар эргэн төлөх нөхцөлтэй “Барих-Шилжүүлэх” төрлийн концессын гэрээний эргэн төлөлтийг тусгаж, санхүүжилтийг хийж эхэлсэн бөгөөд гүйцэтгэл нь дараах байдалтай байна.

Зураг 29. “Барих-Шилжүүлэх” төрлийн концессын гэрээний эргэн төлөлт /тэрбум ₮/



Нийт 1.05 их наяд төгрөгийг 2016 оноос хойш Концессын төслийн эргэн төлөлтөд төлсөн байгаа бөгөөд гэрээний дагуу барьж ашиглалтад оруулсан ажлын санхүүжилтийг төсвийн тухай хуулиар батлуулж, санхүүжүүлж байгаа тул жил бүр гүйцэтгэл 95 хувиас дээш гарч байна.

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар эргэн төлөлт нь батлагдсан Концессын гэрээний санхүүжилтийг хийхдээ концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төслийн санхүүжилттэй холбогдон гарсан хууль, эрх зүйн акт, УИХ, Засгийн газар болон холбогдох байгууллагын шийдвэрт үндэслэн санхүүжүүлнэ. Тухайлбал, “Барих-шилжүүлэх” концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн билээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хүрээнд батлагдсан холбогдох журмын дагуу санхүүжүүлж байна. Уг журамд зааснаар Концессын гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний төлбөрийг гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлэх бөгөөд бодит гүйцэтгэл нь гэрээний үнийн дүнгээс бага бол эргэн төлөлтийг бодит гүйцэтгэлээр санхүүжүүлдэг. Гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийх, гүйцэтгэлийг хянан баталгаажуулахад ЭЗХЯ-тай гэрээ байгуулсан Барилгын хөгжлийн төвийн холбогдох хяналтын инженер, удирдах албан тушаалтнууд, мөн ЭЗХЯ-ын Концессын асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдлага оролцдог. ЭЗХЯ нь концессын эргэн төлөлттэй холбогдолтой санхүүгийн болон бусад холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулж, тухайн санхүүжилтийн дүнг тусгасан албан бичгээр болон цахим системээр дамжуулан СЯ-д хүргүүлнэ.

СЯ нь Концессын гэрээний эргэн төлөлтийн санхүүжилтийг шийдвэрлэхэд дор дурдсан баримт бичгийн иж бүрдлийг хянадаг тул эдгээр материалыг заавал ирүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Концессын тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-аар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр дүгнэлт, хурлын тэмдэглэл;
2. Захиалагчийн зүгээс концессын гэрээнд заасан уг гэрээг хүчин төгөлдөрт тооцох нөхцөлүүд хангагдсан эсэх талаарх дүгнэлт;
3. Концессын гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан гэрээний талууд гэрээг эцэслэн дүгнэсэн дүгнэлт;
4. Концессын гэрээнд өөрчлөлт оруулсан бол гэрээний нэмэлт, өөрчлөлт болон эргэн төлөлтийн хуваарийг дараа онуудад шилжих дүнг төгрөгөөр илэрхийлсэн баримт;
5. Санхүүжилттэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн дагуу хөндлөнгийн байгууллагын дүгнэлт, зөвлөмж болон тухайн төсөлтэй холбогдон гарсан дүгнэлт, зөвлөмжийн дагуу шаардлагатай баримт бичиг;
6. Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын хуулбар;
7. Захиалагч болон концесс эзэмшигчийн хооронд байгуулсан концессын гэрээний эх хувь, эсвэл захиалагч байгууллага хянаж, нотариатаар баталгаажуулсан концессын гэрээний хуулбар хувь байж болно;
8. Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл, гэрээнд багтсан санхүүгийн бусад зардал нэг бүрээр концесс эзэмшигчтэй тооцоо нийлсэн акт;
9. Барилга, байгууламж, засварын ажил, тоног төхөөрөмжийн гэрэл зураг;
10. ТЭЗҮ, зураг төсөл болон төсөв, техник хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээний хуулбар, захиалагчийн хяналтын гэрээ дүгнэсэн дүгнэлт;
11. Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт;
12. Төсвийн шууд захирагчийн хянан баталгаажуулсан санхүүжилтийн дүнтэй албан бичиг;
13. Магадалшгүй ажлын акт, төсөв, гүйцэтгэл, баримтжуулсан фото зураг, хурлын тэмдэглэл зэрэг болно. Эдгээр баримт бичгийн бүрдлийн үнэн зөв эсэхийг захиалагч буюу төсвийн захирагч бүрэн хариуцдаг.

СЯ-ны Төсвийн хөрөнгө оруулалтын газар нь концессын гэрээний эргэн төлөлтийг олгохдоо заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн санхүүжилтийн эрхийг нээнэ. ЭЗХЯ нь концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төслийг холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэж, санхүүгийн тайландаа тусгах ёстой байдаг.

Нийслэлийн Концессын төслийн санхүүжилтэд мөн улсын төсвөөс санхүүжүүлэхэд шаардаж байгаа бичиг баримтын бүрдлийг адилхан шаардан авч санхүүжилтийг хийх талаар Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс анхаарах

хэрэгтэй. Нийслэлийн ИТХ-аар батлагдан хэрэгжиж буй концессын төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсвэл эргэн төлөлтийн санхүүжилтийг хийх тусдаа журам, аргачлал одоогоор байхгүй байгаа тул Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмыг баримталж ажиллах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН АУДИТЫН ХЯНАЛТ, ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

8.1 Хөндлөнгийн хяналт, аудитын шалгалт

Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байх ба түүний бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг Төрийн аудитын тухай хуулиар зохицуулдаг.

МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын байгууллага нь Үндэсний аудитын газар ба энэ нь аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар болон түүний албан хаагчдаас бүрдэнэ. Төрийн аудитын байгууллагыг Монгол Улсын Ерөнхий аудитор удирдана.

Энэ утгаараа аудит нь улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй аливаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн хяналт хийдэг бөгөөд УИХ-ын Төсвийн байнгын хороогоор батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх аудитын сэдвийн дагуу ажилладаг.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит гэсэн төрлөөр аудит хийх бөгөөд аудит хийхдээ хөрөнгө оруулалтыг давхар авч үздэг. Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит, хөрөнгө оруулалтад гүйцэтгэлийн аудитыг тус тус хийдэг. Санхүүгийн тайлангийн аудит, хөрөнгө оруулалтын аудитыг заасан цаглабарын дагуу хийж тайлагнадаг бөгөөд жил бүрийн 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гүйцэтгэж Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон Улсын төсвийн нэгдсэн гүйцэтгэлийн тайлангуудын хамтаар УИХ-д өргөн барьдаг.

Санхүүгийн тайлангийн аудит


Санхүүгийн аудит нь шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулна.

Шалгагдагч этгээд

Төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээд болон тэдгээрийн холбогдох албан тушаалтныг ойлгоно.

Төрийн санхүүгийн тайлангийн аудитын цаглабарыг дараах зурагт үзүүлэв.

Зураг 30. Төрийн санхүүгийн тайлангийн аудитын цаглабар



Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, орон нутгийн төсвийн жилийн төсвийн гүйцэтгэл, ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабарын дагуу боловсруулж төрийн аудитын байгууллагад хүргүүлэн, аудитлагдсан санхүүгийн тайланг дээд шатны төсөв захирагчид хүргүүлнэ.

Хүснэгт 25. Аудит хийхэд оролцогч талуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацаа

Оролцогч	Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацаа	Аудит хийсэн санхүүгийн тайланг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэх хугацаа
Төсвийн шууд захирагч	Дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор	02 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн захирагчид
Төсвийн төвлөрүүлэн захирагч	Дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор	3 дугаар сарын 25-ны өдрийн дотор ТЕЗ-д
Сум, дүүргийн төрийн сан	Дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор	3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны ТЕЗ-д
Аймаг, нийслэлийн ТЕЗ-д	Дараа оны 4 дүгээр сарын 01-ний дотор	4 дүгээр сарын 20-ны дотор СЯ-д
Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	Дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор	3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах ТЕЗ болон СЯ-д
ТЕЗ	Дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор	4 дүгээр сарын 25-ны дотор СЯ-д
Сангийн сайд	Дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор	5 дугаар сарын 5-ны дотор санал дүгнэлт гаргана.


СЯ нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх бөгөөд Төрийн аудитын байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, УИХ-д хүргүүлнэ.

Засгийн газар аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын долоон өдрийн дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт УИХ-д өргөн мэдүүлж, тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батална.

Гүйцэтгэлийн аудит

Төрийн аудитын байгууллага нь шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ. Мөн шалгагдагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт нь үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.


Гүйцэтгэлийн аудитын сэдвийн хүрээнд хуулийн дагуу гүйцэтгэх аудитыг дор үзүүлэв.



Нийцлийн аудит

Шалгагдагч этгээд нь үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд нийцлийн аудит хийнэ. Мөн төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийнэ.

Нийцлийн аудитын сэдвийн хүрээнд хуулийн дагуу гүйцэтгэх аудитыг дор үзүүлэв.



Дээрх 3 төрлийн аудит дотроос гүйцэтгэлийн аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг голчлон шалгадаг.

8.2 Хөрөнгийн удирдлага

Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үед ашиглалт болон насжилтыг уртасгах зорилгоор хийгддэг засвар үйлчилгээний хөтөлбөр (үйл ажиллагаа) нь томоохон үүрэгтэй. Ихэнх тохиолдолд өнгөрсөн хугацааны тоон болон баримтын мэдээлэл дээр үндэслэн үүнийг хэрэгжүүлдэг. Бага үнэд суурилсан хөрөнгийн засвар үйлчилгээний хөтөлбөрийн шийдвэр нь тухайн хөрөнгийн ашиглалтанд суурилсан хувийн хэвшлийн шийдвэрээс харьцангуй сул чанарыг бий болгоно. Ахисан түвшний болон сайжруулсан технологи, загвар дизайн сайжруулалт хийх нь хууль дүрмийн өнөөгийн зохицуулалт, үйл ажиллагааны цикл, асуудал шийдвэрлэх процедур, системийн хүнд суртал зэргээс хамаарч хийхэд түвэгтэй байдаг.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж, санхүүжүүлж, ашиглалтад оруулсны дараагаар уг хөрөнгийг тухайн орон нутаг, улс, нийслэлийн өмчид шилжүүлж, бүртгэлжүүлдэг. Энэхүү хөрөнгийн удирдлагын асуудлыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид ч мэдэж байх шаардлагатай болдог.

Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой үйл ажиллагааны цар хүрээтэй нь уялдуулан одоо мөрдөгдөж байгаа хууль дүрэм, журмын тайлбаруудыг товч авч үзье.

Хүснэгт 26. Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой дүрэм, журмын тайлбарууд

Хууль, журмын нэр	Хөрөнгийн эзэмших эрх нээгдэх, худалдан авалт	Хөрөнгө захиран зарцуулах	Хөрөнгө ашиглалт, хамгаалалт	Хөрөнгө шилжүүлэх, ашиглалтаас хасах
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	++	++	++	++
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	+++	+	-	-
Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам ⁹	+++	++	+	+++
Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам ¹⁰	++	+++	-	+++

Тайлбар: (-) агуулгын зүйл заалт байхгүй, ... (+++) агуулгын зүйл заалт маш тодорхой орсон.

Эдгээр дөрвөн хууль, журмын талаар товч танилцуулья.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Төрийн өмчийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хамгийн гол эрх зүйн баримт бичиг нь Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хууль юм.

Хуулийн зорилт:

Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг

⁹ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журам

¹⁰ Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 66-р тогтоолоор батлагдсан журам

хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хүснэгт 27. Төрийн өмчийн харилцааны субъектүүдийн эрх

Субъект	Бүрэн эрх
УИХ	<ul style="list-style-type: none"> - Ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна - Барьцаалах, шилжүүлэх шийдвэр гаргах - Нийгэмчлэх шийдвэр гаргах
Засгийн газар	<ul style="list-style-type: none"> - Төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангах - Худалдах, шилжүүлэх шийдвэр гаргах - Нэгдсэн тооллого зохион байгуулах - Төрийн өмчит ААН ба бусад төрийн өмчийн талаарх менежментийг хэрэгжүүлэх
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллага	<ul style="list-style-type: none"> - Эзэмших, ашиглах, хамгаалах, мөн сайжруулах ажлыг зохион байгуулах - Бүртгэл, тооллого, тайлан тэнцэл, хяналт, үр ашгийг дээшлүүлэх функц хариуцах - Хувьчлах ажлыг зохион байгуулах - Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах
Төрийн өмчийн талаарх яам, тусгай газар	<ul style="list-style-type: none"> - Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит ААН-ийг мэргэжлийн удирдлагаар хангах - Захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт зэрэг асуудлаар санал оруулах

Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах:

Төрийн өмчийн эд хөрөнгийг олж авах:

- Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, СЯ-аар зардлын дээд хязгаарыг батлуулна.
- Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах ба төрөөс түүнд хариу төлбөргүйгээр олгож болно.
- Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна.

Эд хөрөнгийн үнэлэх, бүртгэх

- Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох журам дүрмийн дагуу бүртгэнэ.

- Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.
- Эд хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах заавар, журмыг СЯ гаргана.

Төрийн өмчийг шинээр бүртгэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ¹¹. Үүнд:

а/ хуулийн этгээдийн эрх барих болон харьяа дээд байгууллагын зөвшөөрөл;

б/ худалдан авах эх үүсвэр санхүүжилтийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуваарилагдсан төсөв;

в/ хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт;

г/ мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;

д/ эдийн засгийн тооцоо, үндэслэл;

е/ худалдах, худалдан авах, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал;

ё/ балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн зөвшөөрөл, хүсэлт;

ж/ үл хөдлөх хөрөнгийн хувьд хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ;

з/ бусад шаардлагатай баримт, материал (үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг ангиллаас хамаарсан холбогдох баримт бичгүүд) зэрэг болно.

Эзэмших, ашиглах:

- Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.
- Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессоор эзэмшүүлэх, ашиглуулах, концессын гэрээний үндсэн дээр шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна
- Төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг Улсын Их Хурал, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно
- Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.

¹¹ Төрийн өмчийн хорооны 2012 оны 44-р тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”

- Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана.
- Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан эрх /тэргүүн ээлжинд худалдан авах/ эдлүүлэх эсэхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.
- Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

Худалдах

- Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.

Үнэ төлбөргүй шилжүүлэх

- Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү УИХ шийдвэрлэнэ.
- Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.

Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах

- Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.
- Эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна.
- Хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална:
 - худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх;
 - илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;

- засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;
- ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх;
- осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах.

Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах

- Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дараах аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ:
 - дуудлагаар худалдах;
 - уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/;
 - төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах;
 - төрийн өмчит хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах;
 - татан буулгаж эд хөрөнгийг хувьчлах;
 - менежментийн үр дүнг харгалзан хувьчлах;
 - давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах.
 - төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хувьчлах.

Төрийн өмчийн тодорхой эд хөрөнгийг энэ зүйлд заасан аль аргаар хувьчлахыг Засгийн газраас баталсан хувьчлах хөрөнгийн жагсаалтад урьдчилан заах бөгөөд түүний дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

Хяналт шалгалтын тогтолцоо

- УИХ, Засгийн газраас ерөнхий хяналт
- Төрийн хянан шалгах хороо, СЯ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллагаас мэргэжлийн хяналт, шалгалт
- Хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалт
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллагын хөндлөнгийн магадлан шалгалт
- Эрх бүхий байгууллагууд тус тусын эрхлэх ажлын хүрээнд өмч хамгаалах асуудлаар төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалалтад санхүүгийн гэнэтийн сонгон шалгалт зэрэг нь багтдаг.

Эд хөрөнгийн тооллого

- Тооллогын бэлтгэл хангах

- Тооллогын комисс томилох, эрх үүргийг танилцуулах
- Эд хөрөнгийн тооллого явуулах гэсэн дарааллаар хийгдэнэ.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Хуулийн зорилт:

Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулийн дэлгэрэнгүй тайлбар, мэдээллийг энэхүү гарын авлагын хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт бүлэг буюу 6 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан тул энд орхив.

3. Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам

Энэ журамд төрийн өмчид эд хөрөнгө олж авах болон түүний бүртгэлийн үеийн бичиг баримтын бүрдүүлбэрийг тухайн хөрөнгийн төрөл бүрээр задлан тайлбарласан байна. Мөн бусдаас ялгаатай зүйл заалт нь хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох харилцааг тодорхой болгож хөрөнгийн зохистой менежментийг хэрэгжүүлэхэд түлхэц болох заалтуудыг оруулжээ. Дээрх харилцаануудаас гадна хөрөнгийг актлах, данснаас хасах шийдвэрийг хэрэгжүүлэх тайлагнах асуудлуудыг цэгцлэн оруулсан байна.

4. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам

Энэ журамд нийслэлийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэлд тусгах, эзэмшилдээ байгаа эд хөрөнгийг шилжүүлэх болон ашиглалтаас хасах үеийн харилцааг бүрэн гүйцэт оруулсан. Тухайн үйл ажиллагаа бүрт бүрдүүлэх бичиг баримтууд, түүний дагалдах тооцоолол зэргийг харьяа газар, хэлтэс хүргүүлэх тухай нарийвчлан тусгажээ. Иймд нийслэлийн холбогдох мэргэжилтэн, албан хаагчид уг журмыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн хөрөнгийн удирдлагад авч үзэх нэг асуудал бол ашиглалт болон насжилтыг уртасгах засвар үйлчилгээний зардал юм. Өнгөрсөн хугацаанд ихэнх тохиолдолд хангалттай хэмжээний зардал, арчилгааны зардал тусган батлагдаггүйн улмаас хөрөнгийн ашиглалт, насжилт богиносох, нэмэлт зардал гарах тохиолдолууд нэлээд байдаг. Тухайлбал, жил бүр батлагддаг зам арчлалтын зардал хангалттай хэмжээнд хүрдэггүй тул замын эвдрэл, гэмтэлээс үүдэлтэй аваар, осол гарах нь элбэг. Иймд шаардлагатай засвар, арчилгааны зардлыг зөв тооцож, төсөвтөө оруулах хэрэгтэй.

Ашиглалт арчилгааны зардал тооцох

Орон нутгийн засаг захиргаадад өмч хөрөнгөтэй холбоотой гарах жилийн ашиглалт, арчлалтын зардлыг тооцоолох, тухайн өмч хөрөнгийн нөхцөл байдлын үе шатаас шалтгаалан эдгээр зардлыг хэрхэн өөрчлөж, тодруулбал зүйтэй талаар авч үзье.

Хотын захиргааны одоо ашиглагдаж байгаа болон ирээдүйд төлөвлөсөн хөрөнгийн ашиглалт, арчилгааны зардлын ирээдүйн өртгийг тооцоход ашиглагддаг нийтлэг хэдэн аргууд бий. Үүнд:

- Зөвхөн тойм, урьдчилсан төлөвлөлтөд зориулсан тооцоо шаардлагатай бол жилийн ашиглалт, арчлалтын зардлын өртгийг тооцоходоо суурь болгон уг хөрөнгийн төсөвт өртөгт эзлэх хувийг ашиглах нийтлэг арга байдаг. Энэ арга нь хөрөнгийн ашиглалт арчилгааны зардлыг тооцоолох боломжтой бусад аргуудаас алдаатай байх магадлал хамгийн өндөртэй нь юм. Урьдчилсан төлөвлөлтөд ихэвчлэн ашигладаг.
- Хотын захиргааны ижил төрлийн байгууламжтай холбоотой өмнөх жилүүдийн зардалд тулгуурлан тооцоолол хийж болно /харьцуулалтын арга гэсэн үг/. Энэ аргын хувьд одоо ашиглагдаж байгаа хөрөнгөнд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт хийхэд зориулан гарсан ижил төстэй зардлыг тодорхойлох, ижил төстэй сургууль, цэцэрлэгт гарсан кэйсийг дүгнэж тооцоо гаргах хэрэгтэй.
- Тухайн хөрөнгийн ашиглалт арчилгааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж, засвар үйлчилгээ, ашиглалтын үйл ажиллагааны таамаглалдаа суурилан нарийвчилсан төсөв гаргах арга бий. Ерөнхийдөө тухайн хөрөнгийн инженерчлэл болон бүтэц, орчин нөхцөл, ашиглалт ба элэгдэл, байршлын онцлог байдал зэргээс хамаарч үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөнд суурилсан аргачлал юм.

Ашиглалт арчилгааны зардал тооцоход дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Хөрөнгийн удирдлагын суурь үзүүлэлт болох анхны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын чанар, стандарт хангасан байдал нь маш чухал үзүүлэлт бөгөөд анх хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авахдаа уг асуудлыг хянаж шалгах нь эргээд хөрөнгийн ашиглалт, насжилттай холбоотой гарах засвар, арчилгааны зардлыг бууруулах боломжтой.
- Урт болон дунд хугацааны графикайн дагуу засвар үйлчилгээ, ашиглалт арчилгааны төлөвлөгөөг гаргаж, түүнийхээ дагуу ямар нэгэн улс төрийн шийдвэр нөлөөгүйгээр санхүүжилтийг батлуулан гүйцэтгэх нь маш чухал юм.
- Ашиглалт сайтай барилга, байгууламжид хөрөнгийн удирдлагын стратеги боловсруулахад тухайн орчин нөхцөл, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаас хамаарч хувьсан өөрчлөгдөх боломжтой. Иймд ашиглалт арчилгааны зардлыг үүнтэй уялдуулан цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад дүрэм журмын дагуу хөрөнгийн удирдлага дэх засвар

үйлчилгээг хийлгэхдээ ихэвчлэн хамгийн бага үнэд суурилан сонгон шалгаруулалтаа хийдэг. Нөгөө талаас уг ХАА нь чанарын шаардлагыг хангаж чадах уу гэдгийг бас харгалзаж үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэгчийн санал болгосон бага үнээр шаардаж буй чанарыг хангуулах хэрэгтэй болдог. Засвар үйлчилгээний чанартай байдал /ихэвчлэн хөрөнгийн насжилт/ нь тухайн хөрөнгийг ашиглаж буй менежерийн хариуцлага болж, байгууллагын хөрөнгө болж үлддэг. Гэхдээ гэрээний эрх зүй талаасаа хөрөнгийг бий болгосон, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлыг шилжүүлснээс хойш ямар ч хариуцлага ноогддоггүй тохиолдол бий.

Элэгдлийн зардал тооцох¹²

Барилгын элэгдлийн зардлыг тооцох нь уг барилга, байгууламжид ашиглалт, насжилтаас бий болох эрсдэлээс сэргийлэх гол хүчин зүйл юм. Тухайлбал, Эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын шугамын модон тулгуурын элэгдлийг буруу тооцсоноос үүдэлтэйгээр элэгдэж муудсан шугамын шон унах, хүний амь насанд аюул учруулах тохиолдлууд гардаг. Иймд хөрөнгийн удирдлагын нэг гол асуудал бол засвар, арчлалт хийхээс гадна элэгдлийг зөв тооцож, арчлалт засвар хийх боломжгүй хөрөнгийг акталж, шинэчлэх асуудал юм.

Элэгдлийг тооцохдоо:

- Тухайн барилгын зориулалт (Олон нийтийнх, орон сууц, үйлдвэрийн барилга, аж ахуйн аргаар баригдсан барилга, жижиг барилга г.м)
- Ханын зузаан (510 мм зузаан хүртэл, 640 мм зузаантай г.м)
- Даацын хийц, бүтээц (төмөр бетон арагт бүтээц, угсармал төмөр бетон, холимог бүтээц, тоосго, даацын өрөгт болон модон холимог бүтээц, сэндвич г.м)
- Байгалийн зарим хүчин зүйлсийн нөлөөллийн итгэлцүүр
- Инженерийн шугам сүлжээний холбогдлын итгэлцүүрээр (ердийн пийшин халаалт, хагас холбогдсон буюу нам даралтын зуухтай, бүрэн холбогдсон г.м) тооцдог.

Мөн барилгаас гадна төрийн өмчид хамаарах газрыг байршил, ашиглалт зориулалтаар нь, инженерийн шугам сүлжээ, зам, замын байгууламж зориулалт, хийц, ачаалал даах чадвар зэргээр нь ангилан элэгдэл тооцдог. Машин тоног төхөөрөмжийн хувьд зориулалт, тухайн хөрөнгийн өөрийн физик шинж чанар, хөдөлгөөнт эсэх зэргээр нь нарийвчлан ялгаж ашиглалтын хугацааг гаргаж, элэгдлийн хувийг тооцдог журамтай.

¹² Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (2018). *Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээний гарын авлага*, УБ хот

Өмчийн бүртгэл ба хөдөлгөөн

Одоогоор төрийн өмчийн хөдөлгөөн, бүртгэл хөтлөлтийг Acolus програм хангамж дээр хөтөлж байна. Төрийн өмчийн улирал тутам хөтлөн шинэчлэх ёстой үндсэн мэдээлэл нь:

- Хөрөнгийн нэр, марк, код
- Хариуцах субъект (байгууллага, хэлтэс)
- Гол холбогдох хүний мэдээлэл (төсөв эзэмшигч, нягтлан бодогч, нярав г.м)
- Хөрөнгийн нийт үнэ
- Зарлагын тооцоо /үе шат
- Элэгдлийн тооцоо /хугацаа
- Төсвийн жил /улирал

Тайлагналт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан мэдээ тайлангийн маягтуудын тусламжтайгаар төрийн өмчит хөрөнгийн хөдөлгөөн, насжилт, ашиглалтын байдал, ангилал зэргийг зорилтот бүлэг байдлаар гаргаж авдаг. Тус газрын www.pcsp.gov.mn сайт болон холбогдох алба, хэлтэст хүргүүлсэн хүсэлтийн дагуу бүртгэл хөдөлгөөний маягт, мэдээ тайлангийн форматуудыг хүлээн авах боломжтой.

Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 66-р тогтоолоор батлагдсан журамд зааснаар эд хөрөнгө шинээр олж авах, шилжилт хөдөлгөөн хийх, данснаас хасч актлах зэрэг үе шат бүрт бөглөдөг маягт, бүрдүүлдэг бичиг баримтыг нарийвчлан тусгаж оруулсан байгаа юм.

Төрийн хөрөнгийг үнэгүйдэх, эзэнгүйдэх, шамшигдуулан алга болгохоос урьдчилан сэргийлэх, шат шатны хөрөнгө эзэмшигчдийн хувьд эзний ёсоор хандаж арчилж тордох нь хөрөнгийн зохистой удирдлагын мөн чанар юм.

Тодорхойлолт

Төрийн хөрөнгийн удирдлага нь нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчийг арчлах, үр дүнтэй ашиглахад чиглэсэн бүх үйл ажиллагааг хэлдэг. Үүнд төрийн өмчит байгууллагуудын худалдан авах төлөвлөгөө болон хөрөнгийг бүртгэх, хадгалах, сайжруулах, захиран зарцуулах үйл ажиллагааг бүхэлд нь хамруулдаг.

Хөрөнгийн төрлүүд:

- Шугаман дэд бүтэц /Авто зам, гүүр, явган хүний зам, усны систем, туннель г.м/
- Барилга байгууламж /Парк, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цагдаа, цэргийн анги, онцгой байдал, засгийн газар, ариун цэврийн байгууламж, зарим газруудын сайжруулалт г.м/

- Механизм /Замын хөдөлгөөний хяналтын систем, онгоцны буудал ба түүний бүтээн байгуулалтууд, эрчим хүчний сүлжээний бүтээн байгуулалт, онцгой байдлын дуут дохио г.м/
- Батлан хамгаалах хэрэгсэл /цэрэг арми, цагдаагийн хэрэгсэл, зэвсэг техник г.м/
- Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл /мөн тавилга хэрэгсэл орно/
- Мэдээлэл технологийн систем /Дата төв, шилэн кабель, сатилайт харилцаа холбоо/ зэрэг нь хөрөнгөд хамаарна.

Хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны санхүүжилтийн ихэнх хэсгийг татварын орлого, үлдсэн багахан хэсгийг зарим үйл ажиллагааны орлогоос бүрдүүлдэг. Бүрдүүлсэн санхүүжилтийн зарцуулалт нь холбогдох дүрэм журмын хүрээнд зохицуулагдана.

Дүгнээд хэлэхэд хөрөнгийн удирдлага нь зөвхөн хөрөнгө хүлээн авах, хөрөнгө оруулалт хийх төдий зүйл биш, харин төрийн мэдлийн өмч хөрөнгийг арчлах, үр дүнтэй ашиглах бүхий л үе шатыг хамруулан ойлгох хэрэгтэй. Иймд тухайн хөрөнгийн үнэ цэнэ, ашиг орлого, зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлийн мэдлэгийг хариуцсан албан хаагчдад түлхүү олгож байх нь чухал юм.

БҮЛЭГ 9. НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нийслэлийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнүүдийн урьдчилсан үр ашгийг тооцдоггүй, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулдаггүй, төслийн гол шаардлага болох зураг, төсөвгүй, газаргүй, техникийн нөхцөл олгогдоогүй төсөл, арга хэмжээ батлагдах тохиолдол байсаар байна. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад урьдчилсан тооцоо, судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв хийгээгүйгээс болж хийгдэж байгаа ажлын үр ашиг, өгөөжийг тооцох боломжгүйд хүрдэг. Олон улсад төлөвлөлтийн үе шатанд баримталдаг зарчим бол төсөл, арга хэмжээ тус бүрт техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, тухайн төслийн үр ашгийг өнөөгийн үнэ цэнээр тооцон, холбогдох судалгааг 1-2 жилийн хугацаанд хийж, бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хот төлөвлөлтийн цогц төлөвлөгөөнд тулгуурлан хөрөнгө оруулалтыг батлах шийдвэр гаргадаг.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хариуцаж байгаа гол нэгж нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг үнэлж, сонгодог боловч одоогоор жил бүрийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг үнэлэх, сонгох тогтсон аргачлал байхгүй, үнэлгээ, дүн шинжилгээ болон хувилбаруудад харьцуулалт хийх боломжгүйгээр төсөвт хөрөнгө баталж байна.

Тухайн жилийн төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахын өмнө орон нутгийн Аудитын байгууллагаас дүгнэлт хийж ИТХ-д танилцуулдаг. Жил бүрийн Аудитын дүгнэлтээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж буй хөрөнгө оруулалтын ажлууд үр ашиггүй, судалгаа, төлөвлөлтгүй, зураг төсөв, газаргүй ажлууд батлагдсан, хууль дүрэм, журам зөрчсөн талаар танилцуулдаг ч хариуцлага тооцдоггүй, аудитын дүгнэлтийг хэрэгжүүлж ажилладаггүй байдал байсаар байна.

Цаашид нийслэлийн хувьд энэхүү гарын авлагад авч үзсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналттай холбоотой олон тооны хууль, журмыг нэгтгэж “Нийслэлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тайлагнах нэгдсэн журам”-тай болж, уг журмыг НИТХ-ын тогтоолоор батлуулан мөрдвөл хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдад нэг л журмыг ашиглахад илүү хялбар болох юм. Гэвч энэхүү гарын авлагад олон тооны хууль, журмын гол заалт, хэрэглээг нэгтгэсэн байдлаар танилцуулсан тул Нийслэлийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдад хэрэглэхэд дөхөм болно хэмээн найдаж байна. Түүнчлэн, Нийслэлд хийгдэх аливаа шинэчлэл нь Сангийн яамны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн цахим системтэй уялдах шаардлагатай бөгөөд иймэрхүү системийг Нийслэлд хөгжүүлэх боломжтой юм. Ингэхдээ уг системд өгөгдлийн сан, дата бий болгож, төсөл, арга хэмжээний түүхийг бүртгэн, цаашид төлөвлөлтөд ашигладаг болохуйцаар шийдвэрлэх хэрэгтэй юм.

Нийслэлийн хувьд хөрөнгө оруулалттай холбоотой журмыг боловсруулахдаа хөрөнгө оруулалтын бүх төсөл (нийслэлийн төсөв, замын сан, ТХХТ)-ийг Нийслэлд 2018 онд туршиж байсан Дэлхийн банкны үнэлгээ, аргачлалыг сайжруулах замаар үнэлэх, сонгох аргачлал нэвтрүүлж, төслийг үнэлж, эрэмбэлээгүй тохиодолд НИТХ-аар батлагддаггүй байх цахим систем болон журмын зохицуулалтыг оруулж, бүх хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан албан хаагчдад хэрхэн ашиглах талаар сургалт явуулах хэрэгтэй. Мөн төлөвлөлтийг аль болох жилийн эхнээс хангалттай эрт хугацаанд эхлүүлэх шаардлага үүсч байгаа бөгөөд тухайлбал хороо, дүүргээс санал боловсруулж, аргачлалын дагуу боловсруулан дараагийн дээд шатны байгууллагад хүргүүлэхэд хамгийн багадаа 2 хүртэлх сарын хугацааг олгох нь зүйтэй юм.

Түүнчлэн, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хэрэгтэй хамгийн гол зүйл бол өмнөх жилүүдийн мэдээлэл, өгөгдөл байдаг. Гэтэл Нийслэлд тулгамдаж буй нэг асуудал бол Нийслэлийн бүх шатны байгууллагын өнгөрсөн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, түүнээс бий болсон хөрөнгө, барилга байгууламжийн талаарх мэдээллийг агуулсан нэгдсэн систем, өгөгдлийн сан байхгүй байна. Энэ нь цаашид ямар хэмжээний арчлалт, засвар үйлчилгээний зардал шаардлагатай болох, тэрийг ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх зэргийг төлөвлөхөд хүндрэл учруулах болно.

Харин Нийслэлийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 25-ний А/859 захирамжаар Нийслэлийн Боловсролын салбарын барилга, байгууламжийн их засварын төсөл арга хэмжээг төлөвлөх аргачлалыг¹³ баталж 2021 оноос мөрдөж эхэлсэн. Нийслэлийн боловсролын салбарын (сургууль, цэцэрлэг) барилга, байгууламжийн их засварын бүртгэлийн системийг¹⁴ бий болгосон. Ингэснээр барилга, байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах, их засварыг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэхэд хяналт тавих, мэдээллийг хадгалах боломж бүрдсэн. Цаашид үүнийг өргөжүүлж өгөгдөлийн нэгдсэн системтэй болж, улмаар журмын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийдэг аргачлалыг нэвтрүүлсэн нэгдсэн систем болгон өргөжүүлэх ажлыг хийх боломжтой юм.

Түүнээс гадна энэхүү гарын авлагыг боловсруулж буй “Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх” төслийн гол зорилго болох эрчим хүчний үр ашгийг Нийслэлийн хэмжээнд хийгдэж буй барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын ажлуудын хүрээнд сайжруулах арга хэмжээг авах шаардлага бий болж байна. Үүнийг мөн нэгдсэн журам боловсруулахад холбогдох заалтаар тусган баталгаажуулж өгөх боломжтой. Энэ хүрээнд аливаа барилга байгууламжийн төлөвлөлтийн үед хамгийн эхэнд боловсруулдаг “Зургийн даалгавар”-т эрчим хүчний хэмнэлттэй холбоотой доорх заалтуудын тусгахыг зөвлөж байна. Үүнд:

¹³ https://tamga.ulaanbaatar.mn/Files2/A859_20200625054350.docx

¹⁴ www.brs.ulaanbaatar.mn

1. Барилгын нэгж талбайд ноогдох халаалтын эрчим хүчний жилийн хэрэглээг 200 кВт*цаг/м²–аас ихгүй байлгах
2. Барилга бүрт “Эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ”-нд тусгагдах өгөгдөл, мэдээллийг үүсгэх
3. Орон сууц ба олон нийтийн барилгын эрчим хүчний хэмнэлтийн ангилал “С”-ээс дээш байх
4. Барилгын зураг төсөлд “Эрчим хүчний үр ашгийн магадлал” хийлгэх
 - Агаар сэлгэлтийн нэмэлт шаардлагууд өгч болно. Жишээ нь: агаар сэлгэлтэд ашиглах төхөөрөмжийн төрөл, эрчим хүчний зарцуулалт, дуу чимээ зэрэгт тавигдах шаардлага гэх мэт.
 - Зургийн даалгавар боловсруулахдаа нарийвчилсан тооцоо хийхийг шаарддаг тул тухайн нэмэлт тооцооллын төсвийг зургийн үнэд шингээх.
5. Барилгын засварын ажил хийх нөхцөлд “Зургийн даалгавар”-т
 - Зураг төслийн өмнө “Эрчим хүчний үнэлгээ” хийх,
 - Хийгдсэн үнэлгээний үндсэн дээр шаардлагатай арга хэмжээг зураг төсөлд тусгахыг заах ба зохиогдсон зураг нь энэхүү шаардлагыг хангасан эсэхийг магадлан итгэмжлэгдсэн этгээд шалгах шаардлагатай.
6. Хөрөнгө оруулалтад шаардлагатай төсөвлөлтийг зөв тооцох
 - Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж шинээр барих, засвар үйлчилгээ хийх, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг тооцоолоход шинэ технологиос гадна асуудлыг цогцоор нь шийдэх хэрэгцээ гардаг. Хэдийгээр эхлэлтийн хөрөнгө оруулалт өндөр байдаг ч урт хугацаанд урсгал зардлыг бууруулах замаар төсөвт өртгөө нөхдөг. Гэхдээ энэ төрлийн судалгаа тооцоо, жишиг өртгийг тооцох аргачлал байхгүй байгаа нь төсөвт суулгахад хүндрэл учруулах талтай.
 - Хөрөнгө оруулалтын болон урсгал зардлаас гадна эрчим хүчний хэмнэлттэй зургийн даалгавар боловсруулах, магадлан хийх, эрчим хүчний аудит хийх зэрэг зөвлөх үйлчилгээний зардлыг бас төсвийн саналд суулгах хэрэгтэй.

Мөн цаашид Сангийн сайдын тушаал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох журмуудад Нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудад эрчим хүчний хэмнэлтийн асуудлын талаарх зүйл, заалт нэмэх байдлаар зохицуулах ажлыг НЗДТГ-ын ХБТХ-ээс санаачлан ажил хэрэг болгох хэрэгтэй юм. Тухайлбал, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан холбогдох журмын 2.1.2.1. “төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх” заалтыг “төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх, Нийслэлд хэрэгжих барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээний хувьд эрчим хүчний хэмнэлттэй холбоотой шалгуурыг хангуулах” гэж өөрчлөх саналыг Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэх боломжтой юм.

Дээр дурдсан шинэ журамтай болж, өгөгдлийн сантай болохоос гадна нийтлэг байдлаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтыг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр дараах гол зүйлсийг анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

Хүснэгт 28. Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах санал, зөвлөмж, хэрэгжүүлэх арга зам, хариуцах эзэн

№	Санал, зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн
1	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний саналыг үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлт бүхий аргачлал, арга зүй бүхий журмыг улсын төсвийн төсөвлөлт, цахим системтэй уялдуулан боловсруулж мөрдүүлэх, өгөгдлийн сан, дата, мэдээллийн баазтай болох зүйл заалттай байх. Энэхүү аргачлал бүхий журмыг ИТХ-аар батлуулах	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
20	Хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн цахим сантай болох тус мэдээллийн сангийн мэдээлэлд тулгуурлан хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнадаг байх ¹⁵	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
2	Батлагдсан зураг төсөвгүй, холбогдох зөвшөөрөлгүй, ялангуяа газрын асуудал нь шийдэгдээгүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг НИТХ-аас цаашид батлахгүй байх талаар анхаарах	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
3	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад олон нийтийн оролцоог хангах, иргэдийг мэдээллээр тогтмол хангаж байх, тухайн дүүрэгт хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд иргэдийн саналыг авч, шаардлагатай тохиолдолд иргэдээр хэлэлцүүлж, эрэмбэлүүлэх, хөрөнгө оруулалтын төсөв хэлэлцэх үйл явцад иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж, төсвийн хөрөнгө оруулалтын ил тод байдлыг хангах	Төлөвлөлтийн эхний шатанд мэдээллийг иргэдэд хорооны түвшинд ил тод хүргэх, хурлыг зохион байгуулах	Хороо, дүүргийн хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид, Засаг дарга нар
4	Нийслэлд хийгдэх улсын төсөв, гадаадын зээл тусламж, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтыг зохицуулах үүднээс хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд	Холбогдох журамд өөрчлөлт оруулах саналаа боловсруулан СЯ-нд хүргүүлэх	НЗДТГ

¹⁵ Ашиглалтад орсон хугацаанаас хойш 30 жилийн хугацаанд их засвар нэг ч удаа хийгээгүй цэцэрлэг байхад жил бүр засвар хийдэг цэцэрлэг ч бий. Түүнчлэн, дараа жил нь буулгаж барих цэцэрлэгт засвар хийх зэргээр төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах тохиолдлууд гарахаа болих болно.

№	Санал, зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн
	Нийслэлээс албан ёсоор дүгнэлт өгч, санал оруулах эрхтэй болох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал гаргах		
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг улсын хөрөнгө оруулалт, томоохон хувийн бүтээн байгуулалтыг дэмжих, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, тордох, хэвийн ажиллагааг хангахад түлхүү чиглүүлэхэд анхаарах	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр шиг Нийслэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулан УХОХ-тэй уялдуулах замаар хийх боломжтой	НЗДТГ-ХБТХ, НИТХ
6	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд урсгал зардлыг тооцох, их засвар, сэргээн босголтын ажлыг шинэ хөрөнгө оруулалтаас тусад нь авч үзэх, түүний онцлогт тохирсон үнэлэх, эрэмбэлэх аргачлал, арга зүй боловсруулах	Нэгдсэн журмаар журамлаж, шинээр баригдах барилга, байгууламжийн цаашид гарах урсгал зардал, их засварын зардлыг тооцох зайлшгүй шаардлага үүснэ	НЗДТГ-ХБТХ, НХОГ
7	Иргэдийн төлөөлөгчдөөс хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөвлөлтөд нөлөөлөхгүй байх. Эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
8	Хөрөнгө оруулалтын төсөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтэд оролцож буй ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх	Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах нь хамгийн чухал бөгөөд мэргэшсэн албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллуулахад анхаарах, чадавхжуулах	Тухайн шатны байгууллагын удирдлага
9	Жил бүрийн ҮАГ-ын гүйцэтгэлийн аудитад нийслэлд хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй ТАХ-г хамруулах	ҮАГ-ийн аудитын сэдэв, удирдамжид тусгах саналаа хүргүүлэх	НЗДТГ

№	Санал, зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн
10	Барилга байгууламжид хяналт тавихад зарим нэг барилга байгууламжийн болон мэргэжлийн хяналтын норм дүрэм, зураг төсвийн норм стандарт, онцгой байдлын норм дүрмүүд өөр хоорондоо зөрчилдөж ажил гацахад хүрдэг. Хоорондоо зөрчилдөж байгаа эдгээр норм дүрмийн талаар судалгаа хийж хуучирсан норм дүрмийг шинэчлэх, хооронд нь уялдуулах, магадлалыг чанаржуулах, хариуцлага тооцдог болох	Хяналт хийж буй мэргэжлийн байгууллагуудад санал хүргүүлж ажлын хэсэг байгуулан, хяналтын инженер, техникийн ажилтнуудын саналыг авч, судалгаа хийх	НХОГ, Захиалагчийн хяналт тавьж буй мэргэжлийн байгууллага
11	СЯ-наас боловсруулсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмууд батлагдсан нь сайшаалтай боловч одоогоор улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудад мөрдөж эхэлж байна. Эдгээр журмуудын дагуу цахим системээр дамжуулан дараа жилийн хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөж байгаа ч журмыг мөрдүүлэхэд цаг хугацаа хэрэгтэй, хүний нөөцийг сургах, мэргэшүүлэх шаардлагатай зэрэг бэрхшээлүүд гарч байгаа учраас шууд орон нутгийн төсвийн төлөвлөлтийн үе шатанд мөрдөж ажиллахад хүндрэлтэй, цаг хугацаа шаардахаар байна.	Төлөвлөлтийг аль болох жилийн эхнээс хангалттай хугацаатайгаар эхлүүлэх шаардлага үүсч байна. Тухайлбал хороо, дүүргээс аргачлалын дагуу санал боловсруулан дараагийн шатны байгууллагад хүргүүлэхэд хамгийн багадаа 2 хүртэлх сарын хугацааг олгох	НЗДТГ
12	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгуулахаар ирүүлдэг саналууд ихэнх хувь нь хэрэгцээ шаардлагын шинжилгээг хийгээгүй, тодорхой судалгаанд үндэслээгүй байдаг. Судалгаа хийхэд цаг хугацаа, хөрөнгө зардаггүй. Олон улсад хөрөнгө оруулалтын төслүүдийн судалгаанд хамгийн их хугацааг зарцуулдаг /1-2 жил/. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын шинжилгээг салбар бүрээр хийх, тодорхойлох хялбар аргачлал гарын авлага боловсруулж мөрдүүлэх.	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ

№	Санал, зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн
13	Хотын хамгийн их төсвийн хөрөнгө оруулалт хийгддэг боловсрол, эрүүл мэндийн салбарт шинээр баригдах барилга, байгууламжийн төлөвлөгөөг байршил, хүчин чадал нэг бүрээр нарийвчлан тооцож, үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, эрчим хүчний үр ашгийн шаардлагыг төлөвлөгөөнд тусгах	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
14	Нийслэлийн байгууллагууд төсвийн хөрөнгө оруулалтын саналыг зөвхөн өөрсдийн хэрэгцээ шаардлагаар тодорхойлж 'хүслийн жагсаалт' төдий гаргадаг. Судалгаа шинжилгээ хангалтгүй хийгддэг тул нийт саналын төсөвт өртөг нь боломжит санхүүжилтээс хэт өндөр гардаг. Нийслэлийн жил бүрийн төсвийн төсөлд тусгуулахаар ирүүлсэн хөрөнгө оруулалтын саналуудын ихэнх хувь нь Төсвийн тухай хуульд заасан үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй судалгаагүй, батлагдсан зураг төсөвгүй, газаргүй ажлууд байдгийг байгууллага, дүүрэг, салбарын түвшинд нягталж дээд шатны байгууллагад хүргүүлэхгүй байх	Улсын төсөв, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэх төслийн үр ашиг, үнэлгээ, эрэмбэлэлт, шалгуур үзүүлэлтүүдийг хангах нь хамгийн чухал тул үүнийг шаардаж хийлгэх, хийгээгүй нөхцөлд хүлээн авахгүй байх	НЗДТГ-ХБТХ
15	Нийслэлийн хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалтын саналын нэгтгэлийг НЗДТГ-ын ХБТХ-ийн цөөн мэргэжилтэн хариуцан ажилладаг нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа бөгөөд бие даасан газар, агентлаг болгож өргөжүүлэх. Түүнчлэн санал өгөх эрхтэй бүх газруудаас давхардсан саналууд маш олон ирдэг. Жишээ нь: сургууль бариулах саналыг хороо, дүүрэг, боловсролын газар, тухайн дүүрэг хорооны нийслэл, дүүргийн төлөөлөгчөөс ирүүлдэг ба саналыг эх үүсвэр бүрээр ангилах, шалгах, нягтлах холбогдох байгууллагад хэвлэмэл болон цахимаар хүргүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.	Цахим систем нэвтрүүлснээр ажлын ачааллыг бууруулах, төслүүдийн давхардлыг арилгах, мөн төслийн судалгаа, үнэлгээг цахимаар хийснээр ил тод, нээлттэй үнэлэх, сонгох, эрэмбэлэх боломж бүрдэнэ	НЗДТГ

№	Санал, зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах эзэн
16	Хөрөнгө оруулалтын судалгаа төлөвлөлтийн үе шатанд оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгож журамлах, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, мэдээллээр хангах, мэдээлэл солилцох ажиллагааг цахимжуулж хөнгөвчлөх	НИТХ-ын тогтоолоор журам батлуулж, уг журамдаа энэхүү асуудлыг тусгах	НИТХ, НЗДТГ
17	Зураг төсөв боловсруулахад жил бүр тодорхой хувиар хөрөнгө баталдаг байх. Судалгаанд үндэслэн эрэмбэлсэн ажлуудын зураг төсвийг түрүүлж боловсруулдаг байх. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зураг төсөв боловсруулах ажлуудыг тусгайлан оруулж газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын төсвийн төсөлтэй нягт уялдуулж боловсруулах	Уг арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтад авч хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд дараа онуудад хэрэгжүүлэх төслүүдийн зураг төсөвт тухайн онд төсөв батлах ажлыг зохион байгуулах	НИТХ, НЗДТГ